"АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"

НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

АГУУЛГА:

1. **Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны жилийн ажлын тайлан.**

   1.1. Төслийн товч танилцуулга
   1.2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны жилийн ажлын тайлан
   А. Төслийн удирдах хорооны хуралдааны тухай
   Б. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны тухай
   - Үйл ажиллагаа
   - Сургалт
   - Томилгоо
   - Томилолт
   - Төслийн 2024 оны үйл ажиллагааны батлагдсан төлөвлөгөө
   - Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

   1.3. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны худалдан авах ажиллагааны тайлан, гүйцэтгэл
   1.4. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэл
   1.5. Төслийн 2024 оны үйл ажиллагааны хяналт- шинжилгээ, үнэлгээний тайлан
   1.6. Inception mission буюу Төслийн эхлэлийн томилолтын хүрээнд хийгдсэн Харилцан ойлголцлын санамж бичиг

2. **Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөний тухай**

   2.1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
   2.2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
   2.3. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны санхүүгийн төлөвлөгөө

3. **Хөтөлбөрийн 2 болон 3 дугаар үе шатны төслийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай**

4. **Тогтоолын төслүүд**

БАТЛАВ.
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ДАРГА И.БАТХҮҮ

"АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"-ИЙН ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ХУРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 7.10.8.2 дахь заалтыг үндэслэн Төслийн удирдах хорооны хурлыг 2024 оны 12 дугаар сарын ..... -ны өдрийн ..... цагт Эдийн засаг, хөгжлийн яамны хурлын танхимд зохион байгуулна.

Хэлэлцэх асуудлууд:

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Танилцуулах	Шийдвэрийн хэлбэр
1	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан, худалдан авах ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулга	20 минут	Төслийн зохицуулагч Н.Тэгшбаяр	ТУХ-ны зөвлөмж
2	Төслийн 2024 оны ХШҮ-ний тайлангийн танилцуулга	10 минут	ХШҮ-ний ажилтан Б.Даваажав	
3	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө батлах тухай	15 минут	Төслийн зохицуулагч Н.Тэгшбаяр	ТУХ-ны тогтоол
4	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний биелэлт, хугацааг сунгах тухай	10 минут	Төслийн зохицуулагч Н.Тэгшбаяр	ТУХ-ны зөвлөмж
5	Хөтөлбөрийн 2 болон 3 дугаар үе шатны төслийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай	15 минут	Төслийн зохицуулагч Н.Тэгшбаяр	ТУХ-ны зөвлөмж

Хянасан:
Төслийн захирал Ж.Өнөржаргал

Боловсруулсан:
Төслийн зохицуулагч Н.Тэгшбаяр

Хэлэлцэх асуудал-1

“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн 2024 оны жилийн ажлын тайлан

1.1. Төслийн товч танилцуулга
1.2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 Үйл ажиллагааны тайлан
1.3. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны Худалдан авах ажиллагааны тайлан
1.4. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны Санхүүгийн тайлан
1.5. Төслийн 2024 оны үйл ажиллагааны Хяналт- шинжилгээ, үнэлгээний тайлан

1. АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР ТӨСЛИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

1.1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:

Хөтөлбөрийн зорилго:

"Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр" нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, хүн ам амьдрахад таатай хот, суурин газар (аймаг, сумын төв)-ыг байгуулж, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх, орон нутгийн ногоон хөгжлийн загвар, шинэчлэлийг хөхиүлэн дэмжих, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлэх зорилготой болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага:

Уг хөтөлбөр нь "Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичгийн хүрээнд Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, "Ковид-19" цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх, ногоон хөгжлийг дэмжих зорилтуудтай нийцсэн.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан чиглэлүүд болон хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдаж байна. Тус хөтөлбөр нь хүнсний нийлүүлэлтийн сүлжээ, тогтолцоо, хүнсний аюулгүй байдлыг хангах, хот хөдөөгийн уялдаа холбоог дэмжих, аймаг, сумын төвүүдэд хүн амьдрахад таатай орчныг бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох ногоон, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх үндэс болох юм.

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: Эдийн засаг, хөгжлийн яам.

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.

Хэрэгжих хугацаа: Уг төсөл нь 3 үе шаттай хэрэгжинэ. Үүнд:

- Төслийн 1 дүгээр үе шат нь 2024-2026 он
- Төслийн 2 дугаар үе шат нь 2027-2028 он
- Төслийн 3 дугаа үе шат нь 2029-2034 онуудад тус тус хэрэгжинэ.

Хөтөлбөр хэрэгжих байршил:

Энэхүү хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих инженерийн дэд бүтэц, тээвэр логистикийн төвийг байгуулах, хөдөө аж ахуйн салбарт оруулах ногоон санхүүжилтийг дэмжиж (тухайлбал: ногоон зээл, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл), хөдөө аж ахуйн менежментийг сайжруулан, түүнийг хянах тогтолцоог бүрдүүлнэ. Дээрх төлөвлөж буй арга хэмжээг 17 аймгийн 52 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

№	Аймгийн нэр	Хамрах сумууд				Нийт
		1	2	3	4	
1	Архангай	Эрдэнэбулган	Эрдэнэ-мандал	Хотонт	Тариат	4
2	Булган	Булган	Хутаг-өндөр	Дашинчилэн	Хишиг-Өндөр	4
3	Дорнод	Хэрлэн	Халхгол	Баян-Уул	Дашбалбар	4
4	Сэлэнгэ	Сүхбаатар	Ерөө	Сайхан	Мандал	4
5	Төв	Зуунмод	Баянчандмань	Лүн	Угтаалтцайдам	4
6	Хэнтий	Хэрлэн	Батноров	Бор-Өндөр	Биндэр	4
7	Ховд	Жаргалант	Булган	Дарви	Манхан	4
8	Увс	Улаангом	Давст	Өмнөговь	Наранбулаг	4
9	Хөвсгөл	Мөрөн	Хатгал	Тариалан		3
10	Говь-Алтай	Есөнбулаг	Цогт	Баян-уул		3
11	Баян-Өлгий	Өлгий	Дэлүүн			2
12	Дундговь	Сайнцагаан	Эрдэнэдалай			2
13	Дархан-Уул	Дархан	Орхон			2
14	Өвөрхангай	Арвайхээр	Есөнзүйл			2
15	Баянхонгор	Баянхонгор	Бууцагаан			2
16	Завхан	Улиастай	Тосонцэнгэл			2
17	Дорноговь	Сайншанд	Замын-Үүд			2
Нийт	**17 аймаг**	**52 сум**				**52**

Хөтөлбөрийн I үе шатыг Ховд, Баян-Өлгий, Увс аймгууд болон хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийгдэх судалгаанд үндэслэн, бэлэн байдал хангасан 8 нэмэлт аймагт буюу нийт 11 аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Хөтөлбөр нь нийт 10 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд дунд хугацааны бодлогын баримт бичигтэй бүрэн нийцсэн ба урт хугацааны бодлогын баримт бичгийн арга хэмжээг хэрэгжүүлэх суурь нөхцөл нь болно.

Төсөвт өртөг /төслийн 1, 2, 3 дугаар үе шатны хүрээнд/:

Хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк (АХБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС) болон Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)-ны нэн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Төслийн 1, 2, 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт санхүүжилт 735.0 сая ам.доллар байх ба дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Энгийн болон хөнгөлөлттэй зээл нийт 550 сая ам.доллар /Үүнд: АХБ-ны 270,0 сая ам.доллар, Уур амьсгалын ногоон сангийн 130,0 сая ам.доллар, Европын хөрөнгө оруулалтын банкны 150,0 сая ам.доллар/;
2. Буцалтгүй тусламж нийт 78.0 сая ам.доллар /Үүнд АХБ-ны 3,0 сая ам.доллар, Уур амьсгалын ногоон сангийн 45,0 сая ам.доллар, Европын хөрөнгө оруулалтын банкны 30,0 сая ам.доллар/;
3. Засгийн газрын оролцоо 75.3 сая ам.доллар /Үүнд: Бүтээн байгуулалтын ажилтай холбоотой НӨАТ, гаалийн албан таварын чөлөөлөлт, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардал/;
4. Хувийн хэвшил, банкны салбар болон бусад төсөлд оролцогч талуудын санхүүжилт 31.7 сая ам.доллар /Үүнд: Төслийн хүрээнд үр шим хүртэх малчдын бүлэг, аж ахуй нэгж, олон нийтийн зүгээс хувь нэмэр оруулах

хөдөлмөр, эд материал болон мөнгөн хөрөнгө оруулалтыг хамруулан тооцсон/.

Хөтөлбөрийн 1 дүгээр үе шат буюу 2024-2026 онуудад зарцуулагдах санхүүжилтийн дүн:

Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төслийн санхүүжилт 270.0 сая ам.доллар байх ба үүнээс:

- Энгийн болон хөнгөлөлттэй зээл 193.1 сая ам.доллар;
- Буцалтгүй тусламж 38.5 сая ам.доллар;
- Засгийн газрын оролцоо 20.7 сая ам.доллар;
- Хувийн хэвшил, банкны салбар болон бусад төсөлд оролцогч талуудын санхүүжилт 17.7 сая ам.доллар байна.

Санхүүжилтийн төлөвлөгөө:

(Үе шатаар, сая ам.доллар)

Эх үүсвэр	Үе шат (ҮСХ[1] ирүүлэх жил)			Нийт
	I үе шат 2023-2025	**II үе шат** 2026-2027	**III үе шат** 2028-2033	
А. Хөрөнгө оруулалтын төслийн бүрэлдэхүүн хэсэг				
Азийн хөгжлийн банк				
(i) Ердийн хөрөнгийн нөөц (энгийн эх үүсвэрийн зээл)	45.0	50.0	40.0	135.0
(ii) Ердийн хөрөнгийн нөөц (хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээл)	45.0	52.2	37.8	135.0
(iii) Тусгай сангийн нөөц (АХС - буцалтгүй тусламж)	3.0	0.0	0.0	3.0
2. Уур амьсгалын ногоон сан (зээл)	11.8	18.4	12.2	42.4
3. Уур амьсгалын ногоон сан (буцалтгүй тусламж)	22.0	10.8	7.2.	40.0
4. Европын хөрөнгө оруулалтын банк (зээл)	52.9	59.4	37.7	150.0
5. Европын хөрөнгө оруулалтын банк (буцалтгүй тусламж)	10.5	11.4	8.1	30.0
6. Монгол Улсын Засгийн газар*	20.7	33.5	21.1	75.3
7. Ашиг шим хүртэгчид**	3.4	2.0	1.3	6.7
Дэд нийлбэр (А)	**214.3**	**237.7**	**165.4**	**617.4**
В. Санхүүгийн зуучлалын зээл				
1. Уур амьсгалын ногоон сан (зээл)	38.4	29.6	19.6	87.6
2. Уур амьсгалын ногоон сан (буцалтгүй тусламж)	3.0	1.2	0.8	5.0
3. Арилжааны банкууд/Хувийн хэвшил	14.3	7.5	3.2	25.0
Дэд дүн (В)	**55.7**	**38.3**	**23.6**	**117.6**
Нийт (А + В)	**270.0**	**276.0**	**189.0**	**735.0**

АХБ, УАНС-ын зээлийн эх үүсвэрүүд нь дараах нөхцөлтэй. Үүнд:

- АХБ-ны хөнгөлөлттэй зээл: 25 жилийн эргэн төлөлтийн хугацаатай байх ба эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, жилийн тогтмол 2 хувийн хүүгийн түвшинтэй байна;

- АХБ-ны энгийн эх үүсвэрийн зээл: 25 жилийн эргэн төлөлтийн хугацаатай байх ба эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй. Хүүгийн түвшний хувьд Баталгаат овернайт санхүүжилтийн хөвөгч хүү дээр 0.5

хувийн нэмэгдэлтэй байх ба хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан төлбөр 0.15 хувь байна;

- УАНС-гийн зээл: 25 жилийн эргэн төлөлтийн хугацаатай байх ба эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Хүүгийн түвшний хувьд 0.25 хувийн хүүтэй байх ба хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан төлбөр 0.5 хувь байна.

- Европын хөрөнгө оруулалтын банкны зээл: 25 жилийн эргэн төлөлтийн хугацаатай байх ба эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Хүүгийн түвшний хувьд тогтмол 2.92 хувийн хүүтэй бөгөөд хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан хураамж 0.15 хувь байна.

Хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүнгүүдийн санхүүжилтийн задаргаа:

(Бүрэлдэхүүн хэсгээр, сая ам.доллар)

Зүйл	Хөрөнгө оруулалт	Нийт	I үе шат
Үр дүн 1: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгч бага ялгаруулдаг, хүн ам суурьших аймаг болон сумын төвүүдийг хөгжүүлэх	**Дэд бүтэц:** Агро-парк, дулаан, цахилгаан, авто зам, ус зайлуулах, хог хаягдлын байгууламж, дахин боловсруулах үйлдвэр	395.7	109.3
Үр дүн 2: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлттэй, тогтвортой бэлчээр болон хөдөө аж ахуйн менежментийг хэрэгжүүлэх	**Мал аж ахуйг дэмжих:** • Өвчнөөс ангид 12 байгууламж, 6 аймаг болон 6 сум дундын түвшний мал эмнэлгийн лабораториуд • Ус хураах, хэмнэх шийдлүүд бүхий 2500га малын тэжээлийн фермийн усалгаатай бүс • Барилгын ажлын явцад 8000 хүн-сарын ажлын байр болгоно	99.2	45.9
Үр дүн 3: Нүүрстөрөгч бага ялгаруулдаг, уур амьсгалд тэсвэртэй малын болон агро-бизнесийн өртгийн сүлжээг бий болгох хүртээмжтэй санхүүжилт олгох	**Санхүүгийн зээл:** 1. ЗГ-аар дамжуулан 50 сая $-ын зээл, дамжуулан зээл, зээлийн эрсдэлийн батлан даалт 2. Арилжааны банкуудаар 50 сая $-ын зээл, дамжуулан зээл, зээлийн эрсдэлийн батлан даалт	117.6	54.8
Үр дүн 4: Нүүрстөрөгч бага ялгаруулдаг, уур амьсгалд тэсвэртэй агро бүс нутгийн хөгжлийг хангах институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх	**Зөвлөх үйлчилгээ ба сургалт:** • 180 орон нутгийн иргэдэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан сургах • уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж • бүсчилсэн хөгжлийн үндэсний 6 бодлогыг боловсруулж хэрэгжүүлсэн	38.5	27.1
Нийт (А)		**651.0**	**237.1**
Төсөвлөгдөөгүй зардал (В)		59.3	24.0
Хэрэгжилтийн явц дах санхүүгийн төлбөр, хураамж (С)		24.7	8.9
Нийт (А+В+С)		**735.0**	**270.0**

1.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ажлын тайлан

А.ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТУХАЙ:

Тайлант хугацаанд Төслийн удирдах хороо 3 удаа хуралдаж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж байсан болно. Үүнд:

- Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 10 сарын 06-ны өдрийн А/62 тоот тушаалаар байгуулагдсан Төслийн удирдах хорооны хурал нь 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яамны хурлын танхимд зохион байгуулагдаж Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөөг баталсан.

- Төслийн удирдах хорооны хурлын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах тухай хэлэлцэн дэмжигдэв. Уг асуудалтай холбоотойгоор төслийн худалдан авах ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөнд өөрчлөлт оров.

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, тэдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/13 дугаар тушаалаар ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан, ЕТГ, ЗГХЭГ, СЯ, ХББОСЯ, ХХААХҮЯ, БОУАӨЯ болон холбогдох төрийн захиргааны байгууллагуудын төлөөллийг оролцуулан Төслийн удирдах хороог шинэчлэн байгуулсан.

УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Хүнсний хувьсгал, Шинэ Хоршоо, Цагаан алт хөдөлгөөнүүдийн зорилттой уялдуулан төслийн 1-р үе шатанд хамрагдах аймаг, сумдын тоог нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна. Энэ хүрээнд төслийн хэрэгжилтийг шуурхай хангах зорилгоор төслийн Удирдлагын гарын авлагад заасан албан тушаалын тоонд багтаан нарийн мэргэжлийн болон инженер, техникийн ажилчдаар төсөл хэрэгжүүлэх нэгжийг өргөтгөх шаардлага гарсан.

Тус шинэчлэн байгуулагдсан Төслийн удирдах хороо нь 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр хуралдаж Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 үйл ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоонд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцэн дэмжиж батлав.



МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 09 сарын 18 өдөр Дугаар А/13 Улаанбаатар хот

Төслийн удирдах хороо шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 7.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Төслийн удирдах хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Дарга: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

Гишүүд: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх (зөвшилцөнөөр);

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бүс, орон нутгийн удирдлага зохицуулалтын газрын дарга (зөвшилцөнөөр);

Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын дарга;

Эдийн засаг, хөгжлийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга;

Эдийн засаг, хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээний газрын Дүнд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, зорилтот хөтөлбөр хариуцсан ажилтан;

Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга (зөвшилцөнөөр);

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга (зөвшилцөнөөр);

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Салбарын хөгжил, орон сууцжуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга (зөвшилцөнөөр);

240071

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга (зөвшилцөнөөр);

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (зөвшилцөнөөр);

Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (зөвшилцөнөөр);

Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (зөвшилцөнөөр);

Нарийн бичгийн дарга: "Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Төслийн зохицуулагч.

2. Төслийн хэрэгжилтийг хангуулж, тухай бүр тайлагнаж ажиллахыг Төслийн удирдах хороонд даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Төслийн удирдах хороо байгуулах тухай" Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 10 дугаар 06-ны өдрийн А/62 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Л.ГАНТӨМӨР

Б. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ:

- **Үйл ажиллагааны талаар:**

Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 189 дүгээр тушаалаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог баталсан тул АХБ-ны журмын дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилчдыг нээлттэй сонгон шалгаруулж, сонгон шалгаруулалтын үр дүнгээр АХБ, Сангийн яамны зөвшөөрлийн дагуу 2024 оны 02 дугаар сараас эхлүүлэн Төслийн удирдагч, Сангийн яамны ТНБД-ын тушаалаар санхүүгийн ажилтан, худалдан авалтын ажилтан нар тус тус томилогдон ажилласан байна.

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоо:

- Улаанбаатар хот – 15 орон тоо
- Орон нутаг дахь ТХН: Ховд, Увс, Баян-Өлгий аймаг тус бүрт 3, нийт 9 орон тоо батлагдсан.

Төслийн үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэнтэй холбогдуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжийг улсын бүртгэлд бүртгүүлэх, Төрийн сан банканд харилцах данс нээх, Төслийн санхүүжилтийн төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэн батлуулах, батлагдсан төлөвлөгөөг Сангийн яам, АХБ-нд хүргүүлэх, мөн шилэн данс, Сангийн яамны төсвийн болон Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй холбогдох цахим системүүдэд төслийн хэрэгжлтийн талаарх мэдээлэл, тайланг тогтоосон хугацаанд тайлагнах зэрэг үйл ажиллагааг хийж байна. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор уг төсөлд шаардлагатай оффисын тавилга, тоног төхөөрөмж, автомашин худалдан авах ажиллагааг АХБ-ын худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулан, гэрээг дүгнэн, санхүүжилтийг холбогдох журмын дагуу олгосон.

Сангийн сайдын тушаалаар батлагдсан Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тооны дагуу Төслийн нэгжид 2 дэд зохицуулагч, худалдан авалт, хот байгуулалтын мэргэжилтэн болон хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан, орчуулагч, Увс, Ховд, Баян-Өлгий зэрэг аймгуудын Төсөл хэрэгжүүлэх нэгжүүдэд шаардлагатай албан тушаалтнуудыг 2024 оны 06 дугаар сараас, барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан дэд зохицуулагчийг 2024 оны 07 дугаар сараас тус тус нээлттэй сонгон шалгаруулалт хийн АХБ-ын зөвшөөрлөөр тус тус томилсон. Мөн Азийн хөгжлийн банк, Сангийн яамны зөвшөөрлөөр 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагчийг шинээр дахин томилон, өмнө нь ажиллаж байсан зохицуулагч Төсөл хэрэгжүүлэх нэгжид Ерөнхий инженерээр томилогдон ажиллаж байна.

Төслийн удирдах хорооны 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоонд нэмэлт, өөрчлөлт оруулсныг Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны 210 дугаар тушаалаар баталгаажуулсан болно.



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2024 оны 11 сарын 20 өдөр Дугаар 210 Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, "Журам батлах тухай" Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 7.12.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 189 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжих байгаа "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалт" хөтөлбөрийн Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоонд "Говь-Алтай аймгийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтан", "Завхан аймгийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Хяналт-шинжилгээ үнэлгээний ажилтан"-г тус тус нэмж батлагдсугай.

2. Төслийн хэрэгжилтэд холбогдох хууль, тогтоомж болон "Журам батлах тухай" Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар батлагдсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар /Ж.Дэлгэржаргал/, Төсөл хэрэгжүүлэх нэгж /Б.Батэориг/-д тус тус даалгасугай.

САЙД Б.ЖАВХЛАН

9763000225



Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 210 дугаар тушаалын хавсралт

"АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"-ИЙН НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ШИНЭЧИЛЭГДСЭН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаал	Орон тоо
1	Төслийн зохицуулагч	1
2	Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан дэд зохицуулагч	1
3	Мал аж ахуй болон бэлчээрийн менежментийн асуудал хариуцсан дэд зохицуулагч	1
4	Сангийн удирдлага хариуцсан дэд зохицуулагч	1
5	Төслийн менежментийн асуудал хариуцсан дэд зохицуулагч	1
6	Ерөнхий инженер	1
7	Санхүүгийн ажилтан	1
8	Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн	1
9	Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	1
10	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	1
11	Сангийн удирдлага хариуцсан санхүүгийн ажилтан	1
12	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
13	Хуульч	1
14	Нийгэм, жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
15	Олон нийттэй харилцах, маркетингийн ажилтан	2
16	Хот байгуулалтын мэргэжилтэн	1
17	Ус хангамж, дулаан, ариутгах татуургын инженер	1
18	Авто замын инженер	1
19	Цахилгааны инженер	1
20	Нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн	1
21	Агрономич	1
22	Бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
23	Малчдын байгууллага, баталгаажуулалтын мэргэжилтэн	1
24	Мал аж ахуй, агро бизнесийн мэргэжилтэн	1
25	Орчуулагч-туслах ажилтан	1
26	Захиргааны ажилтан	1
27	Жолооч	3
	Бүгд	30

Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн шинэчлэгдсэн бүтэц, орон тоо:

- Улаанбаатар хот – 30 орон тоо
- Орон нутаг дахь ТХН: Ховд, Увс, Баян-Өлгий аймаг тус бүрт 3, Говь-Алтай, Завхан аймаг тус бүрт 1, нийт 11 орон тоо батлагдсан.

Тус бүтцийг АХБ-нд хүргүүлж танилцуулсан бөгөөд АХБ-наас Говь-Алтай, Завхан аймагт батлагдсан орон тоог дэмжих боломжгүйгээ мэдэгдсэн.

Одоогоор Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс төслийг хэрэгжүүлэх гарын авлага /FAM/, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 зөвлөх үйлчилгээний ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг зохион байгуулахаар ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд төслийг хэрэгжүүлэх гарын авлага /FAM/-тай танилцаж, уг баримт бичгийн төсвийн хэсэг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэсэгт өөр өөр дүнгээр тусгагдсан төсөвт өртгийн дүн болон бусад шаардлагатай өөрчлөлтүүдийг Төсөл хэрэгжүүлэх гарын авлагад оруулах саналыг бэлтгэн харьяа яаманд танилцуулах бэлтгэлийг хангаж, зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг /TOR/ эцэслэн бэлтгэх, зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгүүдийг боловсруулах ажлуудыг үе шаттайгаар хийж байна.

"Төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг бодлогыг сайжруулах " зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр АХБ, ЭЗХЯ-ны цахим систем, өдөр тутмын Өдрийн сонинд болон төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn дамжуулан сонгон шалгаруулалтын зарыг байршуулан зарласан. Тендерт оролцох сонирхлыг 2025 оны 01 дүгээр сарын 24 өдрийг хүртэл хүлээн авах болно.

- **Сургалтын талаар:**

Тайлант хугацаанд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд нь Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан нийт 15 сургалтанд хамрагдсан.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааны тайлан

№	Сургалтын нэр	Сургалтын огноо	Зохион байгуулагч	Оролцсон ТХН-ийн ажилтан
1	Гадаад зээл тусламжийн удирдлага зохицуулалтын шинэ журмын танилцуулга	2024.02.08	Сангийн яам	• Төслийн зохицуулагч • Санхүүгийн ажилтан • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
2	Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем сургалт	2024.02.23	ТХАА-ны сургагч багш Батбаяр	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
3	АХБ -ны зөвлөх үйлчилгээний сургалт 1	2024.02.26	АХБ-ны ХАА-ны ахлах мэргэжилтэн Ж.Батцэнгэл	• Төслийн зохицуулагч • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
4	Авлигатай тэмцэх шударга ёсны боловсрол олгох сургалт	2024.02.28	АХБ	• Төслийн зохицуулагч • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
5	Төрийн худалдан авах ажиллагааны цахим сургалт	2024.02.29	ТХАА-ны сургагч багш Содгэрэл	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
6	АХБ -ны зөвлөх үйлчилгээний сургалт 2	2024.03.05	АХБ-ны ХАА-ны ахлах	• Төслийн зохицуулагч • Санхүүгийн ажилтан

			мэргэжилтэн Ж.Батцэнгэл	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
7	“Strengthening Safeguards Compliance in Mongolia” 3 модул сургалт	2024.03.19-21	АХБ, сургагч багш Реден Жон Балсоро, Мариа Лорена, Мөнхзул	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
8	Гэрээний менежментийн сургалт	2024.05.29	АХБ, сургагч багш Глен Харрис	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
9	Зээл, тусламжийн зарцуулалтын семинар	2024.04.15-17	АХБ	• Төслийн зохицуулагч • Санхүүгийн ажилтан
10	ФИДИК барилгын ажлын гэрээний дунд шатны мэдлэг олгох богино хугацаат сургалт	2024.06.12-14	АХБ, Монголын авто замчдын холбоо	• Мал аж ахуй, бэлчээрийн менежмент хариуцсан дэд зохицуулагч • Санхүүгийн ажилтан • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан • Хот байгуулалтын мэргэжилтэн
11	Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем (ODAMIS)-ийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-д шилжүүлэх сургалт	2024.07.05	Сангийн яам	• Санхүүгийн ажилтан • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
12	2024 LORTA нөлөөллийн үнэлгээний дизайны семинар /2024 LORTA Impact Evaluation Design Workshop/	2024.10.01-2024.10.05	Уур амьсгалын ногоон сангаас зохион байгуулсан	• Ерөнхий инженер • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
13	Байгаль орчны менежментийн сургалт	2024.12.09	Азийн хөгжлийн банк	• Хот байгуулалтын мэргэжилтэн
14	Хяналт-шинжилгээний үнэлгээний сургалт	2024.12.10	Сангийн яам	• Хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн
15	PIMIS системд шилжих тухай онлайн сургалт	2024.12.13	Сангийн яам	• Нийт ажилчид

- **Ажилтнуудын томилгооны талаар:**

Монгол улсын Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 189 дүгээр тушаалаар ТХН-ийн бүтэц, орон тоог баталсан. Уг тушаалд Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 210 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг нийт 41 орон тоотой байхаар батлагдсан. Тайлант хугацаанд 21 ажилтан томилогдож, 4 ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна. Одоогоор 17 ажилтан төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

	Нэр	Албан тушаал	Томилогдсон огноо	Тайлбар
1	Н.Тэгшбаяр	Төслийн зохицуулагч	9/5/2024	
2	Б.Ванчиндорж	МАА,Бэлчээрийн менежмент хариуцсан дэд зохицуулагч	6/3/2024	
3	Ж.Жанарбаатар	Ногоон бүсийн хүртээмжтэй агробизнесийн сан хариуцсан дэд зохицуулагч	5/17/2024	

4	Д.Алтангэрэл	Барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан дэд зохицуулагч	7/17/2024	
5	Б.Батзориг	Ерөнхий инженер	2/1/2024 2024/09/20	
6	Ч.Одонтуяа	Санхүүгийн ажилтан	2/1/2024	
7	Г.Баясгалан	Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах ажилтан	2/1/2024	2024/12/01 өдрөөс өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн.
8	Ц.Батбаяр	Худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан	5/17/2024	
9	Ё.Лхагвадорж	Хот байгуулалтын мэргэжилтэн	5/17/2024	
10	Б.Даваажав	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн	7/1/2024	
11	Р.Номиндарь	Орчуулагч/туслах ажилтан	5/17/2024	
12	У.Баатархүү	Жолооч	5/17/2024	
13	Ц.Батбалжир	Жолооч	5/17/2024	
14	Д.Дашдорж	Жолооч	21/11/2024	
	Ховд аймаг ТХН			
15	Б.Гомбосүрэн	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн	6/3/2024	2024/11/01 өдрөөс өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн.
16	С.Гансүх	Санхүү, Худалдан авалтын мэргэжилтэн	5/17/2024	
	Увс аймаг ТХН			
17	Д.Жанузаг	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн	5/17/2024	2024/11/07 өдрөөс өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн.
18	Н.Пүрэвдорж	Санхүү, Худалдан авалтын мэргэжилтэн	5/17/2024	2024/11/14 өдрөөс өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн.
19	Б.Алтангэрэл	Инженер	5/17/2024	
	Баян-Өлгий аймаг ТХН			
20	Х.Анар	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн	5/17/2024	
21	Ж.Маржан	Санхүү, Худалдан авалтын мэргэжилтэн	5/17/2024	

Орон нутгийн томилолтын талаар:

Томилолт - 1

Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/132 тушаалын дагуу ЭЗХЯ, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлж буй "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хүрээнд Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай аймгуудад хөтөлбөрийн 1-р үе шатыг албан ёсоор эхлүүлэх, хийгдсэн суурь судалгаануудын техник, эдийн засгийн үндэслэлүүдийг хянан баталгаажуулах, төсөл хэрэгжих талбайн бодит нөхцөл байдалтай танилцах, холбогдох уулзалт зохион байгуулах зорилгоор ТХН-ийн ажилтнууд ЭЗХЯ-ны холбогдох албан тушаалтнуудтай хамтран 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 08-ны өдрүүдэд батлагдсан удирдамж, төсвийн дагуу ажиллав.

Томилолтоор ажиллах явцад:

- Аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчийн хурлын дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга нартай уулзалт зохион байгуулж төслийн үйл ажиллагааны талаар танилцуулга хийж мэдээлэл солилцов,
- Төсөл хэрэгжих талбайн бодит нөхцөл байдалтай танилцсан,
- Төслийн өмнө хийгдсэн суурь судалгаануудын ажлууд, техник эдийн засгийн үндэслэлийг хянаж танилцсан,
- Ажлын тоо хэмжээг хянан, нэмэлтээр, эсвэл өөрчлөн оруулах боломжтой ажлуудын талаар санал солилцсон,
- Хөдөө аж ахуйн кластеруудыг хөгжүүлэх талаар санал солилцсон,
- Ногоон агро-бизнесийн хөгжил болон хөдөө аж ахуйн салбарыг дэмжихэд шаардлагатай аймаг сумдын дэд бүтцийг бий болгох тухай хэлэлцүүлэг хийсэн,
- Орон нутгийн газар зохион байгуулалт, газар зохион байгуулалтын менежментийг сайжруулах талаар санал солилцов.

Томилолтын үр дүнд аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчийн хурлын дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, иргэдтэй уулзалт зохион байгуулж төслийн үйл ажиллагааны талаар ярилцлага хийж, хөтөлбөрүүдийг хэрхэн хамгийн оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар уулзалт, ярилцлагуудыг хийсэн.

Томилолт – 2

"Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр" төслийн хүрээнд санхүүжүүлэгч Азийн хөгжлийн банкнаас ирүүлсэн удирдамжийн дагуу Эдийн засаг, хөгжлийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн холбогдох албан тушаалтнууд төсөл хэрэгжих Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудад томилолтоор (Inception Mission) ажиллаж нутгийн захиргааны төв байгууллагуудын удирдлагатай уулзалт хэлэлцээр хийх, төслийн байршилтай танилцаж төсөл хэрэгжих суурь нөхцөл, одоогийн дэд бүтцийн байдалтай танилцах, цаашид төслийг шуурхай хэрэгжүүлэх, эрчимжүүлэх арга хэмжээний санал боловсруулах зорилгоор 2024 оны 11 дүгээр сарын 03-аас 10-ны өдрүүдэд ажиллаа.

Томилолтын хүрээнд Ховд, Баян-Өлгий, Увс аймгийн төв болон Увс аймгийн Өмнөговь суманд доорх ажиллуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ажлийн хэсэгт багтсан холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулах;
- Төслийн байршилтай танилцаж төсөл хэрэгжих суурь нөхцөл, одоогийн дэд бүтцийн байдалтай танилцах, төсөл хэрэгжүүлэх хуваарь, зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийн төлөвлөгөө, төслийн зардлын төсөв, төслийн байгаль орчин, нийгмийн болон нүүлгэн шилжүүлэлтийн хамгаалалтын төлөвлөгөөний асуудлаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах.

Зураг 1: Баян-Өлгий аймгийн нутгийн удирдлагуудтай хийсэн уулзалт

Зураг 2: Увс аймгийн нутгийн удирдлагуудтай хийсэн уулзалт

Зураг 3: Ховд аймгийн нутгийн удирдлагуудтай хийсэн уулзалт

Зураг 4: Увс аймгийн Өмнөговь сумын нутгийн удирдлагуудтай хийсэн уулзалт

Inception Mission томилолтын ажлын талаар тусад нь бүлэг болгон дэлгэрэнгүй тайлагналаа.

<u>Томилолт – 3</u>

“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн 1-р бүрэлдэхүүн хэсгийн хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтыг баталгаажуулах, нэмэлт өөрчлөлт оруулах хүрээнд аймгуудын Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн саналуудтай дэлгэрэнгүй газар дээр нь танилцаж, санал боловсруулах зорилгоор Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан ажилтнууд 2024 оны 12 дугаар сарын 01-ээс 06-ны өдрүүдэд Ховд аймагт томилолтоор ажиллав.

Хийж гүйцэтгэсэн ажлууд:

Томилолтын хүрээнд Ховд аймгийн төвд доорх ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Аймаг, сумын Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ажлын хэсэгт багтсан холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулав;
- Төслийн хүрээнд төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтыг дэлгэрэнгүй хэлэлцэж, Аймгийн захиргааны саналыг тусгах, уг саналуудын одоогийн нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцов;
- Зураг төсөл бэлэн газар чөлөөлөлтгүй ажлууд байгаа эсэх талаар нягталж, мэдээлэл цуглуулав.

ТӨСЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн удирдах хорооны 2024 оны 09 дугаар сарын 23-ны
өдрийн 3 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"
ТӨСЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 09 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

№	ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУД	2024												Хариуцах байгууллага
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
	1. Төслийн менежмент, институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх													
1.1	Төслийн үйл ажиллагаа, ХАА-ны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулах, Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэн батлах													Нэгдсэн Төсөл хэрэгжүүлэх нэгж /НТХН/
1.2	Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлууд (ажлын оффис, тавилга, тоног төхөөрөмж, санхүүжилтийн данс шинээр нээх), ажлын байрны тодорхойлолтууд боловсруулах, батлуулах													НТХН
1.3	Төслийн хэрэгжүүлэх нэгжийн батлагдсан бүтэц, орон тооны дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулах													Эдийн засаг, хөгжлийн яам /ЭЗХЯ/, НТХН
1.4	Төслийн зээлийн болон буцалтгүй тусламжийн гэрээнүүд байгуулах /нэмэлтээр/													ЭЗХЯ, Сангийн яам /СЯ/, АХБ, НТХН
1.5	Орон нутгийн салбар оффис бий болгох, үйл ажиллагааг нь эхлүүлэх /Баян-Өлгий, Ховд, Увс/													НТХН
1.6	Азийн хөгжлийн банк (АХБ), бусад санхүүжүүлэгч болон оролцогч талуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх, хамтран ажиллах													ЭЗХЯ, НТХН
	2. Төслийн хэрэгжилтийг хангах Зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах													
2.1	Тендерийн үнэлгээний хороо (ТҮХ)-д байгуулах													ЭЗХЯ, НТХН
2.2	"Аймаг,сумын төвүүдийн дэд бүтцийг байгуулах" ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэх, менежментийн бодлогыг дэмжих зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, , ажил эхлүүлэх (Багцын дугаар: PIO1, Төсөвт өртөг: 4,346,000.00 ам.доллар)													ЭЗХЯ, НТХН, Оролцогч байгууллагууд
2.3	**Үйл ажиллагаа 1**: Төслийн I үе шатны нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтад хяналт тавих зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, ажил эхлүүлэх (Багцын дугаар: DDS1, Төсөвт өртөг: 7,035,395.00 ам.доллар)													ЭЗХЯ, НТХН, Оролцогч байгууллагууд
2.4	**Үйл ажиллагаа 2:** "Бэлчээрийн менежментийг сайжруулах" ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах (Багцын дугаар: PIO2, Төсөвт өртөг: 8,450,472.00 ам.доллар)													ЭЗХЯ, НТХН, Оролцогч байгууллагууд

2.5	**Үйл ажиллагаа 3:** "Агро-Бизнес эрхлэгчдэд бага хүүтэй,ногоон ХАА-н бизнес зээл" ажлын хүрээнд ажлын хүрээнд төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах (Багцын дугаар: PIO3, Төсөвт өртөг: 5,100,000.00 ам.доллар)													ЭЗХЯ, НТХН, Оролцогч байгууллагууд
	3. Төслийн хүрээний бараа, ажил худалдан авалт													
3.1	Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шинээр томилогдсон ажилчдад оффисын тоног төхөөрөмж, тавилга худалдан авах ажлыг зохион байгуулах													ЭЗХЯ, НТХН, Оролцогч байгууллагууд
	4. Төслийн менежментийн үйл ажиллагаанууд													
4.1	Төслийн удирдах хорооноос өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах													НТХН
4.2	Сангийн яамны Удирдлагын мэдээллийн системд холбогдох мэдээллийг тухай бүр оруулах													НТХН
4.3	Төсөл, арга хэмжээний улирлын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийж тайлан боловсруулан холбогдох байгууллагад илгээх /Улирал тутам/													НТХН
4.4	Төслүүдийн НДШ, НӨАТ, зарцуулалтын мэдээ тайлан бэлтгэж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх													НТХН
4.5	Төслийн шилэн дансны мэдээлэл оруулах, тайлагнах													НТХН
4.6	АХБ болон Засгийн газарт тайлан мэдээ хүргүүлэх													НТХН
4.7	ЭЗХЯ, СЯ болон АХБ-аас зохион байгуулах сургалт, семинарт хамрагдах													НТХН

*2024 онд нийт 26 нэр төрлийн ажил төлөвлөв.

НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУД	БИЕЛЭЛТ
1. Төслийн менежмент, институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх		
1.1	Төслийн үйл ажиллагаа, ХАА-ны болон санхүүгийн төлөвлөгөөг боловсруулах, Төслийн удирдах хороогоор хэлэлцүүлэн батлах	Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 189 дүгээр тушаалаар нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулан, Төслийн зохицуулагч, Санхүүгийн ажилтан, Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс томилогдон үйл ажиллагаа эхэлсэн тул Төслийн удирдах хорооны 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ТУХ-ны 2 дугаар тогтоолоор тус тус баталсан. Уг төлөвлөгөөнд Төслийн удирдах хорооны 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 2 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан. Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зарим ажилчид 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр, 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрүүдээс шинээр томилогдсон, мөн Монгол Улсын Их хурлын 2024 оны сонгуулийн үр дүнгээр Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан Төсөл удирдах хорооны гишүүд шинэчлэгдсэн тул Төслийн удирдах хорооны хуралдааныг 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр хийж Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны, Худалдан авах ажиллагааны, санхүүгийн төлөвлөгөөг ТУХ-ны 3 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн баталсан. Одоо энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажиллаж байна. *Биелсэн 100%*
1.2	Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлууд (ажлын оффис, тавилга, тоног төхөөрөмж, санхүүжилтийн данс шинээр нээх), ажлын байрны тодорхойлолтууд боловсруулах, батлуулах	А. Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангах чиглэлээр оффисын тавилга, тоног төхөөрөмж, авто машин худалдан авах тендерийг зохион байгуулав. Үүнд: 1. Оффисын тавилга авах тендерийг 2024.05.06 өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, АХБ-ны журмын дагуу зарлаж, 2024.05.13 өдөр нээж, үнэлгээг хийж, сонгон шалгаруулалтын үр дүнгээр “Анун” ХХК-тай 83.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч гэрээний дагуу тавилгыг бүрэн нийлүүлсэн. 2. Тоног төхөөрөмжийн тендерийг 2024.05.06 өдөр Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, АХБ-ны журмын дагуу зарлаж, 2024.05.13 өдөр нээж, үнэлгээг хийж, сонгон шалгаруулалтын үр дүнгээр “Аи Ти Зон” ХХК-тай 162.9 сая төгрөгөөр, “БСБ электроникс” ХХК-тай 6,8 сая төгрөгөөр, “Аргил сувд” ХХК-тай 1.16 сая төгрөгөөр тус тус гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компаниуд гэрээний дагуу тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлсэн. Б. Сангийн яамны Төрийн сан банкинд холбогдох журмын дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн урсгал болон хөрөнгө оруулалтын дансуудыг нээсэн. В. Улаанбаатар хот дахь оффист шинээр авах 16 албан тушаалаас эхний ээлжинд шаардлагатай байгаа 11 албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг бэлтгэн 2024

		оны 12 дугаар сарын 27-ны өдөр Азийн хөгжлийн банкнаас “Үл татгалзах” авах хүсэлтийг хүргүүлсэн, хариу хүлээж байна. *Биелсэн 100%*
1.3	Төслийн хэрэгжүүлэх нэгжийн батлагдсан бүтэц, орон тооны дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулах	Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 189 дүгээр тушаалаар нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулан, батлагдсан бүтэц, орон тооны дагуу нийт 19 албан тушаалтанг 2024 оны 2, 5, 6 дугаар саруудад үе шаттайгаар томилуулаад байна. Үүнд: Улаанбаатар хотын ТХН-д 12, орон нутгийн төсөл хэрэгжүүлэх нэгжид 7 албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг бэлтгэн боловсруулж, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, албан тушаалтнуудыг томилуулсан. УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” хамтарсан Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Цагаан алт хөдөлгөөнүүдийн зорилтой уялдуулан төслийн хэрэгжилтийг шуурхай хангах зорилгоор төслийн удирдлагын гарын авлагад заасан албан тушаалын тоонд багтаан нарийн мэргэжлийн болон инженер, техникийн ажилчдаар төсөл хэрэгжүүлэх нэгжийг өргөтгөх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн. Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 210 дугаар тушаалаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Улаанбаатар хот дахь бүтцийг 16 хүний орон тоогоор нэмэгдүүлэн, нийт 30 хүний орон тоотой, орон нутагт 11 хүний орон тоотой, Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж нийт 41 хүний бүтэц, орон тоотой байхаар батлагдсан байна. Улаанбаатар хот дахь оффист шинээр авах 16 албан тушаалаас эхний ээлжинд шаардлагатай байгаа 11 албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг бэлтгэн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Азийн хөгжлийн банкнаас “Үл татгалзах” авах хүсэлтийг хүргүүлсэн, хариу хүлээж байна. Азийн хөгжлийн банкнаас зөвшөөрөл ирүүлэхээр шинээр батлагдсан бүтэц, орон тооны дагуу шинэ ажлын байруудыг холбогдох журмын дагуу зарлаж эхэлнэ. *Биелсэн 90%*
1.4	Төслийн зээлийн болон буцалтгүй тусламжийн гэрээнүүд байгуулах /нэмэлтээр/	Монгол Улс болон Азийн хөгжлийн банк хооронд 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2023 оны 07 дугаар сарын 06-ний өдрийн УИХ-ын чуулганаар соёрхон баталсан. Үүний дагуу Монгол Улсын Сангийн яам Азийн хөгжлийн банктай санхүүжилтийн эх үүсвэр тус бүрээр орж ирж буй 3 зээлийн хэлэлцээрийг 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан. Үүнд: Энгийн эх үүсвэрийн 45.0 сая ам.доллар, хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн 45.0 сая ам.доллар, уур амьсгалын ногоон сангийн эх үүсвэртэй 50.2 сая ам.доллар, нийт 140.2 сая ам.долларын зээлийн хэлэлцээрийг байгуулсан байна. Дээрх зээлийн хэлэлцээрүүдэд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хууль зүйн дүгнэлт 2024 оны 03 дугаар сарын 19-ны өдөр гаргаснаар эдгээр гэрээнүүд хүчин төгөлдөр болсон. *Биелсэн 100%*

1.5	Орон нутгийн салбар оффис бий болгох, үйл ажиллагааг нь эхлүүлэх /Баян-Өлгий, Ховд, Увс/	Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 189 дүгээр тушаалаар Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудын төсөл хэрэгжүүлэх нэгжүүдийг байгуулан, тус бүр 3 орон тоотой бүтэц баталж өгснөөс ажлын байрны нөхцөл, шаардлагийн дагуу АХБ-наас ажилтан сонгон шалгаруулах "Үл татгалзах" зөвшөөрлийг авч 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс Ховд аймгийн ТХН-д 2, Увс аймгийн ТХН-д 3, Баян-Өлгий аймгийн ТХН-д 2 албан тушаалтныг тус тус томилон ажиллуулж байна. *Биелсэн 100%*
1.6	Азийн хөгжлийн банк (АХБ), бусад санхүүжүүлэгч болон оролцогч талуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх, хамтран ажиллах	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч талын хамтын ажиллагааг хангах, төслийн үйл ажиллагаанд тулгараад байгаа асуудлуудыг шуурхай шийдвэрлэх талаар тухай бүр холбогдох уулзалтуудыг хийж ажилласан. Тухайлбал: Төслийн захиралд танилцуулан чиглэл авсны хүрээнд АХБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын холбогдох албан тушаалтнуудтай 2024.06.19 өдөр уулзалт хийсэн. Тус уулзалтаар төслийн хүрээнд хийгдэхээр тулгамдаад байгаа ажлууд, төслийг хэрэгжүүлэхэд авах арга хэмжээний санал, зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, зөвлөх үйлчилгээний ажлын тендерийг зарлах хугацаа, төслийн талбайд АХБ-ны төлөөлөгчид болон ТХН-ээс хамтран хийх томилолтын асуудал зэргээр санал солилцсон. Уг уулзалтаар төслийн гадаадын зөвлөхийн тендерийн ажлын хүрээнд хийгдэх сургалт, судалгаа, худалдан авах тоног төхөөрөмж, зарцуулах хөрөнгийн задаргааг харуулсан зөвлөхийн нарийвчилсан төсвийн задаргааг багц тус бүрээр авах хүсэлтийг тавьсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс 2 дахь уулзалтыг АХБ-ны төлөөлөгч нартай 2024.07.05 өдөр хийсэн. Уг уулзалтаар Төсөл хэрэгжүүлэх гарын авлагын төсвийн хэсэг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэсэгт өөр өөр дүнгээр тусгагдсан төсөвт өртгийн дүн болон бусад шаардлагатай өөрчлөлтүүдийг Төсөл хэрэгжүүлэх гарын авлагад оруулах саналыг бэлтгэн харьяа яаманд танилцуулах бэлтгэлийг хангаж, зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг /TOR/ эцэслэн бэлтгэх, зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгүүдийг боловсруулах ажлуудыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлэх зэрэг асуудлуудаар ярилцсан. 2024.07.30 өдөр төслийн суурь судалгааг хийсэн төслийн багийн дэд ахлагчтай уулзаж мэдээлэл авсан. ХБОСЯ, ХХААЯ-ны холбогдох албан тушаалтантай уулзалж төслийн талаар товч мэдээлэл өгсөн. ХХААЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга н.Болорчулуун 2024.09.27 өдөр Төслийн хүрээнд хэрэгжих ажлуудын саналын талаар холбогдох чиглэл удирдамжийг өгсөн. Уг асуудлыг төслийн зохицуулагчид танилцуулсан. 2024 оны 11 дүгээр сард Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй Уур амьсгалын өөрчлөлтийн төслийн техникийн ахлах зөвлөх Yusuke Taishi болон албан холбогдох хүмүүстэй уулзалт хийж Төслийн 2 болон 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын давхардлыг гаргах, цаашид хамтран ажиллах талаар санал солилцон, ажил хэргийн уулзалтуудыг хийж байна. АХБ-наас сар бүр хийгдэж буй төслийн ажил,

		санхүүжилт, зарцуулалтын талаарх танилцуулга холбогдох мэдээллийг бэлтгэн танилцуулж байна. Азийн хөгжлийн банкнаас ирүүлсэн эхлэлтийн ажлын томилолт (Inception Mission)-ын удирдамжийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Азийн хөгжлийн банкны төлөөлөгчдийн хамтаар Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудад 2024 оны 11 дүгээр сарын 04-09 өдрүүдэд ажиллаж, аймаг, орон нутгийн Засаг дарга болон төслийн үйл ажиллагаатай холбогдох нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийж одоогийн байгаа дэд бүтэц, төсөл хэрэгжих газрын байршил зэрэг суурь нөхцөлүүдтэй танилцан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналуудаа томилолтоос буцаж ирсний дараа 2024 оны 11 дүгээр сарын 12-15 өдрүүдэд АХБ-ны мэргэжилтэнгүүдтэй хамтран бэлтгэж, уг томилолтын хүрээнд хийгдэх харилцан ойлголцолын санамж бичгийн төсөл болон бусад холбогдох баримт бичгүүдийг бэлэн болгож ЭЗХЯ талаас Төслийн захирал Ч.Өнөржаргал, АХБ талаас төслийн ахлах мэргэжилтэн Раушенбек нар гарын үсэг зурж баталгаажуулсан. *Биелсэн 80%*
	2. Төслийн хэрэгжилтийг хангах Зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах	
2.1	Тендерийн үнэлгээний хороо (ТҮХ)-д байгуулах	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024.05.02 өдрийн А/102 дугаар тушаалаар Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдах тавилга, тоног төхөөрөмж, автомашин худалдан авах тендерийн үнэлгээний хороог байгуулсан. Мөн тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан гадаадын зөвлөхийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулж өгөх хүсэлтийг ЭЗХЯ-д хүргүүлсэн. Тус үнэлгээний хороонд БХБЯ, ХХААХҮЯ-аас оролцох албан тушаалтны нэрсийг албан бичгээр авсан, холбогдох тендерийн үнэлгээний хороод байгуулагдсан. *Биелсэн 100%*
2.2	**<u>Төслийн I үе шатны</u>** нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтад хяналт тавих зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, ажил эхлүүлэх (Багцын дугаар: DDS1, Төсөвт өртөг: 7,035,395.00 ам.доллар)	Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавартай танилцан холбогдох мэдээллийг бэлтгэн Төслийн захирал болон Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. Уг төслийн гадаадын зөвлөхийн ажлын даалгаварт тусгагдсан 2 ажлын давхардлыг шалгах, хийх ажлуудыг хянаж тодорхой болгох, зураг төсөв бэлтгэх ажлын хүрээнд төсөл хэрэгжих сум, орон нутгийн удирдлагуудатай хэлэлцэж тохирсны дараагаар зөвлөхийн ажлын тендерийг зарлах чиглэлийг өгсөн. *Биелсэн 50%*
2.3	**<u>Үйл ажиллагаа 1 :</u>** "Аймаг,сумын төвүүдийн дэд бүтцийг байгуулах" ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэх, менежментийн бодлогыг дэмжих зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, , ажил эхлүүлэх (Багцын дугаар: PIO1, Төсөвт өртөг: 4,346,000.00 ам.доллар)	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/295 дугаар тушаалаар “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн 1 дүгээр үе шатны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан “Төслийн хэрэгжилт болон менежментийн дэмжлэг үзүүлэх, бодлого сайжруулах” зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог шинэчлэн байгуулсан. Үүний дагуу тендерийн үнэлгээний хорооны хуралдааныг 2024.12.04 өдөр зохион байгуулан Төсөл хэрэгжүүлэх нэгжээс боловсруулсан

		зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварыг үнэлгээний хороонд танилцуулсан. Мөн зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг 2024.12.05 өдөр илтгэх хуудсаар Төрийн нарийн бичгийн даргад танилцуулан зөвшөөрөл авсны үндсэн дээр АХБ-наас тендер зарлах зөвшөөрлийг хүссэн албан захиаг Төслийн захирлаас 2014.12.05 өдөр хүргүүлсэн. АХБ-наас зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар /Terms of Reference (TOR)/-т холбогдолтойгоор 2024-12-12 өдөр зарим нэмэлт тодруулга ирүүлснийг Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс боловсруулан, Төслийн захиралд танилцуулан 2024-12-13 өдөр дахин АХБ-нд хүргүүлсэн. АХБ-наас 2024-12-17 өдөр Зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах TOR-ыг цахим системд нийтлэх “Үл татгалзах” зөвшөөрл ирүүлсэн. Үүний дагуу ТНБД-д уг асуудлыг илтгэх хуудсаар танилцуулан зөвшөөрөл авч, TOR-ийг ТНБД-аар батлуулан, зарыг АХБ-ны www.csrn.adb.org, Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn, Өдрийн сонин, ЭЗХЯ-ны цахим хуудаст 2024-12-25 өдөр зарласан. Саналыг 2025-01-24 өдөр хүлээн авна. *Биелсэн 100%*
2.4	**Үйл ажиллагаа 2:** "Бэлчээрийн менежментийг сайжруулах" ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах (Багцын дугаар: PIO2, Төсөвт өртөг: 8,450,472.00 ам.доллар)	- Мал аж ахуй, бэлчээрийн менежментийн бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд зарлах Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж боловсруулахад шаардлагатай мэдээллүүдийг цуглуулах, санал солилцох зорилгоор 11 төрийн болон төрийн бус байгууллага, 11 олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөртэй албан уулзалт зохион байгуулж, төсөл хэрэгжих орон нутгуудад 2 удаа томилолтоор ажилласан. Мөн 9 чуулга уулзалт, хэлэлцүүлэгт Төсөл хэрэгжүүлэх нэгжээ төлөөлөн оролцсон. - 2024-11-03-ны өдөр Мал аж ахуй, бэлчээрийн менежментийг сайжруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварыг АХБ-ны Тэргүүлэх зэргийн мэргэжилтэн М.Раушанбек, Уур амьсгалын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан нарт цахимаар илгээсэн. - 2024-12-20-ны өдөр зохион байгуулагдсан ЭЗХЯ, АХБ болон ТХН-ийн хамтарсан уулзалтын үеэр Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжийг Засгийн газраас хэрэгжүүлж буй Шинэ хоршоо, Цагаан алт хөтөлбөрүүдтэй уялдуулан боловсруулах чиг үүргийг төслийн дэд зохицуулагч Б.Ванчиндорж, АХБ-ны Уур амьсгалын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан нарт өгсөн. - 2024-12-30-ны өдөр АХБ-ны Уур амьсгалын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжид саналаа тусгаж цахимаар ирүүлсэн. - 2025-01-01-ны өдөр АХБ-ны саналыг тусгасан Зөвлөх үйлчилгээний ажлын удирдамжийн сүүлийн хувилбарыг ТХН-ийн зүгээс АХБ-ны Уур амьсгалын мэргэжилтэн Ц.Энх-Амгаланд илгээсэн. - 2025-01-02-ны өдөр АХБ-ны Уур амьсгалын мэргэжилтэн Ц.Энх-Амгалан сүүлийн хувилбар дээр жижиг засвар оруулж АХБ-ны Тэргүүлэх зэргийн мэргэжилтэн М.Раушанбек, Хөдөө аж ахуйн мэргэжилтэн Юүкицугу Янома нарт илгээгээд байна. - Төслийн FAM буюу Удирдлагын гарын авлагад төслийн бэлчээрийн менежменттэй холбоотой хэсгийг “Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо” ТББ-тай шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр заасан. Хэдийгээр төслийн баримт бичигт тодорхой тусгаж өгсөн ч гэсэн аливаа нэг ТББ-тай шууд гэрээ байгуулан

		ажиллахыг ашиг сонирхолын зөрчил гэж үзнэ, тиймээс уг ТББ-тай шууд гэрээ байгуулахгүй, бусад байгууллагуудтайгаа адил тэгш өрсөлдөх байдлаар Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавараа боловсруулах чиг үүргийг 2024-12-20-ны өдөр Төслийн удирдах хорооны даргатай хийсэн уулзалтын үеэр өгсөн. Иймээс "Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэхээр заасан чиг үүргүүд болон зөвлөхийн орон тоог Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаварт нэмж тусгасан. Ингэхдээ гадаад зөвлөхийн орон тоог нэмэхгүй, харин дотоод зөвлөхийн орон тоог нэмэх байдлаар ажлын даалгаварыг боловсруулсан. *Биелсэн 50%*
2.5	**<u>Үйл ажиллагаа 3:</u>** "Агро-Бизнес эрхлэгчдэд бага хүүтэй,ногоон ХАА-н бизнес зээл" ажлын хүрээнд ажлын хүрээнд төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах (Багцын дугаар: PIO3, Төсөвт өртөг: 3,000,000.00 ам.доллар)	Уг арга хэмжээний хүрээнд Төслийн зохицуулагч болон Төслийн захиралд танилцуулан чиглэл авсны хүрээнд АХБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын багийн ахлагч Раушенбектэй уулзалт хийсэн. Тус уулзалтаар төслийн хүрээнд хийгдэхээр тулгамдаад байгаа ажлууд, төслийг хэрэгжүүлэхэд авах арга хэмжээний санал, зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, зөвлөх үйлчилгээний ажлын тендерийг зарлах хугацаа, АХБ-ны Монгол дахь Төслийн багийн томилолт, төслийн талбайд ажиллах асуудлаар хэлэлцсэн. Төслийн удирдлагын гарын авлагад заасны дагуу Монгол улсын Хөрөнгө оруулалтын сангийн хуулийн дагуу санг шинээр үүсгэн байгуулах хууль, эрх зүйн орчныг судлах, уг санг үүсгэн байгуулахад гадаадын зөвлөхийн хийхээр ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг судлах, мөн Сангийн яам бусад байгууллагуудаас туршлага судлах үйл ажиллагааг хийж байна. Мөн уг арга хэмжээний хүрээнд төслийн зөвлөх үйлчилгээний гарын авлагыг орчуулах ажлыг хийж байна. Нийслэлийн засаг даргын тамгын газар дээр хэрэгжиж буй AHURP төслийн нэгжийн албан тушаалтан болон уг төслийн Уур амьсгалын ногоон сангаас олгож буй Хөгжлийн банкны ногоон орон сууцны зээлийн төслийн нэгжийн зохицуулагч М.Түвшинбагана болон ХБ-ны ХОМК-ны захирал Л.Тэмүүжин нартай холбогдох уулзалтуудыг хийж, төслийн хэрэгжилт, GIRAF санг үүсгэн байгуулах асуудлаар туршлага, мэдээлэл солилцох уулзалтуудыг сар бүр зохион байгуулсан. Бүсийн ногоон, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийн сан (GIRAF)-г хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниар Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргуулан шинээр байгуулах тохиолдолд энэхүү компанийг төсөлд оролцогч тал болгохын тулд төслийн зээлдэгч Сангийн яамнаас АХБ-д хүсэлт хүргүүлж, холбогдох зөвшөөрлүүдийг авч, төслийн баримт бичиг нэмэлт, өөрчлөлт оруулсны үндсэн дээр хэрэгжүүлэх нөхцөл байдал үүсэж байгаа тул СЯ, АХБ-нд холбогдох хүсэлтүүдийг хүргүүлж арга хэмжээ авч өгөх тухай 2024.11.21 өдрийн 60 болон 61 тоот албан бичгийг Эдийн засаг, хөгжлийн яам, Монгол Улсын Хөгжлийн банкинд тус тус хүргүүлсэн. Төсөл хэрэгжүүлэх нэгжээс хүргүүлсэн албан бичгийн дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдаас 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/2591 тоот албан бичгийг Сангийн сайдад хүргүүлэн, уг албан тоотод төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд байгуулагдах хөрөнгө оруулалтын сангийн менежментийг хийх компаниар Хөгжлийн банкны "Ди би Эм ассет менежмент" ХХК-ийг сонгон оролцуулах,

		мөн АХБ-аас үл татгалзах зөвшөөрөл авах тухай хүсэлтийг хүргүүлсэн. Сангийн яаманд хүргүүлсэн албан бичгийн дагуу Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын хэлтсийн дарга С.Тулга, мэргэжилтэн А.Гүнбилэг нартай 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрүүдэд тус тус уулзалт хийж холбогдох мэдээллээр хангаж ажилласан. *Биелсэн 50%*
	3. Төслийн хүрээний бараа, ажил худалдан авалт	
3.1	Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шинээр томилогдсон ажилчдад оффисын тоног төхөөрөмж, тавилга худалдан авах ажлыг зохион байгуулах	Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 210 дугаар тушаалаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Улаанбаатар хот дахь бүтцийг 16 хүний орон тоогоор нэмэгдүүлсэн. Үүнтэй холбогдуулан шинээр авах ажилчдын ажлын байрны тодорхойлолтыг АХБ-аар хянуулан “Үл татгалзах” зөвшөөрөл авч сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Мөн Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны 01 дүгээр улирлын зардлын төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд шинээр томилогдсон ажилчдад оффисын тоног төхөөрөмж, тавилгын төсвийг оруулан Төслийн удирдах хороо, Сангийн яамаар батлуулан, батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулна. *Биелсэн 100%*
	4. Төслийн менежментийн үйл ажиллагаануд	
4.1	Төслийн удирдах хорооноос өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах	Төслийн удирдах хороо болон Төслийн захирлаас өгсөн үүрэг, даалгаврыг тухай бүр биелүүлэн ажиллаж байна. Тухайлбал ТУХ-ны хуралдаанаар хэлэлцэн батлагдсан Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан ажил бүрийг цаг хугацааны дагуу хэрэгжүүлэхээр ажиллаж байна. *Биелсэн 100%*
4.2	Сангийн яамны Удирдлагын мэдээллийн системд холбогдох мэдээллийг тухай бүр оруулах	Сангийн яамны удирдлага, мэдээллийн системд төслийн санхүүжилтийн талаарх холбогдох мэдээлэл, гүйцэтгэл, худалдан авалт, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны тайланг сар бүр, зарим тохиолдолд тухай бүр байршуулан ажиллаж байна. *Биелсэн 100%*
4.3	Төсөл, арга хэмжээний улирлын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийж тайлан боловсруулан холбогдох байгууллагад илгээх /Улирал тутам/	Сангийн яамнаас батлагдсан төслийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг бэлтгэх аргачлалын дагуу уг тайланг 2024 оны эхний хагас жилийн байдлаар бэлтгэн Төслийн удирдах хороонд танилцуулсны дараагаар АХБ-д хүргүүлэх, Сангийн яамны удирдлага мэдээллийн ситесмд байршуулсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг бэлтгэн Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 67 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. *Биелсэн 100%*
4.4	Төслүүдийн НДШ, НӨАТ, зарцуулалтын мэдээ тайлан бэлтгэж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх	Төслийн ажилчдын цалинг сар бүрийн 10, 25 өдрүүдэд олгож НДШ-ийн тайланг сарын бүрийн 5-ны дотор, НӨАТ-ын тайланг сар бүр гаргаж цахим системд байршуулан ажиллаж байна. *Биелсэн 100%*
4.5	Төслийн шилэн дансны мэдээлэл оруулах, тайлагнах	Шилэн дансны тухай хуулийн дагуу Төсөл хэрэгжүүлэх нэгжийн урсгал зардал, зардлын төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу холбогдох мэдээллүүдийг тухай бүр шилэн дансны цахим системд

		байршуулан ажиллаж байна. Одоогоор хоцорсон болон дутуу байршуулсан мэдээлэл байхгүй болно. *Биелсэн 100%*
4.6	АХБ болон Засгийн газарт тайлан мэдээ хүргүүлэх	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага болон Сангийн яамнаас шаардсан төслийн хэрэгжилттэй холбоотой тайлан, мэдээллийг тухай бүр гаргаж ажиллсан. Мөн Төсөл хэрэгжүүлэх нэгийн үйл ажиллагааны тайланг сар бүр Төслийн удирдлага, мэдээллийн системд байршуулна. Төслийн 2024 оны хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланг ТУХ-оор хэлэлцсний дараагаар АХБ-нд хүргүүлнэ. *Биелсэн 100%*
4.7	ЭЗХЯ, СЯ болон АХБ-аас зохион байгуулах сургалт, семинарт хамрагдах	Тайлант хугацаанд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд нь Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан нийт 15 сургалтанд хамрагдсан. *Биелсэн 100%*

Тайлант хугацаанд 4 арга хэмжээний хүрээнд 19 нэр төрлийн ажил төлөвлөснөөс 100%-ийн биелэлттэй 14 ажил, 90%-ийн биелэлттэй 1, 80%-ийн биелэлттэй 1, 50%-ийн биелэлттэй 3 ажил байна. Жигнэсэн дундаж үнэлгээ 90.52%-ийн биелэлттэй байна.

1.3 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН 2024 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол Улсын засгийн газар, Азийн хөгжлийн банк (АХБ) хооронд 2024 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр байгуулсан зээлийн гэрээний хүрээнд хэрэгжиж буй “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн төслийн удирдлагын баримт бичигт заасны дагуу АХБ-аас баталсан төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаатай холбоотой худалдан авалт болох VEH01, VEH02, POF01, POE01-2a: Lot 2a, POE01-2b: Lot 2b, POE01-1: Lot 1, POS02, POS01 дугаар бүхий Автомашин, Оффисын тавилга, Оффисын компьютер болон тоног төхөөрөмжийн худалдан авалтын сонгон шалгаруулалтыг хийж төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан.

Монгол Улсын засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн дагуу АХБ-ны зээлдэгчдэд зориулсан худалдан авах ажиллагааны журмаар тус сонгон шалгаруулалтыг “Харьцуулалтын тендер шалгаруулалт” (Request for Quotation) гэх аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг ашиглан бэлтгэж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулан ажилласан болно.

Уг харьцуулалтын тендерийг 2024 оны 05 дугаар сарын 06, 08 дугаар сарын 26-ны өдрүүдэд Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tender.gov.mn цахим сайтаар зарласан бөгөөд 05 дугаар сарын 13, 09 дүгээр сарын 03-ны өдрүүдэд тус тус тендер хүлээн авсан болно. POE1lot2 Багц 2 тендерийн хувьд нэг ч оролцогч үнийн санал ирүүлээгүй. Тиймээс үнийн саналын хүсэлтийг бараа нийлүүлэх боломжит компаниуд руу е-мэйл болон онлайнаар явуулж үнийн санал авч харьцуулсан бөгөөд нэг оролцогч компаниас бүх иж бүрдэл барааг худалдан авах боломжгүй учир хоёр компаниас худалдан авалтыг хийхээр санал болгосон болно.

Сонгон шалгаруулалтын үр дүнгийн тухай: Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД-ын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/102 тоот тушаалаар байгуулсан Үнэлгээний хороо 05 дугаар сарын 03, 21-ний өдрүүд болон 08 дугаар сарын 23, 09 дүгээр сарын 03-ны өдрүүдэд тус тус хуралдаж тендерийн баримт бичиг боловсруулж, үнэлгээг гүйцэтгэсэн.

Тус тендерийн үнэлгээний тайланг АХБ-руу 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр илгээсэн ба АХБ-аас хянан баталгаажуулж 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах зөвшөөрөл ирүүлсэн.

Тендер шалгаруулалтын үр дүн, мөн гэрээ байгуулах эрх олгох мэдэгдлийг ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга өгснөөр Тендерт шалгарсан компаниудтай гэрээ байгуулан ажиллаж гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан. Үүнд:

Гүйцэтгэгч нэр	Гэрээний дугаар	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ эхлэх огноо	Гэрээ дуусгавар болох огноо
"Анун" ХХК	ASDIP/20240202004POE1-ЭЗХЯ/113	83,063,000	6/18/2024	6/18/2024	6/30/2024
"Аргил сувд" ХХК	ASDIP/20240702002POE1LOT2-2-ЭЗХЯ/114	1,160,000	6/19/2024	6/19/2024	6/24/2024
"БСБ Электроникс" ХХК	ASDIP/20240702002POE1LOT2-ЭЗХЯ/110	6,849,300	6/17/2024	6/17/2024	6/21/2024
"Ай Ти Зон" ХХК	ASDIP/20240702001POE01-ЭЗХЯ/112	162,975,000	6/17/2024	6/17/2024	6/24/2024
"Диктум Фактум" ХХК	ASDIP/20240912006POS02	11,000,000	9/12/2024	9/12/2024	9/20/2024
"Эй Эй Ти Эс" ХХК	ASDIP/20240912007POS01	30,333,000	9/12/2024	9/12/2024	9/13/2024
"Таванбогд" ХХК	ASDIP/20240702003VEH01-ЭЗХЯ/111	566,000,000	6/17/2024	6/17/2024	9/17/2024

Бусад төлөвлөгдсөн ажлын хүрээнд:

1. **Төслийн хувь зөвлөх сонгон шалгаруулалт**

   CS06 – Худалдан авалтын зөвлөх, CS07- Бодлогын зөвлөх, CS08 – Засаглал, менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион байгуулсан:

   - 2024.10.23: ЭЗХЯ-ны ТНБД-ын 2024.10.18-ны өдрийн А/245 тушаалаар байгуулагдсан ТҮХ хуралдаж Хувь зөвлөхүүдийн сонгон шалгаруулалт хийх шийдвэр гаргав.
   - 2024.10.24 – 2024.10.30: Ажлын удирдамж /TOR/-ыг АХБ-наас зөвшөөрсний дагуу АХБ-ны CMS систем болон ЭЗХЯ-ны цахим хуудасанд дээр зарлаж, өргөдлүүд хүлээн авсан.
   - 2024.11.01 ТҮХ-хуралдаж ирүүлсэн оролцогчийн материалтай танилцав.
   - 2024.11.04: Үнэлгээний хороо хуралдаж Хувь зөвлөхөд ирүүлсэн материалд үнэлгээ хийж ЭЗХЯ-ны ТНБД-д зөвлөмж гаргав.
   - 2024.11.18: АХБ-ны журмын дагуу Submission 1 бэлтгэж, АХБ-руу зөвшөөрөл хүсэхээр илгээв.
     2024.11.20: АХБ-аас тодруулга хүсэлт ирүүлэв.
   - 2024.11.21: АХБ-д тодруулгын хариуг бэлтгэн, холбогдох баримт бичгийг эцэслэж хүргүүлэв.
   - 2024.11.28: АХБ-аас үл татгалзах хариу буюу зөвшөөрөл ирэв.
   - 2024.11.29: АХБ-ны зөвшөөрлийн дагуу 3 зөвлөхтэй гэрээ байгуулав.
   - 2024.12.02: АХБ-ны журмын дагуу Submission 2 бэлтгэж, АХБ-руу илгээв.
   - 2024.12.10: АХБ-наас Submission 2-г зөвшөөрч гэрээний дугаар ирүүлсэн.

2. PIO1: “Төслийн хэрэгжилтийн болон менежментийн дэмжлэг үзүүлэх, бодлого сайжруулах” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг:

   - 2024.11.01 – 2024.11.09: Ажлын даалгаварыг Төслийн дэд зохицуулагч болон Худалдан авалтын зөвлөхийг хамт эцэслэн боловсруулав.
   - 2024.11.09: Ажлын даалгаварын төслийг Төслийн захиралд танилцуулав.
   - 2024.11.11: Төслийн захирлын зөвлөмжийн дагуу холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан.
   - 2024.12.04: Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/295 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан “Төслийн хэрэгжилтийн болон менежментийн дэмжлэг үзүүлэх, бодлого сайжруулах” (PIO1) зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо

2024.12.04-нд хуралдаж Ажлын даалгаврыг үнэлгээний хороонд танилцуулсан.

- 2024.12.05: ТХН-ээс ЭЗХЯ-ны ТНБД-д ажлын даалгаварыг танилцуулж АХБ-нд хүргүүлэх зөвшөөрлийг илтгэх хуудсаар авсан.
- 2024.12.06: Төслийн захирлаас ажлын даалгаварт “Үл татгалзах” зөвшөөрөл хүсэх тухай хүсэлтийг АХБ-руу илгээв.
- 2024.12.10: АХБ-аас төсөвт өртөгт татвар багтсан эсэх тухай асуулга ирүүлэв.
- 2024.12.12: АХБ-наас ирүүлсэн асуулгын хариуг ТХН-ийн зүгээс хүргүүлэв.
- 2024.12.17: АХБ-наас Ажлын даалгавар /TOR/-ыг зөвшөөрч “Үл татгалзах” ирүүлсэн.
- 2024.12.23: АХБ-наас зөвшөөрсөн Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавр /TOR/-ыг ЭЗХЯ-ны ТНБД-аар батлуулах тухай илтгэх хуудас хүргүүлж батлуулсан.
- 2024.12.25: Тендерийн зарыг АХБ-ны CMS систем, ЭЗХЯ-ны цахим хуудас, төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn систем болон “Өдрийн сонин” дээр нэгэн зэрэг тавьж тендер шалгаруулалтыг эхлүүлсэн.

1.4 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН:

Төсөл, арга хэмжээний төсөв, санхүүгийн эх үүсвэр

Хөтөлбөрийн нийт өртгийг 735.0 сая ам.доллар байхаар тооцсон. Хөтөлбөрийн 1, 2, 4-р үр дүнгийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэг нь 617.4 сая ам.доллар байна (хүснэгт 1). Санхүүгийн зуучлалын зээл (СЗЗ)-ээр хэрэгжүүлэх үр дүн 3-ын өртөг 117.6 сая ам.доллар болно. Хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэгт барилгын ажил, тоног төхөөрөмж, БАХ, хоршоодод үзүүлэх дэмжлэг, зураг төсөл, барилгын хяналт, төслийн удирдлага, хэрэгжилтэд үзүүлэх дэмжлэг, хамгаалал, магадлан шинжилгээ, зөвлөх үйлчилгээ хамаарна.

Хүснэгт 1: Зардлын хураангуй
(сая ам.доллар)

Зүйл			Мөнгөн дүн[a]
A.	**A.**	**Суурь зардал[b]**	
	1.	Үр дүн 1: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, нүүрстөрөгч багатай, хүний сонирхлыг татсан аймаг, сумын төвийг хөгжүүлэх	395.7
	2.	Үр дүн 2: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулах, нүүрстөрөгчийн хуримтлалыг нэмэгдүүлэх, МАА-г тогтвортой эрхлэх бэлчээрийн менежмент хэрэгжүүлэх	99.2
	3.	Үр дүн 4: Нүүрстөрөгч багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ХАА-нутаг дэвсгэрийн хөгжлийн чадавхыг бэхжүүлэх, бодлогын шинэчлэл хийх	38.5
		Дүн (A)	**533.4**
B.	**B.**	**Магадалшгүй зардал[c]**	**59.3**
C.	**C.**	**Хэрэгжилтийн явцад тооцох санхүүжилтийн төлбөр[d]**	**24.7**
		Нийт (A+B+C)	**617.4**

Азийн хөгжлийн банкнаас 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 395,000.00 ам.доллар(WA00001)-ын урьдчилгаа дансны эхний санхүүжилт орж ирсэн. Төслийн урьдчилгаа дансанд 196,345.69 ам.доллар (WA00002)-ын нөхөн дүүргэлт 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр хийгдсэн.

Хөтөлбөрийн 1-р үе шатны нийт төсөвт өртөг 270,000,000.00 ам.доллар бөгөөд тайлант оны байдлаар төслийн үйл ажиллагааны зардалд нийт 494,374.95 ам.доллартай тэнцэх 1,679,007,720.88 төгрөгийг зарцуулсан. Энэхүү зардал нь АХБ-ны L4307-MON дугаартай хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд санхүүжилт хийгдсэн.

Жилийн эцсийн байдлаар АХБ-ны L4307-MON дугаартай хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн хүрээнд 594,395.97 ам.долларын ашиглалт гарсан.

№	Код	Зардлын нэр	Хуваарилагдсан төсөв	Гэрээний дүн	Зарцуулалт	Зарцуулаагүй үлдэгдэл
01	0300	Ажил (Нийтийн эзэмшлийн барилга байгууламжууд); Тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ (тогтвортой бэлчээр, хөдөө аж ахуйн менежментээс бусад); Усалгааны системийн үндсэн ажлууд; ТХН-ийн үйл ажиллагааны зардал	29,600,000.00	451,693.42	196,345.69	29,403,654.31
02	1200	Тогтвортой бэлчээр, хөдөө аж ахуйн менежментийн тоног төхөөрөмж	1,090,000.00	0.00	0.00	1,090,000.00
03	9800	Малын эрүүл мэндийн үйлчилгээ	4,360,000.00	0.00	0.00	4,360,000.00
04	2100	Тогтвортой бэлчээр, хөдөө аж ахуйн менежментийн зөвлөх үйлчилгээ	1,130,000.00	0.00	0.00	1,130,000.00
05	6900	Хүүгийн зардал	2,620,000.00	0.00	3,050.28	2,616,949.72
06	9300	Хуваарилагдаагүй зардал	6,200,000.00	0.00	0.00	6,200,000.00
99	9900	Урьдчилгаа дансны дүн	0.00	0.00	395,000.00	-395,000.00
		ДҮН	**45,000,000.00**	**451,693.42**	**594,395.97**	**44,405,604.03**

L4307-MON: Зээлийн хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээний зарцуулалтын дэлгэрэнгүй тооцоо:

Гэрээний дугаар	Гэрээний төрөл	Утга	Гүйцэтгэгчийн нэр	Дүн	Гэрээ байгуулагдсан огноо	Зарцуулалт (Өссөн дүнгээр)
				ам.доллараар		ам.доллараар
0001	Бараа	VEH01: НТХН-ийн тээврийн хэрэгсэл	Таван богд ХХК	$150,503.38	2024-06-17	$0.00
0002	Бараа	POE01-1: Lot 1: Компьютер, тоног төхөөрөмж	Ай Ти Зон ХХК	$43,821.86	2024-06-17	$43,821.86
0003	Бараа	POE01-2a: Lot 2a: Оффисын тоног төхөөрөмж	Аргил сувд ХХК	$311.91	2024-06-19	$311.91
0004	Бараа	POE01-2b: Lot 2b: Оффисын тоног төхөөрөмж	БСБ электроникс ХХК	$1,841.69	2024-06-17	$1,841.69
0005	Бараа	POF01: Оффисын тавилга	Анун ХХК	$22,331.79	2024-06-18	$22,331.79
0006	Зөвлөхөөс бусад үйлчилгээ	Үйл ажиллагааны зардал (2024 оны 4-8 сар)	НТХН	$128,038.44	2024-04-26	$128,038.44
0007	Бараа	POS01: Оффисын тоног төхөөрөмж	Эй Эй Ти Эс ХХК	$8,065.76	2024-09-12	$0.00
0008	Бараа	POS02: Санхүүгийн програм	Диктум фактум ХХК	$2,924.98	2024-09-12	$0.00
0009	Хувь зөвлөх	CS06: Худалдан авах ажиллагааны зөвлөх	Т.Энхнаран	$21,965.75	2024-11-29	$0.00
0010	Хувь зөвлөх	CS07: Бодлогын зөвлөх	Ш.Түвдэндорж	$35,943.93	2024-11-29	$0.00
0011	Хувь зөвлөх	CS08: Засаглал, менежментэд дэмжлэг үзүүлэх зөвлөх	Д.Болорсүрэн	$35,943.93	2024-11-29	$0.00
Дүн				**$451,693.42**		**$196,345.69**

АХБ-ны L4306-MON дугаартай зээлийн хэлэлцээрийн хүрээнд 35,250.00 ам.долларын хүүгийн зардлын ашиглалт гарсан.

№	Код	Зардлын нэр	Хуваарилагдсан төсөв	Гэрээний дүн	Зарцуулалт	Зарцуулаагүй үлдэгдэл
01A	0300	Ажил-Зам, гудамж талбайн тохижилт	10,250,000.00	0.00	0.00	10,250,000.00
01B	0301	Ажил-Дулаан хангамж, хог хаягдлын менежмент болон бусад дэд бүтцийн ажлууд, инкубатор, инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах	27,000,000.00	0.00	0.00	27,000,000.00
02	6600	Хүүгийн зардал, хариуцлагын төлбөр	2,530,000.00	0.00	35,250.00	2,494,750.00
03	9300	Хуваарилагдаагүй зардал	5,220,000.00	0.00	0.00	5,220,000.00
99	9900	Урьдчилгаа дансны дүн	0.00	0.00	0.00	0.00
		ДҮН	**45,000,000.00**	**0.00**	**35,250.00**	**44,964,750.00**

Азийн хөгжлийн банкны хүрээнд захиран зарцуулж буй Уур амьсгалын ногоон сангийн L8441-MON дугаартай зээлийн хэлэлцээрийн хүрээнд 128,288.89 ам.долларын хүүгийн зардлын ашиглалт гарсан байна.

№	Код	Зардлын нэр	Хуваарилагдсан төсөв	Гэрээний дүн	Зарцуулалт	Зарцуулаагүй үлдэгдэл
1	1	Эрчим хүчний хэмнэлт (сэргээгдэх эрчим хүч); урсгал зардал (ашиглалт, засвар үйлчилгээ)	11,220,000.00	0.00	0.00	11,220,000.00
2	2	Санхүүгийн зуучлалын зээлийн бүрэлдэхүүн хэсэг	37,510,000.00	0.00	0.00	37,510,000.00
3	3	Үйлчилгээний хураамж, хариуцлагын төлбөр	1,080,000.00	0.00	128,288.89	951,711.11
4	4	Хуваарилагдаагүй зардал	390,000.00	0.00	0.00	390,000.00
		ДҮН	**50,200,000.00**	**0.00**	**128,288.89**	**50,071,711.11**

Төслийн бусад зээл, тусламжийн эх үүсвэрийн хуваарилагдсан төсвөөс тайлант хугацаанд гэрээ байгуулагдаагүй, санхүүжилт хийгдээгүй байна.

Хүснэгт 2-т төслийн 2024 оны санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг эдийн засгийн ангиллаар, төгрөгөөр харуулав.

Төслийн төсөв гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв /тайлант хугацааны/	Нийт гүйцэтгэл	Баланс
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДүН	**1,839,322,800.00**	**1,679,007,720.88**	**160,315,079.12**
УРСГАЛ ЗАРДАЛ	1,279,322,800.00	1,164,462,266.34	114,860,533.66
БАРАА, АЖИЛ үЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,279,322,800.00	1,164,462,266.34	114,860,533.66
Үндсэн цалин	783,990,800.00	678,208,328.72	105,782,471.28
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	**96,822,200.00**	**95,787,992.00**	**1,034,208.00**
Байрны түрээс	96,822,200.00	95,787,992.00	1,034,208.00
Хангамж, бараа материалын зардал	**32,960,000.00**	**29,884,734.51**	**3,075,265.49**
Бичиг хэрэг	10,730,000.00	10,719,000.00	11,000.00
Тээвэр, шатахуун	16,570,000.00	16,531,363.60	38,636.40
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,660,000.00	2,634,370.91	3,025,629.09
Эд хогшил, урсгал засварын зардал	**268,675,500.00**	**268,527,547.27**	**147,952.73**
Багаж, техник, хэрэгсэл	193,075,500.00	193,015,727.27	59,772.73
Тавилга	75,600,000.00	75,511,820.00	88,180.00
Томилолт зочны зардал	**73,714,300.00**	**73,629,918.00**	**84,382.00**
Дотоод албан томилолт	73,714,300.00	73,629,918.00	84,382.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж	**22,560,000.00**	**18,181,845.84**	**4,378,154.16**
Бусад нийтлэг АҮТХураамж	7,478,500.00	7,420,740.30	57,759.70
Даатгалын үйлчилгээ	11,000,000.00	8,703,840.00	2,296,160.00
Мэдээлэл технолгийн үйлчилгээ	3,906,500.00	1,887,597.54	2,018,902.46
Банкны шимтгэл	175,000.00	169,668.00	5,332.00
Бараа үйлчилгээний бусад зардал	**600,000.00**	**241,900.00**	**358,100.00**
Бараа үйлчилгээний бусад зардал	600,000.00	241,900.00	358,100.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	**560,000,000.00**	**514,545,454.54**	**45,454,545.46**
Бусад хөрөнгө /НТХН тээврийн хэрэгсэл/	560,000,000.00	514,545,454.54	45,454,545.46

1.5 ТӨСЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

УУР АМЬСГАЛЫН НОГООН САН

ЕВРОПЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК

ТӨСЛИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2024 он 4 дүгээр улирал

АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ

2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

ГАРЧИГ

I. ХУРААНГУЙ
II. ТӨСӨЛД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ
III. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ
    1. Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал
    2. Төслийн хүлээгдэж буй үр нөлөө
    3. Үр дүнд хүрч буй байдал ба гүйцэтгэлийн хувь
    5. Үйл ажиллагаануудын хэрэгжилт
IV. ТӨСЛИЙН ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ
V. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ
    1. Стратегийн зорилготой нийцтэй байдал
    2. Бодлогын орчин
    3. Эдийн засаг, санхүүгийн үндэслэл
    4. Институцийн хүчин чадал
    5. Оролцоо ба өмчлөл
    7. Жендер
VI. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД
VII. ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

I. ХУРААНГУЙ

Төслийн нэр:	Аймаг, сумын төвийн ногоон, бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр
Санхүүжүүлэгч байгууллага:	Азийн хөгжлийн банк (АХБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС), Европын хөрөнгө орууулалтын банк (ЕХОБ)

Санхүүжилтийн хэмжээ:

Эх үүсвэр	Зээл	Буцалтгүй тусламж	Бусад
АХБ	270.0	3.0	
УАНС	130.0	45.0	-
ЕХОБ	150.0	30.0	-
МУ ЗГ			127.0
ХХ	-	-	31.7
АХ			17.7
Нийт	735 сая ам.доллар		

Төсөл, арга хэмжээний зорилго:	Тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, хүн ам амьдрахад таатай хот, суурин газар (аймаг, сумын төв)-ыг байгуулж, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх, орон нутгийн ногоон хөгжлийн загвар, шинэчлэлийг хөхүүлэн дэмжих, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлэх зорилготой болно.
Төсөл хэрэгжих хугацаа:	Уг төсөл нь 3 үе шаттай хэрэгжинэ. ✓ Төслийн 1 дүгээр үе шат нь 2024-2026 он ✓ Төслийн 2 дугаар үе шат нь 2027-2028 он ✓ Төслийн 3 дугаа үе шат нь 2029-2034
Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага:	Эдийн засаг, хөгжлийн яам;
Хамтран хэрэгжүүлэгч байгууллага:	Сангийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.
Төсөл хэрэгжих орон нутаг:	Төслийн I үе шатыг Ховд, Баян Өлгий, Увс аймгууд болон төслийн I үе шатны явцад хийгдэх судалгаанд үндэслэн, бэлэн байдал хангасан 8 нэмэлт аймагт буюу нийт 11 аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

II. ТӨСӨЛД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ

1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц орон тоог нэмэх тухай

Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны 10 сарын 06-ны өдрийн А/62 тоот тушаалаар байгуулсан Төслийн удирдах хорооны ээлжит хурал 2024 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр зохион байгуулагдсан. Энэхүү хурлаар төслийн хэрэгжилтийн явц, цаг хугацаандаа хэрэгжихэд тулгамдаж буй асуудал, тэдгээрийн шийдэл болон Төслийн худалдан авах ажиллагаа, санхүүгийн төлөвлөгөө, ТХН-ийн бүтэц орон тооны шинэчлэлийн талаар хэлэлцсэн.
Ийнхүү төслийн удирдах хороог батлагдсан ТХН-ийн шинэчилсэн бүтэц орон тоог нэмэх хүсэлтийг СЯ-нд хүргүүлж, төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд нэн шаардлагатай орон тоонууд болох төслийн менежментийн асуудал хариуцсан дэд зөвлөх, нийгэм жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн, сангийн удирдлага хариуцсан санхүүгийн ажилтан, байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн гэх мэт 16 ажилтны орон тоог нэмж батлуулсан.

Одоогоор 2025 онд шаардлагатай ажилтнуудын ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтын шатандаа явж байна. Иймд цаашид төсөл хэрэгжүүлэх нэгж цаг алдалгүй дээрх батлагдсан орон тооны ажилчдыг яаралтай сонгон шалгаруулах шаардлагатай.

2. Азийн хөгжлийн банктай хийсэн зээлийн эхлэлийн ажлын хэсгийн "Харилцан ойлголцлын санамж бичиг”-ээр баталгаажсан дараах шийдвэрүүдийг хэрэгжүүлэх тухай;

2024 оны 11-р сарын 5-15-ны өдрүүдэд Азийн хөгжлийн банкаас (АХБ) Аймаг, сумдын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1-р үе шат (АСБНХХОХ)-ыг эхлүүлэх ажлын хэсэг Монгол Улсад ирж ажилласан. Мөн Европын Хөрөнгө оруулалтын банкны (ЕХОБ) баг онлайнаар оролцов. Тус томилолтын гол зорилго нь Баян-Өлгий, Ховд, Увс аймгуудад төсөл хэрэгжих зорилтод газруудтайгаа танилцаж, Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), гүйцэтгэгч байгууллагын (ХБ) төлөөлөгчидтэй уулзаж, ярилцаж, зөвшилцөх; Сангийн яам (СЯ), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (ХББОСЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) – хэрэгжүүлэгч байгууллагууд (ХБ); мөн дээрх аймгуудын аймаг, сумын засаг захиргаа төслийн хэрэгжилтийн талаарх асуудлуудаар:

- ✓ Төслийн хамрах хүрээ, үр дүн, хэрэгжүүлэх хуваарь, зорилтот түвшин;
- ✓ Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх зэрэг төслийн худалдан авалт, зөвлөхийг сонгон шалгаруулах, гэрээний менежмент;
- ✓ Зээл, тусламжийн зарцуулалт, санхүүгийн удирдлага, тайлан, аудит;
- ✓ Нийгэм жендэр, нүүлгэн шилжүүлэлт, байгаль орчны хамгаалал зэрэг төслийн хамгаалалт;
- ✓ Хяналт-шинжилгээ, үнэлгээ, төслийн гүйцэтгэлийн хяналтын систем ба Төлөвлөлт ба Хяналтын хүрээ;
- ✓ Зээлийн гэрээг дагаж мөрдөх;

- ✓ Ye шат-2 болон Ye шат-3 төслүүдийн үе шатуудыг боловсруулах төлөвлөгөө зэргийг хэлэлцэж харилцан ойлголцлынн санамж бичгийг баталгаажуулсан. /Хавсралт-1 үзүүлэв/

Иймд дээрх харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хийгдсэн дараах ажлуудыг үе шаттай зохион байгуулж хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Зөвлөхийн сонгон шалгаруулалт:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн баг 2024 оны 12-р сарын 31-ний дотор багтаан үндсэн зөвлөх үйлчилгээг олон улсын нээлттэй тендерээр сонгон шалгаруулах ажлын хүрээнд тус зөвлөх үйлчилгээний багцуудын ажлын даалгавар, зардлын тооцоог шинэчлэн ажиллаж байна. Эдгээр зөвлөх үйлчилгээний багцад дараах зүйлс багтана:

- ✓ DDS1: Ye шат 1-ийн нарийвчилсан загвар болон үнэлгээ;
- ✓ FDS2: Ye шат 2-ын ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, хяналт;
- ✓ PIO1: Төслийн хэрэгжилт, удирдлагын дэмжлэг, бодлогыг сайжруулах;
- ✓ PIO2: Үр дүн 2-ын төслийн хэрэгжилтийн техникийн туслалцаа (бэлчээрийн менежмент, усалгааны схем, мал үржүүлгийн болон мал эмнэлгийн үйлчилгээ, мөшгөлт, баталгаажуулалтын дэмжлэг, бодлогыг сайжруулах зэрэг); ба (v) PIO3: Үр дүн 3-ын төслийн хэрэгжилт ба менежментийн дэмжлэг (ногоон агробизнесийн санхүүгийн зуучлалын зээл)

Одоогийн байдлаар PIO1: Төслийн хэрэгжилт, удирдлагын дэмжлэг, бодлогыг сайжруулах зөвлөх үйлчилгээний олон улсын нээлттэй тендерийг 2024 оны 12 сарын 25-ны өдөр Азийн хөгжлийн банкны систем / ADB Consultant Management System/, Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn болон өдрийн сонинд тус тус нээлттэй зарласан. Тус тендерийн материал хүлээж авах эцсийн хугацаа 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр дуусна.

Иймд дээрх үлдсэн 3 зөвлөх үйлчилгээний олон улсын нээлттэй тендерийн үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2. Төслийн Ye шат-2-ын бэлтгэл:

АХБ-ны Монгол Улсад хийх хөрөнгө оруулалтын төслийн үечилсэн санхүүжилтийн хүсэлтийг 2026 оны 4-р улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тул хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Ye шат-2-ыг бэлтгэх ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн. Иймд Эдийн засгийн хөгжлийн яам нь Монгол Улсын Засгийн газраас тодорхойлсон хөдөө аж ахуйг хөгжүүлэх нэн тэргүүний байршлыг Санхүүжилтийн Ерөнхий хэлэлцээрийн 4-р жагсаалтад заасан сонгон шалгаруулалтын шалгуурт үндэслэн Ye шат 2-ын аймгийн сонгон шалгаруулалтыг эцэслэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн.

III. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

1. <u>Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал</u>

“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, хүн ам амьдрахад таатай хот, суурин газар (аймаг, сумын төв)-ыг байгуулж, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх, орон нутгийн ногоон хөгжлийн загвар, шинэчлэлийг хөхиүлэн дэмжих, хүнсний гол нэрийн

бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлэх зорилго нь тэргүүлэх ач холбогдолтой хэвээр байна.

2. Төслийн хүлээгдэж буй үр нөлөө

Уг хөтөлбөр нь “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичгийн хүрээнд Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, “Ковид-19” цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх, ногоон хөгжлийг дэмжих зорилтуудтай нийцсэн.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан чиглэлүүд болон хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдаж байна. Тус хөтөлбөр нь хүнсний нийлүүлэлтийн сүлжээ, тогтолцоо, хүнсний аюулгүй байдлыг хангах, хот хөдөөгийн уялдаа холбоог дэмжих, аймаг, сумын төвүүдэд хүн амьдрахад таатай орчныг бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох ногоон, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх үндэс болох юм.

Энэхүү хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих инженерийн дэд бүтэц, тээвэр логистикийн төвийг байгуулах, хөдөө аж ахуйн салбарт оруулах ногоон санхүүжилтийг дэмжиж (тухайлбал: ногоон зээл, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл), хөдөө аж ахуйн менежментийг сайжруулан, түүнийг хянах тогтолцоог бүрдүүлнэ. Дээрх төлөвлөж буй арга хэмжээг 17 аймгийн 52 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

№	Аймгийн нэр	Хамрах сумууд				Нийт
		1	2	3	4	
1	Архангай	Эрдэнэбулган	Эрдэнэ-мандал	Хотонт	Тариат	4
2	Булган	Булган	Хутаг-өндөр	Дашинчилэн	Хишиг-Өндөр	4
3	Дорнод	Хэрлэн	Халхгол	Баян-Уул	Дашбалбар	4
4	Сэлэнгэ	Сүхбаатар	Ерөө	Сайхан	Мандал	4
5	Төв	Зуунмод	Баянчандмань	Лүн	Угтаалтцайдам	4
6	Хэнтий	Хэрлэн	Батноров	Бор-Өндөр	Биндэр	4
7	Ховд	Жаргалант	Булган	Дарви	Манхан	4
8	Увс	Улаангом	Давст	Өмнөговь	Наранбулаг	4
9	Хөвсгөл	Мөрөн	Хатгал	Тариалан		3
10	Говь-Алтай	Есөнбулаг	Цогт	Баян-уул		3
11	Баян-Өлгий	Өлгий	Дэлүүн			2
12	Дундговь	Сайнцагаан	Эрдэнэдалай			2
13	Дархан-Уул	Дархан	Орхон			2
14	Өвөрхангай	Арвайхээр	Есөнзүйл			2
15	Баянхонгор	Баянхонгор	Бууцагаан			2
16	Завхан	Улиастай	Тосонцэнгэл			2
17	Дорноговь	Сайншанд	Замын-Үүд			2
Нийт	**17 аймаг**	**52 сум**				**52**

Хөтөлбөрийн I үе шатыг Ховд, Баян-Өлгий, Увс аймгууд болон хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийгдэх судалгаанд үндэслэн, бэлэн байдал хангасан 8 нэмэлт аймагт буюу нийт 11 аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Хөтөлбөр нь нийт 10 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд дунд хугацааны бодлогын баримт бичигтэй

бүрэн нийцсэн ба урт хугацааны бодлогын баримт бичгийн арга хэмжээг хэрэгжүүлэх суурь нөхцөл нь болно.

3. Үр дүнд хүрч буй байдал ба гүйцэтгэлийн хувь

Дэд бүрэлдэхүүн хэсгүүд	Хүлээгдэж буй үр дүн	Гүйцэтгэлийн хувь	Тайлбар
Төслийн менежмент, институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх	Төслийн үйл ажиллагаа хэвийн явуулахад шаардлагатай хүний нөөц, ажлын байраар хангаж холбогдох сургалтуудад хамруулах	60%	Төслийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах шаардлагатай 41 хүний орон тоог баталсан ба одоогоор ТХН 21 ажилтанг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажилласнаас одоо 17 ажилтны гэрээ хүчин төгөлдөр байна. Мөн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэвийн тогтвортой үйл ажиллагааг хангах чиглэлээр оффисын тавилга, тоног төхөөрөмж, авто машин худалдан авалтууд бүрэн хийгдэж, суурьлагдсан байна.
Үр дүн 1. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгч бага ялгаруулдаг, хүн ам суурьших аймаг болон сумын төвүүдийг хөгжүүлэх	"Аймаг,сумын төвүүдийн дэд бүтцийг байгуулах" ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэх, менежментийн бодлогыг дэмжих зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, , ажил эхлүүлэх; (Багцын дугаар: PIO1, Төсөвт өртөг: 4,346,000.00 ам.доллар)	100%	PIO1: Төслийн хэрэгжилт, удирдлагын дэмжлэг, бодлогыг сайжруулах зөвлөх үйлчилгээний олон улсын нээлттэй тендерийг 2024 оны 12 сарын 25-ны өдөр Азийн хөгжлийн банкны систем / ADB Consultant Management System/, Төрийн худалдан авах ажиллагааны tender.gov.mn болон өдрийн сонинд тус тус нээлттэй зарласан. Тус тендерийн материал хүлээж авах эцсийн хугацаа 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр дуусна.
Үр дүн 1. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгч бага ялгаруулдаг, хүн ам суурьших аймаг болон сумын төвүүдийг хөгжүүлэх	Төслийн I үе шатны нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтад хяналт тавих зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах; (Багцын дугаар: DDS1, Төсөвт өртөг: 7,035,395.00 ам.доллар)	40%	Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын боловсруулж байгаа шаардлагатай өөрчлөлтүүдийг зохих түвшинд шинэчлэж холбогдох газруудаар хянан баталгаажуулах ажил хийгдэж байна. 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тус зөвлөх үйлчилгээний олон улсын нээлттэй тендерийг сонгох шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.
Үр дүн 2. Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлттэй, тогтвортой бэлчээр болон хөдөө аж ахуйн	"Бэлчээрийн менежментийг сайжруулах" ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер	40%	Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын боловсруулж байгаа шаардлагатай өөрчлөлтүүдийг зохих түвшинд шинэчлэж холбогдох газруудаар хянан баталгаажуулах ажил хийгдэж байна. 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тус зөвлөх үйлчилгээний олон улсын нээлттэй тендерийг

менежментийг хэрэгжүүлэх	зохион байгуулах, (Багцын дугаар: PIO2, Төсөвт өртөг: 8,450,472.00 ам.доллар)		сонгох шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.
Үр дүн 3. Нүүрстөрөгч бага ялгаруулдаг, уур амьсгалд тэсвэртэй малын болон агро-бизнесийн өртгийн сүлжээг бий болгох хүртээмжтэй санхүүжилт олгох Үйл ажиллагаануудын хэрэгжилт	"Агро-Бизнес эрхлэгчдэд бага хүүтэй,ногоон ХАА-н бизнес зээл" ажлын хүрээнд ажлын хүрээнд төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ авах олон улсын нээлттэй тендер зохион байгуулах, гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах (Багцын дугаар: PIO3, Төсөвт өртөг: 3,000,000.00 ам.доллар)	40%	Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын боловсруулж байгаа шаардлагатай өөрчлөлтүүдийг зохих түвшинд шинэчлэж холбогдох газруудаар хянан баталгаажуулах ажил хийгдэж байна. 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тус зөвлөх үйлчилгээний олон улсын нээлттэй тендерийг сонгох шалгаруулалтыг зарлахаар ажиллаж байна.

4. <u>Үйл ажиллагаануудын хэрэгжилт</u>

А. Төслийн худалдан авалтын төлөвлөгөө, түүний хэрэгжилт

“АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны худалдан авалтын төлөвлөгөөг 2024 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн ТУХ-ын 2 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан.

№	Ажлын нэр	Тендер зарлах огноо		Гэрээ байгуулсан огноо	Гэрээний үнэ (ам.доллар)		Тайлбар
		Төсөв	Гүйцэтгэл		Төсөв	Гүйцэтгэл	
1	"Нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтад хяналт тавих" зөвлөх үйлчилгээ	2024.12.15			7,035,395		Тус зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг эцэслэж, ажлын давхардлыг бууруулах ажил хийгдэж байна.
2	Төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг бодлогыг сайжруулах " зөвлөх үйлчилгээ	2024.10.15	2024.12.25		4,346,000		2024 оны 12 сарын 25-ны өдөр /ADB Consultant Management System/, tender.gov.mn болон өдрийн сонинд зарласан. Материал хүлээж авах эцсийн хугацаа 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдөр дуусна.
3	Үр дүн 2-ын төслийн хэрэгжилтийн техникийн туслалцаа" (үүнд	2024.12.15			8,450,472		

	бэлчээрийн менежмент, усжуулалтын систем, малын үржил,мал эмнэлгийн үйлчилгээ, гэрчилгээжүүлэлтийн дэмжлэг бодлогыг дэмжих) зөвлөх үйлчилгээ						Зөвлөх сонгон шалгаруулахтай холбоотой зөвлөхийн ажлын даалгавар бэлтгэгдсэн ба үнэлгээний хороо байгуулах хүсэлтийг ЭЗХЯ-нд хүргүүлсэн.
4	Үр дүн 2-ын төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг" (ногоон ХАА-н бизнест зориулсан санхүүгийн зуучлалын зээл) зөвлөх үйлчилгээ	2024.12.15			5,100,000		
5	Оффисын тавилга	2024.05.10	2024.05.06	2024.06.17	26,737	24,474	Гэрээ хийгдсэн.
6	Компьютер, тоног төхөөрөмж	2024.05.10	2024.05.06	2024.06.17	58,856	43,797	Гэрээ хийгдсэн
7	Автомашин	2024.05.10	2024.05.06	2024.06.17	166,579.35	152,103	Гэрээ хийгдсэн
8	Оффисын тавилга	2024.10.15	2024.11.01	2024.11.20	100,114.75	10,985.49	Гэрээ хийгдсэн.
9	Худалдан авах ажиллагааны зөвлөх			2024.11.29	21,955.29	21,955.29	Гэрээ хийгдсэн
10	Бодлогын зөвлөх			2024.11.29	35,926.80	35,926.80	Гэрээ хийгдсэн
11	Засаглал ба менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх			2024.11.29	35,926.80	35,926.80	Гэрээ хийгдсэн
Нийт дүн					**25,836,698.04**	**325,168.38**	

Б. Сургалтанд хамрагдсан байдал

Тайлант хугацаанд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд нь Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан нийт 11 сургалтанд хамрагдсан.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн үйл ажиллагааны тайлан:

№	Сургалтын нэр	Сургалтын огноо	Зохион байгуулагч	Оролцсон ТХН-ийн ажилтан
1	Гадаад зээл тусламжийн удирдлага зохицуулалтын шинэ журмын танилцуулга	2024.02.08	Сангийн яам	• Төслийн зохицуулагч • Санхүүгийн ажилтан • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
2	Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем сургалт	2024.02.23	ТХАА-ны сургагч багш Батбаяр	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
3	АХБ -ны зөвлөх үйлчилгээний сургалт 1	2024.02.26	АХБ-ны ХАА-ны ахлах мэргэжилтэн Ж.Батцэнгэл	• Төслийн зохицуулагч • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
4	Авлигатай тэмцэх шударга ёсны боловсрол олгох сургалт	2024.02.28	АХБ	• Төслийн зохицуулагч • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
5	Төрийн худалдан авах ажиллагааны цахим сургалт	2024.02.29	ТХАА-ны сургагч багш Содгэрэл	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан

6	АХБ -ны зөвлөх үйлчилгээний сургалт 2	2024.03.05	АХБ-ны ХАА-ны ахлах мэргэжилтэн Ж.Батцэнгэл	• Төслийн зохицуулагч • Санхүүгийн ажилтан • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
7	“Strengthening Safeguards Compliance in Mongolia” 3 модул сургалт	2024.03.19-21	АХБ, сургагч багш Реден Жон Балсоро, Мариа Лорена, Мөнхзул	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
8	Гэрээний менежментийн сургалт	2024.05.29	АХБ, сургагч багш Глен Харрис	• Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
9	Зээл, тусламжийн зарцуулалтын семинар	2024.04.15-17	АХБ	• Төслийн зохицуулагч • Санхүүгийн ажилтан
10	ФИДИК барилгын ажлын гэрээний дунд шатны мэдлэг олгох богино хугацаат сургалт	2024.06.12-14	АХБ, Монголын авто замчдын холбоо	• Мал аж ахуй, бэлчээрийн менежмент хариуцсан дэд зохицуулагч • Санхүүгийн ажилтан • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан • Хот байгуулалтын мэргэжилтэн
11	Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн систем (ODAMIS)-ийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-д шилжүүлэх сургалт	2024.07.05	Сангийн яам	• Санхүүгийн ажилтан • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
12	2024 LORTA нөлөөллийн үнэлгээний дизайны семинар /2024 LORTA Impact Evaluation Design Workshop/	2024.10.01-2024.10.05	Уур амьсгалын ногоон сангаас зохион байгуулсан	• Ерөнхий инженер • Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан
13	Байгаль орчны менежментийн сургалт	2024.12.09	Азийн хөгжлийн банк	• Хот байгуулалтын мэргэжилтэн
14	Хяналт-шинжилгээний үнэлгээний сургалт	2024.12.10	Сангийн яам	• Хяналт-шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн
15	PIMIS системд шилжих тухай онлайн сургалт	2024.12.13	Сангийн яам	• Нийт ажилчид

IV. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

1. Стратегийн зорилготой нийцтэй байдал

“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, хүн ам амьдрахад таатай хот, суурин газар (аймаг, сумын төв)-ыг байгуулж, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх, орон нутгийн ногоон хөгжлийн загвар, шинэчлэлийг хөхиүлэн дэмжих, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлэх зорилго нь тэргүүлэх ач холбогдолтой хэвээр байна.

2. Бодлогын орчин

Монгол Улсын Засгийн газраас уламжлалт мал аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй бодлогын чанартай дараах томоохон өөрчлөлтүүдтэй төслийн үйл ажиллагаанд тусгах шаардлагатай.

3. Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн “Шинэ хоршоо хөдөлгөөн” өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжих 5 их наядын "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөө;

4. УИХ-аар 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан “Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль”;

5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан боловсруулсан “Малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолоор хэрэгжих “Цагаан алт” үндэсний хөтөлбөр.

6. Эдийн засаг, санхүүгийн үндэслэл

Хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк (АХБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС) болон Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)-ны нэн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Төслийн 1, 2, 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт санхүүжилт 735.0 сая ам.доллар байх ба дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Энгийн болон хөнгөлөлттэй зээл нийт 550 сая ам.доллар /Үүнд: АХБ-ны 270,0 сая ам.доллар, Уур амьсгалын ногоон сангийн 130,0 сая ам.доллар, Европын хөрөнгө оруулалтын банкны 150,0 сая ам.доллар/;
2. Буцалтгүй тусламж нийт 78.0 сая ам.доллар /Үүнд АХБ-ны 3,0 сая ам.доллар, Уур амьсгалын ногоон сангийн 45,0 сая ам.доллар, Европын хөрөнгө оруулалтын банкны 30,0 сая ам.доллар/;
3. Засгийн газрын оролцоо 75.3 сая ам.доллар /Үүнд: Бүтээн байгуулалтын ажилтай холбоотой НӨАТ, гаалийн албан таварын чөлөөлөлт, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардал/;
4. Хувийн хэвшил, банкны салбар болон бусад төсөлд оролцогч талуудын санхүүжилт 31.7 сая ам.доллар /Үүнд: Төслийн хүрээнд үр шим хүртэх малчдын бүлэг, аж ахуй нэгж, олон нийтийн зүгээс хувь нэмэр оруулах хөдөлмөр, эд материал болон мөнгөн хөрөнгө оруулалтыг хамруулан тооцсон/.

Хөтөлбөрийн 1 дүгээр үе шат буюу 2024-2026 онуудад зарцуулагдах санхүүжилтийн дүн:

Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төслийн санхүүжилт 270.0 сая ам.доллар байх ба үүнээс:

- ✓ Энгийн болон хөнгөлөлттэй зээл 193.1 сая ам.доллар;
- ✓ Буцалтгүй тусламж 38.5 сая ам.доллар;
- ✓ Засгийн газрын оролцоо 20.7 сая ам.доллар;
- ✓ Хувийн хэвшил, банкны салбар болон бусад төсөлд оролцогч талуудын санхүүжилт 17.7 сая ам.доллар байна

7. Институцийн хүчин чадал

"АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Монгол Улсын Сангийн сайдын 210 дугаар тушаалын хавсралтаар "Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай" төслийн хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоонд өөрчлөлт орсон. Одоогоор төсөл хэрэгжүүлэх нэгж нийт 41 ажилтантай гэрээ байгуулахаас 21 ажилтантай гэрээ байгуулж хамтран ажилласнаар 2024 оны 12-р сарын 31-ны өдрийн байдлаар 17 ажилтны гэрээ хүчин төгөлдөр байна.

№	Батлагдсан орон тоо	Нэр
1	Төслийн зохицуулагч	Н.Тэгшбаяр
2	МАА,Бэлчээрийн менежментийн асуудал хариуцсан дэд зохицуулагч	Б.Ванчиндорж
3	Сангийн удирдлага хариуцсан дэд зохицуулагч	Ж.Жанарбаатар
4	Барилга хот байгуулалтын асуудал хариуцсан дэд зохицуулагч	Д.Алтангэрэл
5	Төслийн менежментийн асуудал хариуцсан дэд зохицуулагч	-
6	Ерөнхий инженер	Б.Батзориг
7	Хот байгуулалтын мэргэжилтэн	Ё.Лхагвадорж
8	Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах ажилтан	-
9	Худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан	Ц.Батбаяр
10	Санхүүгийн ажилтан	Ч.Одонтуяа
11	Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн	Б.Даваажав
12	Сангийн удирдлага хариуцсан санхүүгийн ажилтан	-
13	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	-
14	Хуульч	-
15	Нийгэм жендерийн асуудал хариуцсан мэргэжилтэн	-
16 - 17	Олон нийттэй харилцах маркетингийн ажилтан-2	-
18	Ус хангамж, дулаан, ариутгах татуургын инженер	-
19	Авто замын инженер	-
20	Цахилгааны инженер	-
21	Нүүлгэн шилжүүлэлтийн мэргэжилтэн	-
22	Агрономич	-
23	Бэлчээрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	-
24	Малчдын байгууллага, баталгаажуулалтын мэргэжилтэн	-
25	Мал аж ахуй, агро бизнесийн мэргэжилтэн	-
26	Орчуулагч/туслах ажилтан	Р.Номиндарь
27	Захиргааны ажилтан	
28	Жолооч	У.Баатархүү
29	Жолооч	Ц.Батбалжир

30	Жолооч	Д.Дашдорж
31	Ховд аймаг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	-
32	Ховд аймаг, Санхүү, Худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтан	С.Гансүх
33	Ховд аймаг, Инженер	-
34	Увс аймаг, Санхүү, Худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтан	-
35	Увс аймаг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	-
36	Увс аймаг, инженер	Б.Алтангэрэл
37	Баян-Өлгий аймаг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	Х.Анар
38	Баян-Өлгий аймаг, Санхүү, Худалдан авах ажиллагааг хариуцсан ажилтан	Ж.Маржан
39	Баян-Өлгий аймаг, инженер	-
40	Говь-Алтай аймаг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	-
41	Завхан аймаг, Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	-

8. Оролцоо ба өмчлөл

Сангийн яам: Зээлдэгчийн үүргийг гүйцэтгэх, төслийн гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээг дүгнэх, Азийн хөгжлийн банкинд төлбөрийн хүсэлтүүдийг гаргах,

Төслийн удирдах хороо: Төсөл, арга хэмжээний зорилгыг тогтсон хугацаанд, бүрэн хэрэгжүүлэх зорилгоор хэрэгжилтийг нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж, салбарын бодлоготой уялдуулах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус нэгж болох,

Эдийн засгийн хөгжлийн яам: Төслийн үйл ажиллагаанд ерөнхийлөн хяналт тавих, ажиллах хүч, боловсон хүчний зохицуулалт, томилгоо хийх, АХБ-д төслийн дэд данснуудын болон гүйцэтгэгч байгууллагуудын аудитлагдсан тайланг жил бүр хүргүүлэх, төлбөрийн хүсэлтүүдийг баталгаажуулах, түүнийг Сангийн яаманд хүргүүлэх

Төсөл хэрэгжүүлэх нэгж: Төслийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, төслийн гүйцэтгэгч байгууллагуудад зөвлөгөө өгөх, төслийн үйл ажиллагааны тайлан, байгаль орчны хяналтын тайлан, санхүүгийн аудитын тайлангуудыг Азийн хөгжлийн банкинд хүргүүлэх, шаардлагатай санхүүгийн мэдээлэл, нотолгоог хадгалах, төслийн хэрэгжилтийн явцыг АХБ-д мэдээлэх,

Хамтран хэрэгжүүлэгч байгууллага (БХБЯ, ХХААЯ): Төсөлтэй холбоотой бодлогын баримт бичиг бэлтгэх ажилд өөрийн салбартай холбоотой асуудлуудыг бодлогын удирдамжаар хангах, төслийн хэрэгжилтийн явцад техникийн мэргэжил арга, зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх,

Төслийн зөвлөхүүд: ТХН болон гүйцэтгэгч байгууллагуудад төслийн өдөр тутмын асуудлуудад дэмжлэг үзүүлэх, ТХН болон гүйцэтгэгч байгууллагуудад тендерийн бичиг баримт бэлдэх, тендерийн үнэлгээг эсвэл гэрээний хэлэлцээр хийх мөн сонгон шалгаруулалт хийхэд туслах, ТХН болон гүйцэтгэгч байгууллагуудад нэхэмжлэх болон төлбөрийн хүсэлтүүд бэлдэхэд туслах,

Азийн хөгжлийн банк: Төслийн хэрэгжилтийг хянах, дэмжлэг үзүүлэх

9. Жендер

Төслийн хүрээнд жендерийн дата мэдээлэл цуглуулаагүй бөгөөд төслийн цар хүрээнд цаашид жендерийн тухай мэдээ, мэдээлэл, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлох.

V. ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

- Төслийн хэрэгжилт анх батлагдсан хугацаа болон төслийн төлөвлөгөөний хугацаанаас хоцролттой байгаа ба төслийн голлох мэргэжилтнүүдийг сонгон шалгаруулах ажлыг эрчимжүүлэх
- Мөн төслийн удирдлагын баримт бичэгт тусгагдсан дэд бүрэлдэхүүн хэсгүүдийн зөвлөх үйлчилгээний төсөвт өртөг,түүний задаргааг шинэчлэн боловсруулах ажлыг эрчимжүүлэх, хамтран ажиллаж буй яамдуудыг оролцоог идэвхжүүлэх шаардлагатай байна.
- Төслийн үндсэн баримт бичиг болох төслийн удирдлагын баримт бичиг болон худалдан авалтын төлөвлөгөөнд шаардлагатай өөрчлөлтүүд тусгах

VI. ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ, АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн санал

1. “АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Монгол Улсын Сангийн сайдын 210 дугаар тушаалын хавсралтаар “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог батлах тухай” төслийн хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоонд үндэслэн шаардлагатай мэргэжилтний сонгон шалгаруулалтыг 2025 оны 1 сарын 31-ны өдөр дотор зохион байгуулах;
2. Төслийн удирдах хороог 2025 оны 1 дүгээр сарын 20-ны дотор зохион байгуулж төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний үнэлгээ, 2025 оны төслийн худалдан авалт, санхүүгийн төлөвлөгөө, 2025 оны үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө болон хяналт-шинжилгээний тайланг хэлэлцүүлэх;
3. Үндсэн 3 зөвлөх үйлчилгээний олон улсын нээлттэй тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулах ажлыг эрчимжүүлэх;
4. 2024 оны 11-р сарын 5-15-ны өдрүүдэд Азийн хөгжлийн банкаас (АХБ) Аймаг, сумдын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1-р үе шат (АСБНХХОХ)-ыг эхлүүлэх ажлын хэсгийн уулзалтын үр дүнд байгуулагдсан Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд амлалт доорхи ажлын гүйцэтгэлд анхаарах;

№	Үйл ажиллагаа	Хариуцагч талууд	Зорилтот огноо
А. ТХН-ийн ажилтнуудыг сонгон шалгаруулах, тоног төхөөрөмж, төсөв			
1	ТХН-ийн Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтний ажлаас чөлөөлөгдөх тухайгаа АХБ-нд албан ёсоор мэдэгдэж, дээрх ажлын байрны дахин зар, сонгон шалгаруулалтын ажиллагааг эхлүүлнэ.	ТХН	2024 оны 11 дүгээр сарын 22
2	ЭЗХЯ, СЯ 2024-2025 онд ТХН-ийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, ложистикийн зардлыг хангалттай байхаар төсөв хуваарилна.	ЭЗХЯ, СЯ	2024 оны 11 дүгээр сарын 30
3	ТХН-д сайн чанарын шаардлага хангахуйц онлайн хурлын тоног төхөөрөмжийг худалдан авна.	ЭЗХЯ, ТХН	2024 оны 12 дугаар сарын 30
4	ЭЗХЯ нь СЯ-наас баталсан ТХН-ийн шинэчлэгдсэн бүтцийн жагсаалтыг АХБ-нд илгээнэ.	ЭЗХЯ, ТХН, СЯ	2024 оны 12 дугаар сарын 15

№	Үйл ажиллагаа	Хариуцагч талууд	Зорилт от огноо
B. Төслийн хамрах хүрээ			
5	Төслийн үнэлгээний явцад боловсруулсан Аймгуудын үнэлгээний шалгуур, хөдөө аж ахуйн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн 4 дүгээр хавсралтад заасан сонгон шалгаруулалтын шалгуурыг үндэслэн 2-р үе шатны хамрах хүрээнд зорилтот аймгуудыг сонгон шалгаруулна. Монгол Улсын Засгийн газар (МЗГ)-аас тодорхойлж, АХБ-нд албан ёсны хүсэлтээ хүргүүлнэ.	ЭЗХЯ, ХХААХҮЯ, БХБОСЯ, СЯ	2025 оны 3 дугаар сарын 31
6	Төслийн 1-р үр дүнгийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг БХБОСЯ-аас байгуулна.	БХБОСЯ, ЭЗХЯ, ТХН	2024 оны 11 дүгээр сарын 30
7	ХХААХҮЯ-наас төслийн 2-р үе шатны хэрэгжилтийг удирдан чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулна.	ХХААХҮЯ, ЭЗХЯ, ТХН	2024 оны 11 дүгээр сарын 30
8	ЭЗХЯ, ХХААХҮЯ, БХБОСЯ нь аймгийн хөрөнгө оруулалтын дэд төслүүдийг хянаж, үнэлж, эцсийн жагсаалтыг АХБ-нд батлуулахаар илгээнэ. Дэд төслүүдийн шинэчилсэн жагсаалтад ТЭЗҮ хийж, нөлөөлөлтэй нийцэж байгаа эсэхийг шалгах зорилгоор ТХН нь нарийн бичгийн даргаар ажиллах агентлаг хоорондын ажлын хэсэг саналуудыг хянаж, эцэслэн шийдвэрлэнэ.	ЭЗХЯ, БХБОС	2025 оны 1 дүгээр сарын 30
9	Явцын эхний тайланг АХБ-нд ирүүлнэ.	ТХН	2024 оны 12 дугаар сарын 31
10	Баян-Өлгий аймгийн Буянт сумын усжуулалтын системд зориулан анхлан олгосон төсвийг Ховд аймагт дахин хуваарилах боломжийн талаар ЭЗХЯ, хэрэгжүүлэгч байгууллагууд, аймгийн удирдлагуудтай ярилцана.	ЭЗХЯ, ХХААХҮЯ, аймаг , сумын удирдлага	2025 оны 1 дүгээр сарын 30
C. Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ			
11	ТХН нь төслийн хэрэгжилтийн үр дүнтэй хяналт-шинжилгээ, үнэлгээг (ХШҮ) баталгаажуулахын тулд АХБ-ны санхүүжилттэй AHURP болон GADIP-ийн туршлагад үндэслэн суурь мэдээллийг цуглуулж, ТГУТ-ийг байгуулна.	ЭЗХЯ, ТХН, аймгийн ТХН, аймаг, сумдын ЗДТГ	2025 оны 1 дүгээр сарын 30
D. Төсөл хэрэгжүүлэх зохицуулалт			
12	ГЗБГЗЗГ-ын төлөөлөгчийг ТУХ-нд оруулна.	ЭЗХЯ, ТХН	2024 оны 12 дугаар сарын 31
13	ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ -тай зөвшилцсөний үндсэн дээр ЭЗХЯ, ТХН нь Монголын бэлчээр ашиглагчдын үндэсний нэгдсэн холбоо (МБАҮНХ)-тай хэрэгжүүлэх гэрээ байгуулах ажлыг эхлүүлнэ.	ЭЗХЯ, ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ, ТХН	2025 оны 1 дүгээр сарын 30
14	ЭЗХЯ-наас GIRAF сангийн менежер байгууллагыг тодорхойлж, албан ёсоор томилохын тулд СЯ-тай нягт зөвлөлдөж, цаашид боловсруулахаар АХБ-нд холбогдох хүсэлтийг хүргүүлнэ.	ЭЗХЯ, СЯ	2025 оны 1 дүгээр сарын 30
E. Худалдан авалт, зөвлөх сонгон шалгаруулах			
15	ЭЗХЯ болон ТХН нь PIMS зөвлөх үйлчилгээний багцыг (PIO1) зарлана.	ЭЗХЯ, ТХН	2024 оны 12 дугаар сарын 31
16	ЭЗХЯ болон ТХН нь үлдсэн зөвлөх үйлчилгээний багцыг зарлах болно.	ЭЗХЯ, ТХН	2025 оны 1 дүгээр сарын 30
17	Хувь зөвлөхүүдийн багцуудыг сонгон шалгаруулах үйл явцыг дуусгаж, гэрээ байгуулна.	ЭЗХЯ, ТХН	2025 оны 11 дүгээр сарын 30
18	Өмнөговь сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах нэмэлт зөвлөх	ЭЗХЯ, ТХН,	2025 оны

№	Үйл ажиллагаа	Хариуцаг ч талууд	Зорилт от огноо
	үйлчилгээний багцыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, сонгон шалгаруулалтыг эхлүүлэх.	БХБОС	2 дугаар сарын 28
F. Санхүүгийн удирдлага, тайлан, аудит			
19	ЭЗХЯ, ТХН нь Хавсралт 5-д заасан санхүүгийн удирдлага, тайлан, аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ЭЗХЯ, ТХН	2025 оны 1 дүгээр сарын 30
20	Санхүүгийн удирдлагын гарын авлагын төслийг АХБ-д илгээнэ.	ТХН	2025 оны 1дүгээр сарын 20
21	СУҮАТ-т дурдсанчлан ТХН-ийн нягтлан бодогч сонгон шалгаруулна.	ЭЗХЯ, ТХН	2025 оны 6 дугаар сарын 30
G. Байгаль орчны хамгаалалт			
22	Төслийн байгаль орчны болон нийгэм, жендэрийн мэргэжилтнийг зарлах, сонгон шалгаруулалт	ЭЗХЯ, ТХН	2025 оны 1 дүгээр сарын 30
23	БОАШШ, БОМТ болон БОҮХТХХ -ийг шинэчлэхийн тулд зөвлөхүүдэд зориулсан АД бэлтгэх	ЭЗХЯ, ТХН	2025 оны 3 дугаар сарын 30
24	Төслийн бүх сайтад олон нийтийн хэлэлцүүлэг хийж, мэдээлэл өгөх.	ЭЗХЯ, ТХН	2025 оны 3 дугаар сарын 30
25	Төслийн талбайн орон нутгийн онцлогтой уялдуулан тодорхой бүтэцтэй төслийн гомдлыг барагдуулах механизмыг бий болгох.	ЭЗХЯ, ТХН	2025 оны 3 дугаар сарын 30
26	Байгаль орчны хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагын АД-г бэлтгэх	ЭЗХЯ, ТХН	2025 оны 5 дугаар сарын 30
27	Байгаль орчны хяналтын хагас жилийн эхний тайланг бэлтгэх	ЭЗХЯ, ТХН	2025 оны 3 дугаар сарын 30

1.6 INCEPTION MISSION БУЮУ ТӨСЛИЙН ЭХЛЭЛИЙН ТОМИЛОЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

Харилцан ойлголцлын санамж бичиг

MFF 0116/зээл 4306, 4307, 8441/Буцалтгүй тусламж 0885, 0886-МОН: Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1-р үе шат

Зээлийн эхлэлийн ажлын хэсэг
2024 оны 11-р сарын 5-15

I. ТАНИЛЦУУЛГА

1. 2024 оны 11-р сарын 5-15-ны өдрүүдэд Азийн хөгжлийн банкаас (АХБ) Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1-р үе шат (АСБНХХОХ)-ыг эхлүүлэх ажлын хэсэг Монгол Улсад ирж ажиллаа. Европын Хөрөнгө оруулалтын банкны (ЕХОБ) баг зайнаас онлайнаар оролцов.[2] Томилолтын гол зорилго нь Баян-Өлгий, Ховд, Увс аймгуудад төсөл хэрэгжих зорилтод газруудтайгаа танилцаж, Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), гүйцэтгэгч байгууллагын (ХБ) төлөөлөгчидтэй уулзаж, ярилцаж, зөвшилцөх; Сангийн яам (СЯ), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам (ХББОСЯ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (ХХААХҮЯ) – хэрэгжүүлэгч байгууллагууд (ХБ); мөн дээрх аймгуудын аймаг, сумын засаг захиргаа төслийн хэрэгжилтийн талаарх асуудлуудаар: (i) төслийн хамрах хүрээ, үр дүн, хэрэгжүүлэх хуваарь, зорилтот түвшин; (ii) төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэх зэрэг төслийн худалдан авалт, зөвлөхийг сонгон шалгаруулах, гэрээний менежмент; (iii) зээл, тусламжийн зарцуулалт, санхүүгийн удирдлага, тайлан, аудит; (iv) нийгэм жендэр, нүүлгэн шилжүүлэлт, байгаль орчны хамгаалал зэрэг төслийн хамгаалалт; (v) хяналт-шинжилгээ, үнэлгээ, төслийн гүйцэтгэлийн хяналтын систем ба Төлөвлөлт ба Хяналтын хүрээ (ТХХ); (vi) зээлийн гэрээг дагаж мөрдөх; (vi) Ye шат-2 болон Ye шат-3 төслүүдийн үе шатуудыг боловсруулах төлөвлөгөө. Уулзсан хүмүүсийн жагсаалтыг **Хавсралт 1- д үзүүлэв**.

2. Энэхүү харилцан ойлголцлын санамж бичигт томилолтын үеэр хийсэн хэлэлцээ, тохиролцоог нэгтгэн харуулсан болно. Энэхүү санамж бичигт тусгагдсан

[2]Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд дараах гишүүд багтсан: АХБ-ны Хот байгуулалтын үндсэн мэргэжилтэн / томилолтын багийн ахлагч ноён Раушан Маматкулов ; Хөдөө аж ахуй, хүнс, байгаль, хөдөөгийн хөгжлийн секторын Байгалийн нөөц, хөдөө аж ахуйн ахлах мэргэжилтэн Ноён Юкицугу Янома; Төсөл хариуцсан ахлах ажилтан (Дэд бүтэц) Б.Туул; Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн газрын (УАӨТХГ) Уур амьсгалын өөрчлөлтийн ахлах ажилтан Цээлэйн Энх-Амгалан; Худалдан авах ажиллагаа, төсвийн ерөнхийлөн захирагч, санхүүгийн удирдлагын газрын (ХААТЕЗСУГ) Худалдан авах ажиллагааны ахлах ажилтан Жадамбаагийн Жамсранжавын Батцэнгэл; Хамгаалалын албаны (ХА) Байгаль орчны ажилтан Нямжавын Эрдэнэсайхан; УАӨТХГ-ын Жендэрийн ахлах ажилтан Гэрэлт-Одын Саранзаяа; SG-WUD төслийн шинжээч Хатагтай Noelle Laspinas; ХААТЕЗСУГ-ын Санхүүгийн удирдлагын мэргэжилтэн ноён Кашиф Жамал; Дараах АХБ-ны ажилтнууд томилолтод зайнаас оролцох болно: ХА-ны Хамгаалалын үндсэн мэргэжилтэн Ноён Шотаро Сасаки; Нийгмийн хөгжлийн мэргэжилтэн (Нүүлгэн шилжүүлэлт) ХА, Хатагтай Мария Лорена С.Клето; болон ХААТЕЗСУГ-ын Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн ноён Томас Робинсон. Дараах АХБ-ны ажилтан зөвлөх ажлын хэсгийг дэмжин ажиллана: Байгаль орчны хамгаалалын зөвлөх Найдансүрэнгийн Эрдэнэсайхан, ЕХОБ-ны баг ажлын хэсэгт зайнаас онлайнаар нэгдсэн бөгөөд дараах ажилтнуудыг багтаасан байна: Салбарын эдийн засагч-PJ-ийн холбогдох хүн Хатагтай Моника Паганнини; Зээлийн мэргэжилтэн-GLO-ын холбогдох хүн Ноён Жан-Филипп Стийнс; Нийгмийн хөгжлийн ахлах мэргэжилтэн-PJ Нийгмийн шинжээч Хатагтай Эсмеральда Франциско; болон ЕХОБ-ны Хятад, Монгол дахь төлөөлөгчийн газрын ажилтан хатагтай Лу Жао нар оролцов.

тохиролцоог АХБ-ны удирдлагын баг болон Монгол Улсын Засгийн газар зөвшөөрсний үндсэн дээр баталгаажуулна.

II. ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

3. АХБ 2023 оны 3-р сарын 22-ны өдөр олон үе шатат санхүүжилтийн хөтөлбөр (ОҮШСХ) болон Үе шат 1-ийг баталж, зээл тусламжийн гэрээг 2024 оны 1-р сарын 11-нд байгуулж, 2024 оны 3-р сарын 19-нд хүчин төгөлдөр болсон. Нийт хөтөлбөрийн Хөрөнгө оруулалтын тооцоолсон нийт дүн 735.0 сая ам.доллар байна. ОҮШСХ -оор дамжуулан АХБ нийт 448 сая ам.долларын санхүүжилт олгох бөгөөд үүнд АХБ-ны энгийн хөрөнгийн эх үүсвэрээс ердийн зээл (135 сая ам. доллар) болон хөнгөлөлттэй зээл (135 сая ам. доллар), АХБ-ны тусгай сангаас (Азийн Хөгжлийн сан [АХС]), Ногоон уур амьсгалын сангаас хамтран санхүүжүүлсэн зээл (130 сая ам. доллар), буцалтгүй тусламж (45 сая ам.доллар) (НУАС) нь хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нэг хэсгийг санхүүжүүлэхэд туслах зорилгоор АХБ-ны удирдлагад байх болно. Европын Хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ) нь Европын Холбооны Азийн хөрөнгө оруулалтын сангаас (ЕХОБ удирдах) 100 сая ам.доллартай тэнцэх хэмжээний зээл, 30 сая ам.доллартай тэнцэх буцалтгүй тусламж хамтран (АХБ удирдахгүй) санхүүжүүлнэ. Татвар хураамж, нүүлгэн шилжүүлэлт, барилгын ажил, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ, төслийн менежмент болон бусад төрлийн зардал болох 75.3 сая ам.долларыг Засгийн газар санхүүжүүлнэ. Үе шат-1 зээл ба буцалтгүй тусламжийн эцсийн хугацаа 2029 оны 3-р сарын 21. Төслийн ГБ нь ЭЗХЯ бөгөөд ХБ-д БХБОСЯ, СЯ, ХХААХҮЯ багтдаг.

4. Хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь Монгол Улсыг ногоон, хүртээмжтэй агро - нутаг дэвсгэрийн хөгжлийг урагшлуулахад туслах зорилготой юм. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үр дүн нь (i) уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгч бага ялгаруулдаг, сонирхол татахуйц аймаг, сумын төвүүдийг хөгжүүлэх; (ii) уур амьсгалд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр агууламжтай, бэлчээр, хөдөө аж ахуйн тогтвортой менежментийг хэрэгжүүлэх; (iii) нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуй, агробизнесийн үнэ цэнийн сүлжээнд (хөтөлбөрийн санхүүгийн зуучлалын зээлийн бүрэлдэхүүнээр) хүртээмжтэй санхүүжилт бий болгох; ба (iv) нүүрстөрөгч багатай, уур амьсгалд тэсвэртэй агро -нутаг дэвсгэрийг хөгжүүлэх байгууллагын чадавхи, бодлогыг бэхжүүлэх. ОҮШСХ нь Үр дүн 1, 2-ын зорилтот хөрөнгө оруулалтад зориулж 17 аймгийг хамарсан 3 үе шаттай байх болно. Үр дүн 3, 4 нь дээр дурдсан аймгуудыг хамрах боловч сонгон шалгаруулах шалгуур, үр шим хүртэгчдийн нөхцөл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шаардлагад үндэслэн улсын хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой. Үе шат-1 нь Баян - Өлгий, Ховд, Увс гэсэн баруун гурван аймагт чиглэнэ.

5. 2024 оны 11-р сарын 15-ны байдлаар төслийн хэрэгжилт 28%-тай байна. Гэрээ байгуулсан нийт дүн 0.36 сая ам.доллар байна. Нийт зарцуулалт нь 0.76 сая ам.доллар байна. ЭЗХЯ нь төсөл хэрэгжүүлэх нэгжийг (ТХН) байгуулж, ажилтнуудыг сонгон шалгаруулж, ТХН-ийн оффисын тавилга, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн худалдан авалтыг хийсэн. ТХН болон АХБ-ны төслийн баг зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг (ЗҮАД) эцэслэн боловсруулж, санал авах хүсэлтийг (САХ) бэлтгэхээр ажиллаж байна. Зөвлөх үйлчилгээний багцыг 2024 оны 11-р сард зарлахаар төлөвлөж байна.

III. УУЛЗАЛТААР ГАРСАН ШИЙДВЭРҮҮД

А. Хэрэгжилтийн зохион байгуулалт.

6. Хамгийн сүүлд 2024 оны 9-р сард болсон Хөтөлбөрийн удирдах хорооны хурлаар төслийн хэрэгжилтийн ерөнхий явц, төслийн хэрэгжилтийн асуудал, тэдгээрийг шийдвэрлэх алхам, төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, ТХН-ийн бүтцийн шинэчлэлийн талаар хэлэлцэв. ТУХ-ны хурлаар шийдвэрлэсний дагуу ТХН-ийн одоогийн бүтэц, бүрэлдэхүүнийг нэмэх хүсэлтийг СЯ-нд хүргүүлж, төслийн хэрэгжилтийг түргэсгэхэд туслах хамгаалалын мэргэжилтнүүд, инженерүүд болон бусад туслах ажилтнуудыг багтаасан ажилтнуудыг нэмж оруулав. СЯ-ны шийдвэрийг үндэслэн ГБ нь ТХН-ийн дээрх ажилтнуудын сонгон шалгаруулалтын талаар АХБ-наас зарлах зөвшөөрөл авах албан ёсны хүсэлт илгээнэ.

7. ГБ нь ТХН-ийг байгуулж, дараах 14 ТХН-ийн ажилтнуудыг сонгон шалгаруулсан: Төслийн зохицуулагч; Хот байгуулалтын асуудал хариуцсан орлогч зохицуулагч (Үр дүн 1), Газар тариалан, бэлчээрийн менежмент (Үр дүн 2); болон Санхүүгийн зуучлалын зээлийн бүрэлдэхүүн хэсэг (Үр дүн 3); Ерөнхий инженер; Худалдан авалт, худалдан авах ажиллагааны ахлах ажилтан; Хяналт-шинжилгээ, үнэлгээ (ХШҮ)-ийн ажилтан; Санхүүгийн ажилтан; Төслийн туслах; болон Жолооч. Төслийн зорилтот аймгуудад ТХН - ийг байгуулж, ТХН бүр ХШҮ-ний ажилтан, Худалдан авалт, санхүүгийн ажилтан, Инженерүүдийг сонгон шалгаруулсан. ТХН нь оффис түрээсэлж, оффисын тоног төхөөрөмж, тавилга, тээврийн хэрэгслийг худалдан авсан. **Хавсралт 2-т** ТХН-ийн одоогийн бүтэцийг үзүүлэв. Сангийн яамнаас одоогийн батлагдсан бүтэц, зохион байгуулалтад үндэслэн эхлэлийн томилолтын үеийн байдлаар ТХН-ийн дараах орон тоо сул байна: (i) Ховд аймгийн ТХН: Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан ажилтан, инженер; ба (ii) Увс аймгийн ТХН: Санхүү, худалдан авах ажиллагааны ажилтан, Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан.

8. Хөтөлбөрийн хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ) нь хот байгуулалт, бэлчээрийн хяналт шинжилгээнд чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг харгалзан үзэж, байгууллагын зохион байгуулалтын шатлалаар БХБОСЯ-нд харьяалалгүй болсон тул ГЗБГЗЗГ-ын төлөөлөлийг ТУХ-нд оруулахыг төлөөлөгчийн газраас зөвлөлөө. Нэмж дурдахад, Ухаалаг газрын менежментийн системд тавигдах онцлог хэрэгцээ, техникийн шаардлагыг тодорхойлох, мөн фото хяналт, зайнаас тандан судлах аргуудыг ашиглан бэлчээрийн хяналтыг хэрэгжүүлэхэд ГБ болон ТХН нь ГЗБГЗЗГ-тай нягт хамтран ажиллана.

9. **Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаа (ОНОХАА).** Худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой (ОНОХАА) явуулах нь төвөгтэй байдгийг онцолж, Төслийн хэрэгжилт, менежментийг дэмжих зөвлөх (PIMS)-ийн боловсруулсан ОНОХАА-ны гарын авлагад үндэслэн туршилтын хэлбэрээр бага хэмжээгээр эхлүүлэхийг санал болгов.

10. **Төслийн Ye шат-2-ын бэлтгэл.** АХБ-ны Монгол Улсад хийх хөрөнгө оруулалтын төслийн үечилсэн санхүүжилтийн хүсэлтийг 2026 оны 4-р улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа тул хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн Ye шат-2-ыг бэлтгэх ажлыг эхлүүлэхийн чухлыг төлөөлөгчид онцлон тэмдэглэлээ. Иймд ГБ нь Монгол Улсын Засгийн газраас (МУЗГ) тодорхойлсон хөдөө аж ахуйг хөгжүүлэх нэн тэргүүний байршлыг Санхүүжилтийн Ерөнхий хэлэлцээр (CEX)-ийн 4-

р жагсаалтад заасан сонгон шалгаруулалтын шалгуурт үндэслэн Үе шат 2-ын аймгийн сонгон шалгаруулалтыг эцэслэн шийдвэрлэх шаардлагатай байна.

11. **ТХН-ийн үйл ажиллагааны төсөв, офисийн тоног төхөөрөмж.** Хөтөлбөрийн цар хүрээ, ложистикийн шаардлагыг харгалзан ГБ, ТХН, ХБ-ийн ажилтнуудыг багтаасан баг төслийн талбайд тогтмол зорчих шаардлагатай болно. Иймд ТХН-д логистикийн зардлыг нөхөхөд ГБ болон СЯ хангалттай үйл ажиллагааны төсвийг цаг тухайд нь хуваарилна.

12. Эхлэлийн томилолтын үеэр ТХН-ийн онлайн хурлын хэрэгсэл нь сайн чанарын онлайн хурал зохион байгуулахад хангалтгүй байгааг мэдлээ. Иймд ТХН-ийн онлайн хурлын шаардлагыг хангахын сайн чанартай тоног төхөөрөмж худалдан авах хэрэгтэй байна.

13. Үр дүн 3-ын хэрэгжилтийг эрчимжүүлэх: Санхүүгийн зуучлалын зээлийн (СЗЗ) бүрэлдэхүүн хэсэг болох ГБ нь Ногоон, хүртээмжтэй бүс нутгийн хөдөө аж ахуйн бизнесийн санг (GIRAF) удирдах байгууллагыг тодорхойлж, албан ёсоор томилохын тулд СЯ-тай нягт зөвлөлдөж, цаашид боловсруулахаар АХБ-нд холбогдох хүсэлтийг хүргүүлнэ.

14. Төслийн нэг байршил болох Увс аймгийн Өмнөговь суманд одоог хүртэл ерөнхий төлөвлөгөөгүй байгаа нь томилолтын явцад тогтоогдсон. Иймд дээрх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний багцад тусгахаар томилолтын баг, ТХН болон аймаг, сумдын удирдлагууд тохиролцов. Өмнөговь сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах нь цаашид хөрөнгө оруулалтын дэд төслүүдийг хэрэгжүүлэхэд амин чухал юм. Өмнөговь сумын ЗДТГ-аас дээрх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг санхүүжүүлэх хүсэлтийг аймгийн ЗДТГ-аар дамжуулан БХБОСЯ-нд гаргаж, БХБОСЯ ерөнхий төлөвлөгөөний АД-ыг боловсруулан, ТХН-д хүргүүлнэ.

B. Төслийн хамрах хүрээ

15. Төсөл хэрэгжих газруудтай танилцах үеэр томилолтын баг доорх аймаг, сумдад төслийн оролцогч талуудтай уулзаж, зөвлөлдсөн: Аймгийн Засаг дарга, ИТХ-ын дарга нар; Хөрөнгө оруулалт, хөгжил, Хөдөө аж ахуй, Мал эмнэлэг, үржлийн газар, Газар зохион байгуулалт, Нийгмийн халамж, Эрүүл мэнд, Боловсролын газрын хамт олон; цахилгаан станц, цахилгаан түгээх үйлчилгээ үзүүлэгч; ус хангамж, түгээлтийн үйлчилгээ үзүүлэгч; хатуу хог хаягдлын менежментийн үйлчилгээ үзүүлэгчид; аж үйлдвэрийн паркийн удирдлагын баг; малчид, эрчимжсэн тариаланчид; тариаланчид; малчдын хоршоод; болон мах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах компаниуд.

16. Төсөл хэрэгжих газруудтай танилцаж, аймаг, сумдын засаг захиргааны төлөөлөлтэй ярилцах үеэр төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зарим барилгын ажлын багцыг улсын төсөв болон бусад олон улсын санхүүжилтийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн болохыг томилолтын багт мэдээлэв. Тухайлбал, “Үр дүн 1”-д багтсан Улаангом хотын цэвэрлэх байгууламжийг Польш улсын Засгийн газрын хоёр талын зээлийн хөрөнгөөр санхүүжүүлж, барилгын ажлын явц 40 орчим хувьд хүрээд байна. Томилолтын баг, ТХН, аймаг , сумдын удирдлагууд дэд төслүүд болон барилгын ажил, бараа бүтээгдэхүүний багцын шинэчилсэн жагсаалтыг ТХН-д илгээхээр тохиролцов. ТХН болон томилолтын баг

дээрх жагсаалтын талаар ХБ-ууд болон ЭЗХЯ-тай хэлэлцэн, төслийн шинэчилсэн хамрах хүрээнд хамрагдах дэд төсөл, барилгын ажлын шинэчилсэн жагсаалтыг шалгаж, тохиролцоно. Томилолтын баг, ГБ болон ТХН нь дээрх дэд төслүүд, барилгын ажлын шинэчилсэн жагсаалт нь төслийн үр нөлөө, үр дүн, төслийн ТЭЗҮ-тэй нийцэх ёстойг тохиролцов.

17. **ТЭЗҮ-д хийгдэх шинэчлэл.** Аймгуудын удирдлагуудтай уулзаж газар дээр нь очиж танилцах үеэр 2019 онд дуусан төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэх, ялангуяа ТЭЗҮ-ээс тодорхойлсон дэд төслүүдтэй холбоотой асуудлыг шинэчлэх шаардлагатай байгааг аймгийн удирдлагууд онцолж байлаа. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж эхлэх үед анхны ТЭЗҮ-ийг хийснээс хойш бараг 6 жил үргэлжилсэн; Иймд одоо байгаа дэд бүтцийн бүтээн байгуулалтын байдал өөрчлөгдөж, улсын болон аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж дуусан хөрөнгө оруулалтын зарим дэд төслүүдийг нэмж, солих хүсэлтийг аймгуудын удирдлагуудад тавьжээ. Улсын болон аймгийн төсвөөс санхүүжүүлээд дуусан байсан.

18. **Дэд төслүүдийн шинэчилсэн жагсаалт.** Томилолтын баг болон ТХН-ээс аймгийн удирдлагуудыг дэд төслүүдийн шинэчилсэн жагсаалтаа төслийн хөрөнгө оруулалтын хамрах хүрээнд багтаан хянуулахаар ирүүлэхийг хүссэн. Дэд төслүүдийн шинэчилсэн жагсаалтын ТЭЗҮ-ийн үр нөлөө, үр дүнд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор ТХН нь нарийн бичгийн үүргийг гүйцэтгэж, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шаардлага, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 1, 2-р үр дүнгийн хэрэгжилтэд хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч ажиллах, агентлаг хоорондын ажлын хэсгийн саналуудыг хянаж, эцэслэн шийдвэрлэнэ. Дээрх ажлын хэсгүүдийг 2024 оны 11 дүгээр сард БХБОСЯ, ХХААХҮЯ байгуулна.

19. Ажлын хэсэг ТЭЗҮ-ээр тодорхойлсон одоо хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын дэд төслүүдийг шинэчлэх талаар аймгуудын санал, үндэслэлтэй танилцаж, эцсийн жагсаалтыг ЭЗХЯ-аар дамжуулан АХБ-аас зөвшөөрөл авахаар илгээнэ. Хөрөнгө оруулалтын дэд төслүүдийн батлагдсан жагсаалтад үндэслэн ЭЗХЯ нь 1-р үе шатад инженерийн нарийвчилсан зураг төсөл, хяналтын зөвлөх үйлчилгээний АД-ыг хянан үзэж, зөвлөхийг сонгон шалгаруулах үйл явцыг үргэлжлүүлнэ.

20. Аймгуудын удирдлагууд томилолтын үеэр зарим барилгын ажлын багцад улсын төсөвт тусгагдсан инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулагдсан байгааг дурдаж, төслийг санхүүжүүлэхийг хүссэн байна. БХБОСЯ-ны дэргэдэх ажлын хэсэг ТХН-тэй хамтран АХБ-тай зөвлөлдсөний үндсэн дээр эдгээр нарийвчилсан инженерийн зураг төслийг дахин хянаж, батлагдсан төслийн хүрээнд тэдгээрийг санхүүжүүлж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг үнэлнэ.

21. Дэд бүтэц бий болгох, мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сүлжээг хөгжүүлэх, GIRAF сангаас Ногоон зээл/хөнгөлттэй зээл авах зэрэг нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд хүрэхийг зорьж буй нийт үр нөлөөг бий болгохын тулд төслийн 3 бүрэлдэхүүн хэсгийн хэрэгжилтийг нягт уялдуулж, төлөвлөж, хэрэгжүүлэх, ажлын байр бий болгох, малчид, тариаланчдын орлогыг нэмэгдүүлэх, бэлчээрийг нөхөн сэргээх зорилгоор малын илүүдэл нөөцийг багасгах, нүүрстөрөгчийн ул мөрийг бууруулах (мал, газар) шаардлагатай.

22. Төслийн ТЭЗҮ-ийг 2019-2021 онд хийснээс хойш малчин өрхүүдийн дийлэнх нь Бэлчээр ашиглагчдын хэсгүүдэд (БАХ) нэгдсэн. Гэвч БАХ болон сумын удирдлагуудын хооронд байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээний (БАГ) хэрэгжилт сумын түвшинд хүчин чадал хүрэлцээгүйгээс удааширчээ. Иймд төслийн дэмжлэг нь чадавхийг бэхжүүлэх нэн чухал хэрэгцээнд тулгуурлан сумын түвшинд БАГ-ыг

хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чадавхийг бий болгоход чиглэгдэх ёстой: талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх амраах, сэлгэх бэлчээрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, зохицуулах, жил бүр бэлчээрийн төлөв байдлын зураг аван хяналт тавьж, БАГ-ний хэрэгжилтийг багтаан малчдын орон нутгийн хөгжлийн төслийг дэмжих урьдчилсан нөхцөл болгоно.

23. Аймгийн хэмжээнд малын эрүүл мэндийг хянах тогтолцоог боловсруулж нэвтрүүлсэн. Бүс нутгаас махны экспортыг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй гол бэрхшээлийг шийдвэрлэхэд энэ тогтолцоог малчин, сумын түвшинд нэвтрүүлж, хэрэгжүүлэх ажил хоцорч байна.

24. 2015 онд санаачлан 2021 оноос хэрэгжиж байгаа Хариуцлагатай нүүдэлчдийн платформыг Стандарт, хэмжил зүйн газраас Хариуцлагатай нүүдэлчин зохистой дадлыг нэвтрүүлэхэд тавих шаардлагууд MNS6891:2020 болгон баталсан. Энэ нь малчин өрхийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бүхий л бүрэлдэхүүн хэсэг болох бэлчээрийн төлөв байдал, малын эрүүл мэнд, малын тавлаг байдал, түүхий эдийн чанар, байгаль орчныг хамгаалах зэрэг агуулгыг багтаасан. Үндэсний итгэмжлэлийн төвөөр батлагдсан гэрчилгээжүүлэх системтэй. Малчид, БАХ, малчдын хоршоод бүгд баталгаажуулалтад хамрагдах боломжтой бөгөөд малчид, хоршоодын орлогыг нэмэгдүүлэхийн тулд мөшгөх тогтолцоотой, хариуцлагатай үйлдвэрлэсэн, ёс зүйтэй, сайн чанарын түүхий болон хагас боловсруулсан малын түүхий эдээр хангах зорилгоор гадаадын зах зээл рүү гарч эхлээд байна. Тухайлбал, Хятадын компаниуд нэг кг үслэг ноолуурыг 89 ам.долларaар авдаг бол барууны “Burberry” гэх мэт брэндүүд нэг кг ноолуурыг 110-125 ам.долларaар авдаг. Энэхүү мөшгөх тогтолцоогоор баталгаажсан ноолуурыг манай улсын хоршоод илүү өндөр үнээр худалдаалж эхэлсэн. Энэхүү шилдэг туршлага, стандарт, баталгаажуулалтын тогтолцоог сайжруулж малчин өрх болон малчдын хоршоодод зах зээлийн боломжийг нээж өгөх шаардлагатай байна.

25. ЭЗХЯ, ТХН нь ХХААХҮЯ-тай зөвшилцөн малчдын БАХ-ийг бэхжүүлэх зорилгоор санхүүжилтийн хүрээний гэрээ, хөтөлбөрийн удирдлагын гарын авлагад дурдсанчлан Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулна. Бэлчээрийг хязгаарлах БАГ-ний зорилтуудын хэрэгжилтийг хангахын тулд тогтвортой мал аж ахуйн дадлага, ур чадварын сургалт явуулах, бэлчээрийн доройтол, тогтвортой, урт хугацааны менежментийн БАХ-ын чадавхийг бэхжүүлэх тухай сумдын удирдлагуудтай гарын үсэг зурна.

26. Аймаг, сумдын засаг захиргаа, төслийн аймаг, сумдын оролцогч талуудаас Үр дүн 2-ыг хэрэгжүүлэхэд дараах өөрчлөлтийг санал болгосон (Хүснэгт 1):

Хүснэгт 1: Үр дүн 2-ын хамрах хүрээ ба хэрэгжилтэд санал болгож буй өөрчлөлтүүд:

Төслийн үнэлгээний үеэр төлөвлөсөн	Аймаг , сумдын засаг захиргаа, оролцогч талуудын санал болгож буй өөрчлөлтүүд
БАХ байгуулах	Бүх малчин өрхүүд БАХ-д нэгдсэн. Одоо БАХ-г хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэхэд анхаарч, талхлагдсан бэлчээрийн нөхөн сэргээлтийг хийх. Боломжтой бол төслийн олон нийтийн буцалтгүй тусламж/инновацийн төсөлд өргөдөл гаргах нөхцөл БАГ-ийн идэвхжүүлэх/хэрэгжилттэй байх.
Малчдын хоршоо байгуулах	Шинэ хоршоо хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 600 гаруй хоршоо шинээр байгуулагджээ. Төсөл одоо дотоод засаглалыг сайжруулах, бизнесийг хөгжүүлэх, зах зээлд нэвтрэх зэрэг чадавхыг бэхжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Малын эрүүл мэндийг хянах тогтолцоог бий болгох	ШХА-ийн Ногоон алт төслөөс малын эрүүл мэндийг хянах тогтолцоог бий болгож, аймгийн хэмжээнд нэвтрүүлсэн. Төсөл нь энэ тогтолцоог сум, малчдын түвшинд нэвтрүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.
Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх	Баруун гурван аймаг Ойрхи Дорнод, Казахстан, ОХУ-ын Алтайн бүс нутагт зах зээлийн боломжоо нээсэн. Орон нутгийн мал эмнэлгийн лабораториудын хүчин чадал экспортод гаргах махны чанарыг баталгаажуулах түвшинд хүрэхгүй байгаа нь гол хүндрэл болж байна. Одоогоор махнаас дээж авч УБ руу явуулж, шинжилгээнд хамруулж байна. Бүх аймгууд мал эмнэлгийн үйлчилгээний гэрчилгээтэй лабораторитой байх нь экспортод гаргах махны гэрчилгээг цаг алдалгүй олгоход чухал ач холбогдолтой юм.
Агро аж үйлдвэрийн парк байгуулахад дэмжлэг үзүүлэх Шинэ Ховд Аж үйлдвэрийн парк	Ховд аймаг бүс нутгийн Аж үйлдвэрийн паркийн зангилаа болно. Төрөөсдэд бүтэц (цахилгаан дамжуулах шугам) болон хувийн компаниудад үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт хэдийнэ хийж эхэлсэн. Уг бүсэд төслийн хүрээнд байгуулах Агро аж үйлдвэрийн паркийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтыг зохицуулах шаардлагатай байна.
Услалтын системийг сэргээн засварлах	Ховд аймгаас Булган голын сав дагуу услалтын систем байгуулах хүсэлт гаргасан. Баян-Өлгий аймгийн Буянт сумын усалгааны системд зориулан хуваарилсан төсвийг Ховд аймаг руу шилжүүлэх боломжийг ЭЗХЯ, хэрэгжүүлэгч байгууллагууд, аймгийн удирдлагуудтай ярилцана. Одоогоор Ховд аймагт 1-р үе шатны хүрээнд төлөвлөсөн услалтын систем байхгүй бол Увс аймагт гурав, Баян-Өлгийд хоёр услалтын систем байгуулахаар төлөвлөсөн байна. Мөн АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хүнсний ногооны тариалалт ба, усалгаатай газар тариалан" төслийн хүрээнд 2024 онд Баян-Өлгий аймгийн Сагсай, Баяннуур сумдад хоёр усалгааны системийг шинээр байгуулаад байна. Үүнээс гадна ШХА-ийн хөрөнгө оруулалтаар Буянт сумын усалгааны системийг шинэчилж байсан. . ЭЗХЯ, хэрэгжүүлэгч байгууллагууд, ТХН-ээс дээрх асуудлыг аймаг, сумдын удирдлагуудтай хэлэлцэж, ТУХ, АХБ-нд санал хүргүүлнэ.

C. Зөвлөхийн сонгон шалгаруулалт, Худалдан авалт, Гэрээ байгуулах

27. **Зөвлөхийн сонгон шалгаруулалт.** ТХН-ийн баг 2024 оны 12-р сарын 31-ний дотор багтаан зарлах зорилгоор үндсэн зөвлөх үйлчилгээний багцуудын ажлын даалгавар, зардлын тооцоог шинэчлэхээр ажиллаж байна. Эдгээр зөвлөх үйлчилгээний багцад дараах зүйлс багтана: (i) DDS1: Ye шат 1-ийн нарийвчилсан загвар болон үнэлгээ; (ii) FDS2: Ye шат 2-ын ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, хяналт; (iii) PIO1: Төслийн хэрэгжилт, удирдлагын дэмжлэг, бодлогыг сайжруулах; (iv) PIO2: Ур дүн 2-ын төслийн хэрэгжилтийн техникийн туслалцаа (бэлчээрийн менежмент, усалгааны схем, мал үржүүлгийн болон мал эмнэлгийн үйлчилгээ, мөшгөлт, баталгаажуулалтын дэмжлэг, бодлогыг сайжруулах зэрэг); ба (v) PIO3: Ур дүн 3-ын төслийн хэрэгжилт ба менежментийн дэмжлэг (ногоон агробизнесийн санхүүгийн зуучлалын зээл). Дээрх зөвлөх үйлчилгээ нь 2026 онд АХБ-ны удирдлагаар батлуулахаар төлөвлөж буй 1-р үе шатны төслийг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх, 2-р үе шатны төслийг бэлтгэхэд чухал ач холбогдолтой юм. Томилолтын баг, ЭЗХЯ, ТХН нь дээрх зөвлөх үйлчилгээний багцыг зарлах ажлыг түргэвчлэхээр тохиролцов.

28. **Худалдан авалт.** АХБ-ны худалдан авах ажиллагааны ахлах ажилтан АХБ-ны худалдан авах ажиллагааны бодлого, дүрэм журам, тавигдах шаардлага зэрэг гол асуудлуудын талаар ТХН-ын багт танилцуулга хийлээ. Томилолтын баг, ЭЗХЯ, хэрэгжүүлэгч байгууллагууд, ТХН нь одоогийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, аймаг, сумдын төр, захиргааны байгууллагуудаас шинэчилсэн дэд төсөл, барилгын ажлуудын жагсаалтыг хүлээн авч, үнэлж, хэлэлцсэний үндсэн дээр шинэчлэхээр тохиролцов. (Санамж бичгийн 10-р хэсэг).

Одоогийн төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 9 зөвлөх үйлчилгээ, үүнд зөвлөх үйлчилгээ, барилгын ажил, АХБ, ЕХОБ-ны санхүүжүүлсэн барааны багц багтсан. Энэ нь **Хавсралт 3- т багтсан.**

29. Томилолтын үеэр буюу 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр ТХН-ийн Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн ажлаас чөлөөлөгдөх өргөдлөө ТХН-ийн Зохицуулагчид өгсөн. Томилолтын баг, ГБ болон ТХН нь төслийн хүрээнд худалдан авалтыг цаг алдалгүй хийх зорилгоор Худалдан авах ажиллагааны шинэ мэргэжилтний ажилд авах ажлыг түргэсгэхээр тохиролцов. Энэ хооронд ТХН нь Худалдан авах ажиллагааны зөвлөхийг ажилд авах ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ нь ТХН-д дээрх зөвлөх үйлчилгээний багцыг бэлтгэх, зарлах, ажилд авах ажлыг түргэсгэхэд туслах болно (Санамж бичгийн 11-р хэсэг).

30. **ЕХОБ-ны Худалдан авалт ба тайлагнах шаардлага**. Томилолтын баг, ГБ болон ТХН нь ЕХОБ-аас санхүүждэг барилгын ажил, бараа бүтээгдэхүүний багцын худалдан авалтын талаар ярилцав. Санамж бичгийн 16-20-д дурьдсанчлан, ЕХОБ-аас санхүүждэг зарим багцыг бусад эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа бөгөөд баригдаж байна. Иймд аймаг, сумдын засаг захиргаанаас дэд төслүүдийн шинэчилсэн жагсаалтыг хүлээн авч, үнэлсний дараа АХБ, ЕХОБ-ын төслийн багууд, ТХН, ЭЗХЯ хамтран баригдаж байгаа дээрх багцуудыг солих, бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга замын талаар ярилцана. Томилолтын баг, ЕХОБ, ТХН, ЭЗХЯ хамтран ЕХОБ-ын санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн худалдан авалт нь ЕХОБ-ын худалдан авах ажиллагааны бодлого, заавар, шаардлагад нийцэж байгаа эсэхийг хэлэлцлээ. Талууд мөн ЕХОБ-ны төслийн тайланд тавигдах шаардлагуудын талаар ярилцав. ЕХОБ-ны тайлангийн шаардлагыг Хавсралт 4-т оруулсан болно.

D. Санхүүгийн менежмент, Тайлан ба аудит

31. Томилолтын баг төслийн хүрээнд тавигдах санхүүгийн менежментийн шаардлагуудыг хэлэлцлээ. 1, 2, 4-р үр дүнгийн санхүүгийн менежментийн үйл ажиллагааг төв ТХН-ээс гүйцэтгэх нь батлагдсан. Үр дүн 3-ыг хэрэгжүүлэх GIRAF-ийн менежерээр ажиллах аж ахуйн нэгжийг засгийн газар хараахан тодруулаагүй байгааг томилолтын баг тэмдэглэв. Засгийн газрын шийдвэр гарч АХБ-аар хянагдсаны дараа мэдэгдэнэ.

32. ТХН-ийн Санхүүгийн мэргэжилтэнд АХБ-ны төслүүдийн санхүүгийн удирдлагын шаардлагуудын талаар сургалт зохион байгууллаа. 2022 онд бэлтгэсэн зардлын тооцоог өнөөгийн хөгжлийн хэрэгцээ, эдийн засгийн нөхцөл байдлыг тусган нягтлан үзэж, шинэчлэх шаардлагатай байгааг томилолтын багийн зүгээс онцоллоо.

33. Томилолтын баг Санхүүгийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөний (СУҮАТ) ахиц дэвшлийг сайшаасан боловч төслийн өнөөгийн шаардлагуудыг шийдвэрлэхийн тулд боловсон хүчин, нягтлан бодох бүртгэл, тайлан, дотоод аудит зэрэгт өөрчлөлт оруулахаар тохиролцсон байна (Хавсралт 5-аас шинэчилсэн СУҮАТ-г үзнэ үү). Томилолтын баг 2025 оны 6-р сарын 30-ны дотор нягтлан бодогчийн сонгон шалгаруулалтыг хийж дуусгахыг төсөлд зөвлөж, санхүүгийн удирдлагын гарын авлагын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвлөлөө. Санхүүгийн удирдлагын гарын авлагын төслийг 2025 оны нэгдүгээр сарын 20-ны дотор АХБ-руу илгээхээр тохиролцов.

34. Аудитаар батлагдсан Төслийн Санхүүгийн Тайлангийн (АБТСТ) загварыг хэлэлцлээ. АБТСТ-г Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС)-ын нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь ашиглан бэлтгэх бөгөөд төслийн санхүүжилтийн бүх эх үүсвэрийг хамрах ёстой гэж тохиролцов. Эхний АБТСТ нь зээл хэрэгжиж эхэлсэн өдрөөс санхүүгийн жилийн эцэс хүртэл бэлтгэгдэнэ. Гэсэн хэдий ч 2024 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэлх санхүүгийн гүйлгээний дүнг эхний АБТСТ-г хойшлуулах хүсэлт гаргах эрхийг тодорхойлон хянаж үзэхээр тохиролцов. ТХН нь 2025 оны 1-р сарын 15-ны дотор энэ талаарх мэдээллийг АХБ-руу илгээнэ.
35. ТХН-ээс ЭЗХЯ болон Сангийн яам (СЯ) бүх санхүүгийн гүйлгээнд урьдчилсан аудит хийдэг гэж томилолтын багт мэдээлэв. Үүний дагуу ТХН-д дотоод аудитын мэргэжилтэн авахын оронд ЭЗХЯ, СЯ-ны дотоод аудитад төсөл хамрагдаж болно. Тогтмол ажлын явцын тайлагналын тухайд АХБ улирал тутам санхүүгийн удирдлагын ахицийн тайлангийн загварыг ТХН-тэй хуваалцаж санал авахаар тохиролцов. Санхүүгийн удирдлагын явцын тайлангийн загварыг улирлын тайлангийн ерөнхий загварт нэгтгэнэ.

36. Үр дүн 2-ын хүрээнд олон нийтэд түшиглэсэн арга хэмжээний хэрэгжилтийн зохицуулалтыг эцэслэн боловсруулж байгааг томилолтын баг тэмдэглэв. Хэрэгжүүлэх зохицуулалтыг боловсруулсны дараа хөрөнгийн урсгал, санхүүгийн удирдлагын зохицуулалтыг эргэн харахаар тохиролцлоо. Төслийн санхүүгийн тогтвортой байдлын зохицуулалтын хөндлөнгийн оролцоог эргэн харах шаардлагатай байгааг томилолтын баг мөн онцолжээ.

37. Төсөл хэрэгжсэний дараа төслийн хөрөнгийг хүлээн авах төрийн байгууллагууд тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээ хийх зохицуулалтыг албан ёсны болгох шаардлагатай байгааг томилолтын багийн зүгээс онцлон тэмдэглэв. ТХН-ээс концепц боловсруулахаар тохиролцсон. Баримт бичигт хөрөнгө хүлээн авах аж ахуйн нэгжүүд, тэдгээр байгууллагад эд хөрөнгө, холбогдох өр төлбөрийг шилжүүлэх тухай хууль тогтоомж, тэдгээр этгээдтэй байгуулсан гэрээ, дээрх зохицуулалтыг эцэслэн шийдвэрлэх арга хэмжээний төлөвлөгөөг тусгасан байна.

38. Томилолтын баг мөн 4307 Зээлийн гэрээний 4-р хавсралтын 27-33-т заасан санхүүгийн гэрээнүүдийг дагаж мөрдөх шаардлагатайг онцлон тэмдэглэв. Зарим гэрээ нь 2024 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхлэх тул үр дүнг тайлагнах, баталгаажуулах механизмыг яаралтай хянаж, зөвшилцөх шаардлагатай байгааг онцлон тэмдэглэв. ЭЗХЯ нь төслийн хэрэгжүүлэгч байгууллагын хувьд төслийн хэрэгжилтийг АХБ, ЕХОБ, УАНС-ийн зээл, тусламжийн гэрээнд нийцүүлэн хангах үүрэгтэй.

39. **ТХН-д нягтлан бодогч сонгон шалгаруулж авах үндэслэл.** Төсөл боловсруулах явцад ТХН-ийн нягтлан бодогчийн сонгон шалгаруулалтын асуудлыг тохиролцсон бөгөөд үүний дагуу санхүүгийн удирдлагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд (СУҮАТ) тусгагдсан (ХУББ-ийн 18-р хүснэгтийг үзнэ үү). Нягтлан бодогчийн албан тушаалыг яаралтай нөхөх нь санхүүгийн удирдлагын хяналтыг хүчтэй бөгөөд тогтвортой хэрэгжүүлэх, ажлын ачааллыг зохих түвшинд байлгах, АХБ-ны санхүүжилтийн гэрээг цаг тухайд нь биелүүлэх боломжийг олгоно. Тогтмол санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанаас гадна төлбөрийн гүйлгээний хэмжээ одоогийн байдлаар сард дунджаар 25 гүйлгээ хийдэг байснаас сард дунджаар 80 гүйлгээ болж мэдэгдэхүйц өсөх төлөвтэй байна. Үр дүн 2-ын хүрээнд үйл ажиллагаа явуулж эхэлснээр энэ хэмжээ цаашид нэмэгдэх болно. Санхүүгийн удирдлага, тайлагналт, аудитын арга хэмжээг **Хавсралт 5-д оруулсан болно**.

E. Байгаль орчны хамгаалалт

40. Төслийг В зэрэглэлд хамруулж, Ховд, Увс, Баян-Өлгий аймаг болон холбогдох сум дундын төвүүд дэх төслийн талбайнуудад байгаль орчны анхан шатны шалгалтын (БОАШШ) төслийг 2023 оны 2-р сард бэлтгэсэн. Мөн 2023 оны 2-р сард Байгаль орчны үнэлгээ, хяналтын тогтолцооны хамрах хүрээ (БОҮХТХХ) бэлтгэсэн. Баруун Монгол дахь төслийн бүх талбайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөн онд боловсруулсан. Мөн АХБ-ны Хамгаалалтын бодлогын мэдэгдэл (2009) болон Монгол Улсын Засгийн газрын байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийг танилцуулж, 2024 оны 11-р сарын 12-ны өдрийн төслийн эхлэлийн уулзалтын үеэр цаашид авах арга хэмжээний талаар ТХН-тэй хэлэлцсэн.

41. Төслийн эхний үе шатанд олон нийтийн санал асуулга явуулах, мэдээллийг нээлттэй болгох ажлыг зохион байгуулж, орон нутгийн иргэдийн дунд байнгын зөвлөлдөх шаардлагатай байгаа бөгөөд орон нутгийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг цаг тухайд нь шийдвэрлэхийн тулд гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч байгууллагуудын шууд оролцоотойгоор гомдлыг барагдуулах механизмыг (ГБМ) бий болгох нь төслийн эхний чухал алхам юм.

42. АХБ-ны Хамгаалалтын бодлогын мэдэгдэл (2009) болон Монгол Улсын Засгийн газрын шаардлагуудыг дагаж мөрдөхийн тулд байгаль орчны үндэсний мэргэжилтэнг зарлах, сонгон шалгаруулах, нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулж дуусаны дараа БОАШШ, БОМТ, мөн ОҮШСЭҮ-ын БОҮХТХХ-ийг шинэчлэх нь чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн төслийн хүрээнд хамрах хүрээ, байршилд бага зэрэг болон томоохон өөрчлөлт гарсан тохиолдолд төслийн байгаль орчныг хамгаалах баримт бичгийг шинэчлэх шаардлагатай байгааг онцоллоо.

43. Төслийн эхний үе шатанд төслийн дотоод болон гадаад мониторингийн чадавхийг бий болгох, ТХН-аас АХБ-нд хянуулахаар хагас жил тутам Байгаль орчны хяналтын тайланг цаг тухайд нь бэлтгэх талаар эхлэлийн хурлаар онцоллоо.

F. Газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх (ГЧНШ) ба уугуул иргэдийн хамгаалалт

44. Төсөл нь албадан нүүлгэн шилжүүлэх В ангилал, уугуул иргэдэд зориулсан С ангилалтай. Томилолтын баг болон ТХН нь АХБ болон ЕХОБ-ны хамгаалалтын бодлогын зорилтууд, албадан нүүлгэн шилжүүлэлт болон уугуул иргэдийг хамгаалах үндсэн зарчим, үйл явц, шаардлагын талаар ярилцав. Томилолтын багийн зүгээс төслийн хэрэгжилтийн туршид ач холбогдолтой зөвлөгөөнүүдийг явуулах шаардлагатайг ТХН-д зөвлөжээ. Нэмж дурдахад, томилолтын багаас ТХН-д нийгмийн хамгааллын чиглэлээр туршлагатай зөвлөхийг татан оролцуулахыг зөвлөжээ.

45. Томилолтын баг болон ТХН-ийн зүгээс төслийн түвшний Гомдол барагдуулах механизм (ГБМ) байгуулагдаж, төслийн хугацаанд үйл ажиллагаатай, хүртээмжтэй байх ёстойг хэлэлцэж, янз бүрийн гомдол, гомдолтой холбоотой хамгаалалын арга хэмжээний ялгааг тодруулав. ГБМ-ийн үйл ажиллагааг мониторингийн тайланд байнга дэм болох дэлгэрэнгүй мэдээллээр баталгаажуулах шаардлагатай. Өргөдөл гомдлын талаарх мэдээлэл, гомдлыг шийдвэрлэх арга хэмжээ, гомдлын эцсийн үр дүнгийн талаарх мэдээллийг хүсэлтийн дагуу АХБ-д хүргүүлэх ёстой.

46. Томилолтын баг болон ТХН-ийн зүгээс АХБ-ны төслийн гүйцэтгэлийн тайланг (ТГТ) гаргах хүртэл хагас жил тутам ТХН-ийн дотоод хяналт, зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтын хүрээнд мэргэшсэн хөндлөнгийн ажиглагчаар хагас жил тутам хөндлөнгийн хяналт тавих зэрэг хамгаалалын хяналтын шаардлагуудыг хэлэлцлээ. Томилолтын багийн зүгээс мөн ТХН-д (i) бүх барилгын ажил нь ГЧНШ-ын холбогдох төлөвлөгөө (ГЧНШ)-тай байх шаардлагатайг АХБ-ны ГЧНШ-ын хамгаалалтын мэргэжилтнүүд хянаж баталгаажуулахыг сануулаа; болон (ii) барилгын ажлын тендерийн бүх баримт бичиг, гэрээнд гүйцэтгэгчээс эцсийн ГЧНШ-ын холбогдох арга хэмжээг дагаж мөрдөхийг шаардсан заалтууд болон мониторингийн тайланд тусгагдсан эсвэл АХБ, ГБ болон ТХН-ийн хооронд тохиролцсон аливаа засч залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгасан байх ёстой. Томилолтын багийн зүгээс АХБ-наас 2024 оны 12-р сард (байгаль орчны менежментийн сайжруулсан төлөвлөлт) болон 2025 оны 1-р улиралд (нийгмийн хамгаалал) зохион байгуулах гэж буй хамгаалалтын арга хэмжээний сургалтад ТХН-ийн холбогдох ажилтнуудыг томилохыг ТХН-д тавьсан.

G. Нийгэм ба жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө (НЖҮАТ)

47. Төсөл нь үр дүнтэй Жендэрийн нэгдсэн бодлого (ЖНБ) гэсэн ангилалд багтсан бөгөөд төслийг бэлтгэх явцад нийгэм, жендэрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг (НЖҮАТ) боловсруулсан. Томилолтын баг болон ТХН, НЖҮАТ-ийн хэрэгжилтийн гол асуудлуудыг хэлэлцэв. Гол нь АХБ-ны жендэрийн бодлого, жендэрийн ангиллын тогтолцоо, нийгмийн оролцоо, НЖҮАТ-ийн хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавих удирдамж, НЖҮАТ-ны жендэрийн үйл ажиллагааны логикийн тайлбар, шалгуур үзүүлэлтийг ТХН-д хүргүүлсэн. Эрхэм зорилго нь ТХН-д дараахь зүйлийг онцлон тэмдэглэв: (i) хөтөлбөрийн үйл ажиллагааны жендэрийн үр дүн, НЖҮАТ-ийн үзүүлэлтүүдийг хянах зорилгоор хүйсээр нь ангилсан мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх идэвхтэй арга хэмжээ авах; (ii) Жендэрийн арга хэмжээний хэрэгжилтийн байдал, жендэрийн шалгуур үзүүлэлтийг уялдуулан системтэй, тодорхой тусгах зорилгоор НЖҮАТ мониторингийн матрицыг бий болгох; мөн (iii) жендэрийн арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн явцыг сайтар хянаж, хагас жил тутам НЖҮАТ-ны хэрэгжилтийн мониторингийн тайланд тус тус тайлагнаж, (iv) төслийн ХХГА болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийгэм, жендэрийн зөвлөхийг эрт үе шатанд ажиллуулж, татан оролцуулах.

48. Төслийн үйл ажиллагааны 80-аас доошгүй хувь нь хэрэгжиж дууссан, жендэртэй холбоотой зорилтуудын 80-аас доошгүй хувь нь хэрэгжиж дууссан тохиолдолд төслийн НЖҮАТ амжилттай гэж үнэлэгддэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

H. Төслийн гүйцэтгэл ба зээлийн гэрээний хэрэгжилт

49. **Төслийн гүйцэтгэлийн хяналт, үнэлгээ.** Томилолтын баг болон ТХН-ийн зүгээс төслийн менежментийг дэмжих зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр ТХН-ээс боловсруулах төслийн гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог (ТГУТ) боловсруулах, бий болгох, шинэчлэх хэрэгцээ, ач холбогдлын талаар ярилцав. ТГУТ нь зураг төсөл, мониторингийн тогтолцоонд суурилсан байх бөгөөд мөн НЖҮАТ, БОМТ, ГЧНШН болон тогтвортой хөгжлийн зорилтод оруулах хувь нэмэр, АХБ-ны үр дүнгийн тогтолцоонд оруулах хувь нэмэр, Монгол Улсын Засгийн газрын зорилтуудыг харгалзан үзнэ.

50. **Зээл, буцалтгүй тусламж, төслийн гэрээнд нийцсэн байдал.** Томилолтын баг болон ТХН-ийн зүгээс зээл болон төслийн гэрээ, гэрээний хэрэгжилтийн

байдлын талаар хэлэлцлээ. Ерөнхийдөө төслийн эхний шатанд зээлийн гэрээнүүд биелэгдэж байгаа бөгөөд хугацаа нь дуусаагүй байна. Төслийн гэрээнд нийцсэн төлөв байдлыг **Хавсралт 6- д үзүүлэв.**

51. **Шинэчлэгдсэн Хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлага (ШХХГА)**. Томилолтын үр дүн, хэлэлцүүлэг, тохиролцоонд үндэслэн томилолтын баг, ЭЗХЯ болон ТХН нь ХХГА-ийг шинэчлэхээр ярилцаж, тохиролцсон. Шинэчлэгдсэн ХХГА-ийг **Хавсралт 7**-д оруулсан болно.

IV. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ, ДАРААГИЙН АЛХАМ

52. Аймгийн ТХН, аймаг , сумдын засаг захиргаа, төслийн бусад оролцогч талуудын хүчтэй дэмжлэг, үүрэг оролцоотойгоор гүйцэтгэсэн. Эрхэм зорилго ГБ болон ТХН нь дараахь арга хэмжээний талаар тохиролцов.

№	Үйл ажиллагаа	Хариуцагч талууд	Зорилтот огноо
Н. ТХН-ийн ажилтнуудыг сонгон шалгаруулах, тоног төхөөрөмж, төсөв			
1	ТХН-ийн Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтний ажлаас чөлөөлөгдөх тухайгаа АХБ-нд албан ёсоор мэдэгдэж, дээрх ажлын байрны дахин зар, сонгон шалгаруулалтын ажиллагааг эхлүүлнэ.	ТХН	2024 оны арваннэгдүгээр сарын 22
2	ЭЗХЯ, СЯ 2024-2025 онд ТХН-ийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, ложистикийн зардлыг хангалттай байхаар төсөв хуваарилна.	ЭЗХЯ, СЯ	2024 оны арваннэгдүгээр сарын 30
3	ТХН-д сайн чанарын шаардлага хангахуйц онлайн хурлын тоног төхөөрөмжийг худалдан авна.	ЭЗХЯ, ТХН	2024 оны арванхоёрдугаар сарын 30
4	ЭЗХЯ нь СЯ-наас баталсан ТХН-ийн шинэчлэгдсэн бүтцийн жагсаалтыг АХБ-нд илгээнэ.	ЭЗХЯ, ТХН, СЯ	2024 оны арванхоёрдугаар сарын 15
I. Төслийн хамрах хүрээ			
5	Төслийн үнэлгээний явцад боловсруулсан Аймгуудын үнэлгээний шалгуур, хөдөө аж ахуйн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн 4 дүгээр хавсралтад заасан сонгон шалгаруулалтын шалгуурыг үндэслэн 2-р үе шатны хамрах хүрээнд зорилтот аймгуудыг сонгон шалгаруулна. Монгол Улсын Засгийн газар (МЗГ)-аас тодорхойлж, АХБ-нд албан ёсны хүсэлтээ хүргүүлнэ.	ЭЗХЯ, ХХААХҮЯ, БХБОСЯ, СЯ	2025 оны гуравдугаар сарын 31
6	Төслийн 1-р үр дүнгийн хэрэгжилтийг удирдан чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсгийг БХБОСЯ-аас байгуулна.	БХБОСЯ, ЭЗХЯ, ТХН	2024 оны арваннэгдүгээр сарын 30
7	ХХААХҮЯ-наас төслийн 2-р үе шатны хэрэгжилтийг удирдан чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулна.	ХХААХҮЯ, ЭЗХЯ, ТХН	2024 оны арваннэгдүгээр сарын 30
8	ЭЗХЯ, ХХААХҮЯ, БХБОСЯ нь аймгийн хөрөнгө оруулалтын дэд төслүүдийг хянаж, үнэлж, эцсийн жагсаалтыг АХБ-нд батлуулахаар илгээнэ. Дэд төслүүдийн шинэчилсэн жагсаалтад ТЭЗҮ хийж, нөлөөлөлтэй нийцэж байгаа эсэхийг шалгах зорилгоор ТХН нь нарийн бичгийн даргаар ажиллах агентлаг хоорондын ажлын хэсэг саналуудыг хянаж, эцэслэн шийдвэрлэнэ.	ЭЗХЯ, БХБОС	2025 оны нэгдүгээр сарын 30

№	Үйл ажиллагаа	Хариуцаг ч талууд	Зорилт от огноо
9	Явцын эхний тайланг АХБ-нд ирүүлнэ.	ТХН	2024 оны арванхоёр дугаар сарын 31
10	Баян-Өлгий аймгийн Буянт сумын услалтын системд зориулан анхлан олгосон төсвийг Ховд аймагт дахин хуваарилах боломжийн талаар ЭЗХЯ, хэрэгжүүлэгч байгууллагууд, аймгийн удирдлагуудтай ярилцана.	ЭЗХЯ, ХХААХҮЯ, аймаг , сумын удирдлага	2025 оны нэгдүгээр сарын 30
J.	**Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ**		
11	ТХН нь төслийн хэрэгжилтийн үр дүнтэй хяналт-шинжилгээ, үнэлгээг (ХШҮ) баталгаажуулахын тулд АХБ-ны санхүүжилттэй AHURP болон GADIP-ийн туршлагад үндэслэн суурь мэдээллийг цуглуулж, ТГУТ-ийг байгуулна.	ЭЗХЯ, ТХН, аймгийн ТХН, аймаг, сумдын ЗДТГ	2025 оны нэгдүгээр сарын 30
K.	**Төсөл хэрэгжүүлэх зохицуулалт**		
12	ГЗБГЗЗГ-ын төлөөллийг ТУХ-нд оруулна.	ЭЗХЯ, ТХН	2024 оны арванхоёр дугаар сарын 31
13	ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ -тай зөвшилцсөний үндсэн дээр ЭЗХЯ, ТХН нь Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо (МБАНХ)-тай хэрэгжүүлэх гэрээ байгуулах ажлыг эхлүүлнэ.	ЭЗХЯ, ХХААХҮЯ, ГЗБГЗЗГ, ТХН	2025 оны нэгдүгээр сарын 30
14	ЭЗХЯ-наас GIRAF сангийн менежер байгууллагыг тодорхойлж, албан ёсоор томилохын тулд СЯ-тай нягт зөвлөлдөж, цаашид боловсруулахаар АХБ-нд холбогдох хүсэлтийг хүргүүлнэ.	ЭЗХЯ, СЯ	2025 оны нэгдүгээр сарын 30
L.	**Худалдан авалт, зөвлөх сонгон шалгаруулах**		
15	ЭЗХЯ болон ТХН нь PIMS зөвлөх үйлчилгээний багцыг (PIO1) зарлана.	ЭЗХЯ, ТХН	2024 оны арванхоёр дугаар сарын 31
16	ЭЗХЯ болон ТХН нь үлдсэн зөвлөх үйлчилгээний багцыг зарлах болно.	ЭЗХЯ, ТХН	2025 оны нэгдүгээр сарын 30
17	Хувь зөвлөхүүдийн багцуудыг сонгон шалгаруулах үйл явцыг дуусгаж, гэрээ байгуулна.	ЭЗХЯ, ТХН	2025 оны арваннэгдүгээр сарын 30
18	Өмнөговь сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах нэмэлт зөвлөх үйлчилгээний багцыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, сонгон шалгаруулалтыг эхлүүлэх.	ЭЗХЯ, ТХН, БХБОС	2025 оны хоёрдугаар сарын 28
M.	**Санхүүгийн удирдлага, тайлан, аудит**		
19	ЭЗХЯ, ТХН нь Хавсралт 5-д заасан санхүүгийн удирдлага, тайлан, аудитын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ЭЗХЯ, ТХН	2025 оны нэгдүгээр сарын 30
20	Санхүүгийн удирдлагын гарын авлагын төслийг АХБ-д илгээнэ.	ТХН	2025 оны нэгдүгээр сарын 20
21	СУҮАТ-т дурдсанчлан ТХН-ийн нягтлан бодогч сонгон шалгаруулна.	ЭЗХЯ, ТХН	2025 оны зургаадугаар сарын 30
N.	**Байгаль орчны хамгаалалт**		

№	Үйл ажиллагаа	Хариуцагч талууд	Зорилт от огноо
22	Төслийн байгаль орчны болон нийгэм, жендэрийн мэргэжилтнийг зарлах, сонгон шалгаруулалт	ЭЗХЯ, ТХН	2025 оны нэгдүгээр сарын 30
23	БОАШШ, БОМТ болон БОҮХТХХ -ийг шинэчлэхийн тулд зөвлөхүүдэд зориулсан АД бэлтгэх	ЭЗХЯ, ТХН	2025 оны гуравдугаар сарын 30
24	Төслийн бүх сайтад олон нийтийн хэлэлцүүлэг хийж, мэдээлэл өгөх.	ЭЗХЯ, ТХН	2025 оны гуравдугаар сарын 30
25	Төслийн талбайн орон нутгийн онцлогтой уялдуулан тодорхой бүтэцтэй төслийн гомдлыг барагдуулах механизмыг бий болгох.	ЭЗХЯ, ТХН	2025 оны гуравдугаар сарын 30
26	Байгаль орчны хөндлөнгийн хяналт шалгалтын байгууллагын АД-г бэлтгэх	ЭЗХЯ, ТХН	2025 оны тавдугаар сарын 30
27	Байгаль орчны хяналтын хагас жилийн эхний тайланг бэлтгэх	ЭЗХЯ, ТХН	2025 оны гуравдугаар сарын 30

52. ТАЛАРХАЛ

53. АХБ-ны үйл ажиллагаанд асар их дэмжлэг үзүүлж, зочломтгой хүлээн авч, заавар зөвлөгөө, хувь нэмэр оруулсан ЭЗХЯ, СЯ, ТХН, ХХААХҮЯ, БХБОСЯ, аймаг, сумдын захиргааны хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Монгол Улс, Улаанбаатар хот

2024 оны ..... сарын ..... -нд гарын үсэг зурав.

Ж.Өнөржаргал

Ноён Раушан Маматкулов

Төслийн захирал
Эдийн засаг, хөгжлийн яам

Хот байгуулалтын ахлах мэргэжилтэн
Ус, хот байгуулалтын салбар
Азийн Хөгжлийн банк

Хавсралтууд

1. Уулзсан хүмүүсийн жагсаалт

2. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц
3. Төслийн худалдан авалтын төлөвлөгөө
4. Европын Хөрөнгө оруулалтын банкны тайлагнах журам
5. Санхүүгийн удирдлага, тайлан, аудитын үйл ажиллагаа
6. Зээл ба Төслийн гэрээний байдал
7. Шинэчилсэн Хөтөлбөрийн удирдлагын гарын авлага

ДҮГНЭЛТ

Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 189 дүгээр тушаалаар Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулан, Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоог баталсан. Сангийн сайдын тушаалаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу АХБ-ны холбогдох журам, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх" журмын дагуу Төслийн нэгжийн ажилчдыг холбогдох журмын дагуу нээлттэй сонгон шалгуулж, томилж эхэлснээр төслийн үйл ажиллагаа 2024 оны 02 дугаар сараас эхэлсэн болно.

1. <u>Төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, ажилчдын сонгон шалгаруулалтын талаар</u>:

Сангийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 189, 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 112 дугаар тушаалуудаар батлагдсан бүтэц, орон тооны дагуу нийт 19 албан тушаалтанг 2024 оны 2, 5, 6 дугаар саруудад үе шаттайгаар томилсон. Үүнд: Улаанбаатар хотын ТХН-д 12, орон нутгийн төсөл хэрэгжүүлэх нэгжид 7 /Ховд аймагт-2, Увс аймагт-3, Баян-Өлгий аймагт-2/ албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг бэлтгэн боловсруулж, нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулан, албан тушаалтнуудыг томилуулсан.

УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Цагаан алт хөдөлгөөнүүдийн зорилттой уялдуулан төслийн хэрэгжилтийг шуурхай хангах зорилгоор төслийн удирдлагын гарын авлагад заасан албан тушаалын тоонд багтаан нарийн мэргэжлийн болон инженер, техникийн ажилчдаар төсөл хэрэгжүүлэх нэгжийг өргөтгөх хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн. Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 210 дугаар тушаалаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Улаанбаатар хот дахь орон тоог 16 хүнээр нэмэгдүүлэн, нийт 30 хүний орон тоотой, орон нутагт 11 хүний орон тоотой, Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг нийт 41 хүний орон тоотой байхаар батлагдсан байна.

Улаанбаатар хот дахь Төсөл хэрэгжүүлэх нэгжид шинээр авах 16 албан тушаалаас эхний ээлжинд шаардлагатай байгаа 11 албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтыг бэлтгэн 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Азийн хөгжлийн банкинд хүргүүлсэн, "Үл татгалзах" хүлээж байна.

Азийн хөгжлийн банкнаас "Үл татгалзах" зөвшөөрөл ирүүлэхээр шинээр батлагдсан бүтэц, орон тооны дагуу шинэ ажлын байруудыг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж эхэлнэ.

2. <u>Төслийн хүрээнд хийгдсэн ТЭЗҮ, суурь судалгааны ажлуудтай танилцах, төсөлд оролцогч талуудтай хийсэн уулзалтын тухайд:</u>

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч талын хамтын ажиллагааг хангах, төслийн үйл ажиллагаанд тулгараад байгаа асуудлуудыг шуурхай шийдвэрлэх талаар тухай бүр холбогдох уулзалтуудыг хийж ажилласан.

Тухайлбал, АХБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж төслийн хүрээнд хийгдэхээр тулгамдаад байгаа ажлууд, төслийг хэрэгжүүлэхэд авах арга хэмжээний санал, зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, зөвлөх үйлчилгээний ажлын тендерийг зарлах хугацаа, төслийн талбайд АХБ-ны төлөөлөгчид болон ТХН-ээс хамтран хийх томилолт зэрэг асуудлаар хэлэлцэн тохиролцож, зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан.

Мөн энэхүү төслийг "Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Цагаан алт хөдөлгөөнүүдийн зорилттой уялдуулах шаардлагатай тул холбогдох бодлогын зөвлөмжийг Эдийн засаг, хөгжлийн яамнаас авсны үндсэн дээр төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банктай хамтарсан уулзалтуудыг хийж байна.

3. <u>Төслийн бэлтгэл ажлын хүрээнд Орон нутагт ажилласан томилолтын тухайд:</u>

Төсөл хэрэгжих Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудад хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих дэд бүтэц, хөдөө аж ахуйн менежмент, санхүүгийн зуучлалын зээлийн бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх нөхцөл байдалтай танилцах зорилгоор 2024 оны 6, 10, 11 дүгээр саруудад нийтдээ 3 удаа Төслийн захирлаар батлуулсан удирдамжийн дагуу орон нутагт томилолтоор ажилласан.

Энэхүү ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкнаас ирүүлсэн эхлэлтийн ажлын томилолт (Inception Mission)-ын удирдамжийн хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Азийн хөгжлийн банкны төлөөлөгчдийн хамтаар Увс, Ховд, Баян-Өлгий аймгуудад 2024 оны 11 дүгээр сарын 04-09 өдрүүдэд ажиллаж, аймаг, орон нутгийн Засаг дарга болон төслийн үйл ажиллагаатай холбогдох нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийж одоогийн байгаа дэд бүтэц, төсөл хэрэгжих газрын байршил зэрэг суурь нөхцөлүүдтэй танилцан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналуудаа 2024 оны 11 дүгээр сарын 12-15 өдрүүдэд АХБ-ны мэргэжилтэнгүүдтэй хамтран бэлтгэж, харилцан ойлголцолын санамж бичгийн төсөл болон бусад хавсралтаар дагалдах баримт бичгүүдийг бэлэн болгож ЭЗХЯ талаас Төслийн захирал Ч.Өнөржаргал, АХБ талаас төслийн ахлах мэргэжилтэн Раушенбек нар гарын үсэг зурж баталгаажуулсан.

Уг санамж бичгийн хавсралтаар төсөл хэрэгжүүлэх гарын авлага /FAM/-д төслийн одоогийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудын талаар оруулах өөрчлөлтийн саналууд эцэслэн батлагдсан бөгөөд Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс дээрх санамж бичигт заасан хуваарийн дагуу ажлуудаа зохион байгуулан ажиллаж байна.

<u>4. Төслийн хэрэгжилтийн талаар:</u>

Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл нь анх АХБ-ын техник туслалцааны төслийн хүрээнд 2019 оны Монгол Улсын дэд бүтэц, хөдөө аж ахуйн тоон мэдээлэлд үндэслэгдэн анхны ТЭЗҮ хийгдсэн бөгөөд Дэлхийн даяар тархаад байсан Ковид-19 цар тахлын улмаас үүсээд байсан хөл хорио болон бусад нөлөөлөөс шалтгаалан Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

буюу анхны төслийн ТЭЗҮ хийснээс 4 жилийн дараа Зээлийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлагдсан байна.

Иймд уг төслийн анхны ТЭЗҮ, төслийн удирдлагын гарын авлага /FAM/-д тусгагдсан төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсэг болох аймаг болон сумын төвүүдийг хөгжүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалт, 2 дугаар бүрэлдэхүүн хэсэг болох хөдөө аж ахуйн менежментийг хэрэгжүүлэх, 3 дугаар бүрэлдэхүүн хэсэг болох санхүүгийн зуучлалын зээлийн төслүүд нь бусад санхүүжүүлэгч байгууллагуудаас олгосон гадаадын зээл, тусламжийн төслүүд, Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлуудтай давхацсан эсэхийг нягтлан тогтоох, мөн валютын ханшны өөрчлөлт, бараа, материалын үнийн өсөлтийг төсөвт нэмэгдүүлэн тусгаж, уг төслийн хүрээнд хэрэгжүүлэх төслийн ажлын жагсаалтыг дахин шинэчлэх зайлшгүй шаардлага тулгарч байгаа болно.

Уг асуудлын хүрээнд Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зүгээс 1 дүгээр бүрэлдэхүүн буюу аймаг болон сумын төвүүдийг хөгжүүлэх дэд бүтцийн хөрөнгө оруулалтын ажлуудын чиглэлээр Төсөл хэрэгжүүлэх Ховд, Увс, Баян-Өлгийн аймгийн төв, Увс аймгийн Өмнөговь сум, Баян-Өлгий аймгийн Дэлүүн суманд хийх ажлуудыг хянах, сум, орон нутгийн удирдлагуудатай хэлэлцэж санал авах, “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтад хяналт тавих зөвлөх үйлчилгээ авах тендерийн ажлын даалгаврыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор бэлэн болгохоор ажиллаж байна.

Төслийн 2 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хэсэг болох Мал аж ахуй, бэлчээрийн менежментийг сайжруулах ажлын хүрээнд зарлах Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Цагаан алт хөдөлгөөнүүдийн зорилттой уялдуулан боловсруулсан бөгөөд шаардлагатай мэдээллүүдийг цуглуулах, санал солилцох зорилгоор 11 төрийн болон төрийн бус байгууллага, 11 олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөртэй албан уулзалт зохион байгуулж, төсөл хэрэгжих орон нутгуудад 2 удаа томилолтоор ажилласан ба 9 чуулга уулзалт, хэлэлцүүлэгт оролцсон. Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар АХБ-аар хянагдах шатандаа явж буй бөгөөд 2025 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн дотор зөвлөх үйлчилгээний тендерийг зарлахаар төлөвлөн ажиллаж байна.

Төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсэг болох санхүүгийн зуучлалын зээлийн хэсгийн хүрээнд Бүсийн ногоон, хүртээмжтэй хөдөө аж ахуйн бизнесийн сан (GIRAF)-г үүсгэн байгуулах шаардлагатай бөгөөд хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компаниар Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргуулан шинээр байгуулах тохиолдолд энэхүү компанийг төсөлд оролцогч тал болгохын тулд төслийн зээлдэгч Сангийн яамнаас АХБ-нд хүсэлт хүргүүлж, холбогдох зөвшөөрлүүдийг авч, төслийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсны үндсэн дээр хэрэгжүүлэх нөхцөл байдал үүсэж байгаа тул Эдийн засаг, хөгжлийн сайдаас 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 01/2591 тоот албан бичгийг Сангийн сайдад хүргүүлэн, уг албан тоотод төслийн 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд байгуулагдах хөрөнгө оруулалтын сангийн менежментийг хийх компаниар Хөгжлийн банкны “Ди би Эм ассет менежмент” ХХК-ийг сонгон оролцуулах, мөн АХБ-аас үл татгалзах зөвшөөрөл авах тухай хүсэлтийг хүргүүлсэн. Хүргүүлсэн албан тоотын дагуу Сангийн яамны холбогдох албан тушаалтантай уулзалт хийх, мэдээллээр хангах ажлуудыг хийж байна. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 3 санхүүгийн дундын зуучлалын хэрэгжилт, техникийн

дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор бэлэн болгохоор ажиллаж байна.

5. Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилчид холбогдох хурал, зөвөлгөөн, сургалтад оролцсон болон бусад асуудлын талаар:

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудыг чадавхжуулах ажлын хүрээнд Сангийн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газар, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан нийт 15 удаагийн сургалтанд хамрагдсан.

Тайлант хугацаанд Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж нийт 67 албан бичгийг холбогдох төрийн захиргааны болон хувийн хэвшлийн байгууллагуудад илгээсэн ба гаднаас 11 албан бичиг ирүүлснийг хянан шийдвэрлэсэн байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ-2

“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн 2025 оны Үйл ажиллагааны төлөвлөгөө, Худалдан авалтын болон Санхүүгийн төлөвлөгөөний тухай

2.1 Төслийн 2025 оны Үйл ажиллагааны төлөвлөгөө
2.2 Төслийн 2025 оны Худалдан авалтын төлөвлөгөө
2.3 Төслийн 2025 оны Санхүүгийн төлөвлөгөө

"АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"

2025 оны 01 дүгээр сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

№	ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУД	2025												Хариуцах байгууллага
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
	1. Төслийн ерөнхий менежмент, зохион байгуулалт													
1.1	Төслийн удирдах хороогоор батлагдсан 2025 оны үйл ажиллагааны, худалдан авах ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах													Нэгдсэн Төсөл хэрэгжүүлэх нэгж /НТХН/
1.2	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн батлагдсан бүтэц, орон тооны дагуу songon шалгаруулалтыг тухай бүр зохион байгуулж, төслийн нэгжийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллах													Эдийн засаг, хөгжлийн яам /ЭЗХЯ/, НТХН
1.3	Төслийн удирдах хорооноос өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлж ажиллах													НТХН
1.4	Сангийн яамны Удирдлагын мэдээллийн системд холбогдох мэдээллийг тухай бүр оруулах													НТХН
1.5	Төсөл, арга хэмжээний улирлын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ хийж тайлан боловсруулан холбогдох байгууллагад илгээх /Улирал тутам/													НТХН
1.6	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн НДШ, НӨАТ, зарцуулалтын мэдээ тайлан бэлтгэж, холбогдох байгууллагуудад хүргүүлэх													НТХН
1.7	Төслийн шилэн дансны мэдээллыг тухай бүр оруулах, тайлагнах													НТХН
1.8	Санхүүжүүлэгч байгууллага болон Засгийн газарт тайлан мэдээг тогтмол хүргүүлэх													НТХН
1.9	ЭЗХЯ, СЯ болон АХБ-аас зохион байгуулах сургалт, семинарт тухай бүр хамрагдах													НТХН
1.10	Хэрэгжүүлэгч байгууллага болон АХБ-с зохион байгуулах гадаад, дотоод томилолтод төслийн чиг үүргийн дагуу хамрагдаж ажиллах													НТХН
	2. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 1-ийн хэрэгжилтийг хангуулах													
2.1	“Төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг, бодлогыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээний ажил”-ын гүйцэтгэгчийг songon шалгаруулж, гэрээ байгуулах													ЭЗХЯ, НТХН
2.2	Төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн хөрөнгө оруулалтын ажлын ТЭЗҮ шинэчлэх ажлыг зохион байгуулах													НТХН, Зөвлөх баг
2.3	“Төслийн 1-р үе шатны нарийвчилсан зураг төсөл боловсруулах, хяналт хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний ажил”-ын Ажлын даалгаврыг шинэчилж дуусгах													НТХН
2.4	“Төслийн 1-р үе шатны нарийвчилсан зураг төсөл боловсруулах, хяналт хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний ажил”-ын гүйцэтгэгчийн songon шалгаруулалтыг эхлүүлэх, гэрээ байгуулах													ЭЗХЯ, НТХН
2.5	Төслийн 1 дүгээр бүрэлдэхүүн хэсгийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын Ажлын зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлэх													НТХН, Зөвлөх баг
2.6	Увс аймгийн Өмнөговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг songon шалгаруулж, гэрээ байгуулах, ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлэх													ЭЗХЯ, НТХН, Зөвлөх баг
2.7	Боловсруулж дууссан зураг төсөлд үндэслэн барилгын ажлын тендерийн баримт бичгийг бэлтгэж эхлэх													НТХН, Зөвлөх баг
2.8	Төслийн 2 дугаар үе шатны songогдсон байршилд ТЭЗҮ, Ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний Ажлын даалгаврыг боловсруулах													НТХН
2.9	Төслийн 2 дугаар үе шатны songогдсон байршилд ТЭЗҮ, Ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний songон шалгаруулалтыг эхлүүлэх													ЭЗХЯ, НТХН

2.1 ТӨСЛИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /ТӨСӨЛ/

"АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"

2025 оны 01 дүгээр сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

№	ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУД	2025												Хариуцах байгууллага
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
	3. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 2-ийн хэрэгжилтийг хангуулах													
3.1	Төслийн 2-р бүрэлдэхүүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлаж, гэрээ байгуулах													ЭЗХЯ, НТХН
3.2	Малчдыг зохион байгуулалтын бүтцэд оруулах талаар яриа таниулга, сургалт зохион байгуулах													НТХН, Зөвлөх баг, МБАНХ
3.3	Хариуцлагатай нүүдэлчин стандартыг хангасан БАХ, малчдын хоршоодыг баталгаажуулах ажлыг зохион байгуулах													НТХН, Зөвлөх баг, МБАНХ
3.4	БАХ, малчдын хоршоодод тоног төхөөрөмжийн болон ажлын байрны дэмжлэг үзүүлэх													НТХН, Зөвлөх баг, БАХ, хоршоод
3.5	Аймаг, сумдын агро-бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, өртгийн сүлжээг хөгжүүлэх													НТХН, Зөвлөх баг, Аймаг, сумын ЗДТГ
3.6	Олон нийтэд суурилсан хөрөнгө оруулалтын төсөл боловсруулах арга зүйг малчдад заах, төслүүдийг эцэслэн боловсруулах													НТХН, Зөвлөх баг
3.7	Бэлчээр ашиглах гэрээ, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах арга хэмжээ зохион байгуулах													НТХН, Зөвлөх баг, Аймаг, сумын ЗДТГ
3.8	Бэлчээрийн даацад нийцүүлэн малын тоо толгойг бууруулах чиглэлийн арга хэмжээ зохион байгуулах													НТХН, Зөвлөх баг, ХХААХҮЯ
3.9	Бэлчээрийн төлөв байдал, өөрчлөлтийг фото мониторинг, зайнаас тандах судлах болон бусад аргаар үнэлэх, судлах чадавхыг хөгжүүлэх													НТХН, ГЗБГЗЗЕГ, ЦУОШГ
3.10	ХАА-н салбарын хүлэмжийн хийн ялгарал, CO2-ын шингээлтийн чиглэлээр сургалт, уулзалт, хэлэлцүүлэгт оролцох													НТХН, Зөвлөх баг, АХБ
3.11	Мал эмнэлэг, үржил селекц, сайн дурын ажилтнуудын чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох													НТХН, Зөвлөх баг, ХХААХҮЯ, МЭЕГ
3.12	Малын гаралтай бүтээгдэхүүний мөшгөх тогтолцоо, гэрчилгээжүүлэх ажлын хүрээнд програм хангамж, тоног төхөөрөмжийн хэрэгцээг тодорхойлох, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, оролцох													НТХН, Зөвлөх баг, ХХААХҮЯ, МЭЕГ
3.13	Хамгаалагдсан аж ахуй (хорио, цээрийн байгууламж) байгуулах зураг, төсвийг эцэслэн боловсруулах													НТХН, Зөвлөх баг, ХХААХҮЯ, МЭЕГ
3.14	Мал эмнэлэгийн лаборатори, хорио цээрийн тоног төхөөрөмжийн худалдан авалт хийх													НТХН, Аймгийн Мал эмнэлэг, ХАА-н газар
3.15	Услалтын систем байгуулах байршлуудыг эцэслэн сонгож, зураг, төсвийг эцэслэн боловсруулах													НТХН, Зөвлөх баг, Амгийн ЗДТГ
3.16	Малын тэжээл тариалах, хадлангийн талбай байгуулах чиглэлээр сургалт, яриа таниулга, хэлэлцүүлэг зохион байгуулах													НТХН, Зөвлөх баг, ХХААХҮЯ

"АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"

2025 оны 01 дүгээр сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

№	ТӨЛӨВЛӨСӨН АЖЛУУД	2025												Хариуцах байгууллага
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
	4. Төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын хэрэгжилтийг хангуулах													
4.1	Бүсийн ногоон, хүртээмжтэй ХАА-н бизнесийн сан (GIRAF)-г үүсгэн байгуулах Хөрөнгө оруулалтын менежментийн компанийг тодорхойлон, уг асуудлыг Сангийн яаманд уламжлан, Азийн хөгжлийн банкнаас "Үл татгалзах" тухай зөвшөөрөл авах													НТХН, ЭЗХЯ
4.2	Төслийн бүрэлдэхүүн хэсэг 3 санхүүгийн дундын зуучлалын хэрэгжилт, техникийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж дуусгах													НТХН, Тендерийн үнэлгээний хороо
4.3	Төслийн бүрэлдэхүүн хэсэг 3 санхүүгийн дундын зуучлалын хэрэгжилт, техникийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах, гэрээ байгуулж ажлыг эхлүүлэх													НТХН, Тендерийн үнэлгээний хороо, ЭЗХЯ
4.4	Санг байгуулахад шаардагдах баримт бичгүүдийг бэлтгэх. Үүнд: Сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын хөтөлбөр, бизнес төлөвлөгөө, дотоод хяналтын бодлого, орлого, зардлын бүртгэл, эрсдлийн удирдлага гэх мэт													НТХН, Зөвлөх баг
4.5	Бүсийн ногоон, хүртээмжтэй ХАА-н бизнесийн сан (GIRAF)-г үүсгэн байгуулах хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд гаргах													НТХН, Зөвлөх баг, ЭЗХЯ
4.6	Сангийн зээлийг дамжуулах олгох шаардлага хангасан арилжааны банкуудыг сонгох, жагсаалт гаргах судалгаа хийх, бэлтгэл ажил хангах													НТХН, Зөвлөх баг
4.7	Төсөлд оролцогч талуудын ажилтнуудын чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөө гаргах, сургалт зохион байгуулах													НТХН, Зөвлөх баг
4.9	Сангийн бодлого, үйл ажиллагааны талаарх журам зааврыг арилжааны банк, гэрчилгээтэй хоршоод сурталчлан танилцуулах													НТХН, Зөвлөх баг
4.10	Шаардлагатай тайлан, судалгаа, мэдээллийг бэлтгэн СЯ, ЭЗХЯ, АХБ-д хүргүүлэх.													НТХН, Зөвлөх баг
4.11	Бүсийн ногоон, хүртээмжтэй ХАА-н бизнесийн сан (GIRAF)-гийн бүтэцэд байгуулдаг зээлийн цонх-1, 2 болон туршилтын 3 дугаар цонхыг байгуулах бэлтгэл ажлыг хангах													НТХН, Зөвлөх баг
4.12	Төсөлд оролцогч санхүүгийн байгууллагуудын зээлийн эрсдэлийг бууруулах болон санхүүжилтийн схемийн хүрээнд боловсруулан гаргах барьцаа орлох хэрэгслийг хүлээн зөвшөөрүүлэх зориулалтаар зээлийн батлан даалтын механизм хэрэгжүүлэх ажлын бэлтгэлийг хангах													НТХН, Зөвлөх баг
4.13	Хөдөө аж ахуйн ногоон бизнес санаачлагыг дэмжих инновацын тэтгэлэг олгох ажлын бэлтгэлийг хангах													НТХН, Зөвлөх баг

НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ

2.2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН 2025 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Маягт 1

№	Тендер шалгаруулалт-ын код	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр	Нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Багц дугаар	Нийт төсөвт өртөг (USD доллар)	Нийт төсөвт өртөг (MNT)	Тухайн онд санхүүжих дүн	Тендер шалгаруулалтын арга	Тендер шалгаруулалт зарлах сар	Тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур үзүүлэлт тавьсан эсэх	Тайлбар, тодруулга
1	2	3	4	5	6		7	8	9	10	11
			ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ								
1	DDS1	АХБ-ны зөвл	"Нарийвчилсан зураг төсөл, барилга угсралтад хяналт тавих" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	DDS1	7,035,395.00	24,062,809,748.75	14,451,474,599.84	АХБ-ны худалдан авах ажиллагааны журмын дагуу Олон улсын нээлттэй тендер /АХБ-ОУНТШ/	2025-02	-	Төслийн I үе шатны ажил (Detailed design and supervision for tranche 1)
2	PIO1	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	"Төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг бодлогыг сайжруулах " зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	PIO1	4,346,000.00	14,864,406,500.00	9,656,814,987.30	АХБ-ОУНТШ	2024-12	-	Үйл ажиллагаа 1: "Аймаг, сумын төвүүдийн дэд бүтцийг байгуулах" (Project implementation and management support and policy improvement)
3	PIO2	АХБ-ны хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламж	"Үр дүн 2-ын төслийн хэрэгжилтийн техникийн туслалцаа" (үүнд бэлчээрийн менежмент,усжуулалтын систем,малын үржил,мал эмнэлгийн үйлчилгээ,гэрчилгээжүүлэлтийн дэмжлэг бодлогыг дэмжих)зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	PIO2	8,450,472.00	28,902,726,858.00	7,428,384,031.41	АХБ-ОУНТШ	2025-02	-	Үйл ажиллагаа 2: "Бэлчээрийн менежментийг сайжруулах" (Project implementation technical assistance for output 2 including rangeland management irrigation scheme, animal breeding and veterinary services, traceability and certification)
4	PIO3	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	"Үр дүн 2-ын төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг" (ногоон ХАА-н бизнест зориулсан санхүүгийн зуучлалын зээл) зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах	PIO3	3,000,000.00	10,260,750,000.00	2,995,115,648.59	АХБ-ОУНТШ	2025-02	-	Үйл ажиллагаа 3: "Агро-Бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, ногоон ХАА-н бизнес зээл" (Project implementation and management support for output 3 financial intermediation loan for green agribusiness)
5		АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Увс аймгийн Өмнөговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах.		150,000.00	513,037,500.00	513,037,500.00	АХБ-ОУНТШ	2025-08		
6	BPCE	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Баян-Өлгий аймгийн бэлчээр ашиглагчдын хэсэг ба хоршоодод тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	BPCE	394,080	1,347,852,120.00		RFQ	2025-08		2025.Q4
7	BPCF	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Баян-Өлгий аймгийн бэлчээр ашиглагчдын хэсэг ба хоршоодын ажлын байрны асуудалд дэмжлэг үзүүлэх	BPCF	259,149	886,354,367.25		RFQ	2025-08		2025.Q4
8	KPCE	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Ховд аймгийн бэлчээр ашиглагчдын хэсэг ба хоршоодод тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	KPCE	265,688	908,719,382.00		RFQ	2025-08		2025.Q4
9	KPCF	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Ховд аймгийн бэлчээр ашиглагчдын хэсэг ба хоршоодын ажлын байрны асуудалд дэмжлэг үзүүлэх	KPCF	184,440	630,830,910.00		RFQ	2025-08		2025.Q4
10	UPCE	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Увс аймгийн бэлчээр ашиглагчдын хэсэг ба хоршоодод тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлэх	UPCE	336,488	1,150,873,082.00		RFQ	2025-08		2025.Q4
11	UPCF	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Увс аймгийн бэлчээр ашиглагчдын хэсэг ба хоршоодын ажлын байрны асуудалд дэмжлэг үзүүлэх	UPCF	221,794	758,590,928.50		RFQ	2025-08		2025.Q4
12	ALVE	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Мал эмнэлэг, хорио цээрийн тоног төхөөрөмж нийлүүлэх	ALVE	823,012	2,814,906,793.00		OCB	2025-08		2026Q1

НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ХУДАЛДАН											
13	POF02	АХБ-ны хөнгөлөлттэй зээл	Оффисын тавилга			158,046,800.00	158,046,800.00	Харьцуулалтын тендер шалгаруулалт /ХА/	2025-02	-	Сангийн сайдын шинэчлэн баталсан бүтцийн дагуу Улаанбаатар хотын оффист хэрэглэгдэнэ.
14	POE02		Компьютер, тоног төхөөрөмж			238,217,882.00	238,217,882.00	ХА	2025-02	-	Сангийн сайдын шинэчлэн баталсан бүтцийн дагуу Улаанбаатар хотын оффист хэрэглэгдэнэ.
15	VEH03		Мини автобус			280,000,000.00	280,000,000.00		2025-02	-	ТХН-ийн үйл ажиллагаанд хэрэглэнэ.
16	VEH04		Автомашин			359,695,573.60	359,695,573.60	ХА	2025-02	-	ТХН-ийн үйл ажиллагаанд хэрэглэнэ.
			Дүн				**36,080,787,022.74**				
			Ам.долларын ханшийг 2024 оны 12-р сарын 31-ны өдрийн Монгол банкны албан ханшаар тооцов. /MNT/	3,420.25	-						
					НЭГДСЭН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ						

2.3. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн удирдах хорооны 2025 оны 01 дүгээр сарын .....-ны
өдрийн ..... дугаар тогтоолын ..... хавсралт

"АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"
ТӨСЛИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зардлын нэр	Гэрээний огноо	Тайлант онд санхүүжих дүн	I улирал	II улирал	III улирал	IV улирал
Урсгал зардал:		**39,503,032,832.74**	**1,095,709,616.00**	**3,717,292,403.58**	**9,538,568,434.79**	**26,187,422,633.98**
Зөвлөх үйлчилгээ		**35,365,696,327.14**	**48,130,434.00**	**2,247,938,579.98**	**8,729,208,184.79**	**24,340,419,128.38**
Төслийн I үе шатны нарийвчилсан зураг төсөл боловсруулах, барилга угсралтын хяналт тавих зөвлөх үйлчилгээ (Багцын дугаар: DDS1, Төсөвт өртөг: 7,035,395.00 ам.доллар)		14,451,474,599.84		2,167,721,189.98	3,612,868,649.96	8,670,884,759.90
Үйл ажиллагаа 1 : "Аймаг, сумын төвүүдийн дэд бүтцийг бий болгох" ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэх, менежментийн бодлогыг дэмжих зөвлөх үйлчилгээ (Багцын дугаар: PIO1, Төсөвт өртөг: 4,346,000.00 ам.доллар)		9,656,814,987.30			2,414,203,746.83	7,242,611,240.48
Үйл ажиллагаа 2: "Бэлчээрийн менежментийг сайжруулах" ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх зөвлөх үйлчилгээ (Багцын дугаар: PIO2, Төсөвт өртөг: 8,450,472.00 ам.доллар)		7,428,384,031.41			1,857,096,007.85	5,571,288,023.56
Үйл ажиллагаа 3: "Агро-Бизнес эрхлэгчдэд бага хүүтэй, ногоон ХАА-н бизнес зээл" ажлын хүрээнд төслийн хэрэгжилт, менежментийн дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ (Багцын дугаар: PIO3, Төсөвт өртөг: 3,000,000.00 ам.доллар)		2,995,115,648.59			748,778,912.15	2,246,336,736.44
Увс аймгийн Өмнөговь сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах		513,037,500.00				513,037,500.00
Худалдан авах ажиллагааны хувь зөвлөх (CS06)	2024.11.29	75,097,176.00	11,264,576.40	18,774,294.00	22,529,152.80	22,529,152.80
Бодлогын хувь зөвлөх (CS07)	2024.11.29	122,886,192.00	18,432,928.80	30,721,548.00	36,865,857.60	36,865,857.60
Засаглал менежментэд дэмжлэг үзүүлэх хувь зөвлөх (CS08)	2024.11.29	122,886,192.00	18,432,928.80	30,721,548.00	36,865,857.60	36,865,857.60
Төслийн үйл ажиллагаа		**4,137,336,505.60**	**1,047,579,182.00**	**1,469,353,823.60**	**809,360,250.00**	**1,847,003,505.60**
Төслийн үйл ажиллагааны зардал		3,101,376,250.00	651,314,500.00	829,658,250.00	809,360,250.00	811,043,250.00
Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн оффисын тавилга, тоног төхөөрөмж		396,264,682.00	396,264,682.00			396,264,682.00
Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн тээврийн хэрэгсэл		639,695,573.60		639,695,573.60		639,695,573.60
НИЙТ ДҮН		**39,503,032,832.74**	**1,095,709,616.00**	**3,717,292,403.58**	**9,538,568,434.79**	**26,187,422,633.98**

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ-3

Хөтөлбөрийн 2 болон 3 дугаар үе шатны төслийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай

Хөтөлбөрийн 2 болон 3 дугаар үе шатны төслийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай

Төслийн 2 дугаар үе шатны санхүүжилт баталгаажих асуудал АХБ-ны системд 2026 оны 4 дүгээр улиралд хийгдэхээр туссан болно. Энэ хүрээнд 2025 оны 1 дүгээр улиралд багтаан төслийн 2 дугаар үе шат хэрэгжих аймгийн байршлыг шийдвэрлэх шаардлага тулгарч байна. Ингэснээр цаашлаад 2025 онд багтаан ТЭЗҮ, Ажлын зураг төсөл боловсруулах зөвлөхийг сонгон шалгаруулах, 2026 оны 4 дүгээр улирлаас өмнө төслийн 2 дугаар үе шатны зээлийн гэрээ байгуулахад шаардлагатай баримт бичгийг боловсруулах нөхцөл бүрдэнэ.

“Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” (ASDIP)-ийн Үе шат 2 (Т2) ба Үе шат 3 (Т3)-д аймгуудыг сонгох шалгуур үзүүлэлтүүд нь төслийн баримт бичигт тодорхой дурдагдсан байдаг.

Аймгуудыг сонгох шалгуур үзүүлэлтүүд:

1. Хөдөө аж ахуйн тэргүүлэх байршлууд:
    - Аймгуудыг хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, нийлүүлэлт, ложистикийн кластеруудын байршлаар сонгоно. Эдгээр кластеруудыг Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ)-аас тодорхойлсон бөгөөд хөдөө аж ахуйн үнэ цэнийн сүлжээг сайжруулахад чиглэгдэнэ.

2. Хөтөлбөрийн зорилго, чиглэлд нийцэх байдал:
    - Аймгууд нь ногоон бүс нутгийн хөгжлийн загварт нийцсэн байх шаардлагатай. Үүнд:
        - Уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой хот-хөдөөгийн харилцааг дэмжих.
        - Нүүрстөрөгчийн бага ялгаралтай, уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн үнэ цэнийн сүлжээ (LCLVC)-г хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх орно.

3. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд:
    - Аймгуудыг дараах үндсэн үзүүлэлтүүдээр үнэлнэ:
        - Нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин: Дэд бүтэц, ногоон хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хамгийн их хүртэх боломжтой аймгуудыг сонгоно.
        - Хотын зэрэглэл: Бүс нутгийн болон улсын хотын сүлжээнд чухал ач холбогдолтой аймгуудыг дэмжинэ.

4. Байгаль орчин, уур амьсгалын нөхцөл:
    - Уур амьсгалын өөрчлөлтөд өртөх магадлал өндөртэй, бэлчээрийн доройтол ихтэй, ногоон бүс нутагт шаардлагатай арга хэмжээг авахад тохиромжтой аймгуудыг сонгоно.

5. Мал аж ахуй, хөдөө аж ахуйн бизнес хөгжүүлэх боломж:
    - Мал аж ахуйн үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх боломжтой, эсвэл боловсруулах үйлдвэрийн дэд бүтэц, агро-индустриал парк-уудыг төлөвлөсөн эсвэл одоо байгаа байршлуудыг сонгоно.

6. Одоогийн хэрэгжиж буй хөтөлбөрүүдтэй уялдаа:

- Ye шат 2 болон 3-д сонгогдох аймгууд нь Азийн хөгжлийн банк (АХБ), НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ) болон бусад байгууллагын хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдтэй нийцсэн байх шаардлагатай. Ингэснээр төслийн 1-р үе шатны хүрээнд хийгдсэн хөрөнгө оруулалтууд дээр тулгуурлах боломжийг олгоно.

7. Газар зүйн болон стратегийн өргөтгөл:
    - Ye шат 3 нь хөтөлбөрийн ногоон бүс нутгийн хөгжлийн загварыг өргөжүүлэхэд чиглэгдэнэ. Ye шат 1 ба Ye шат 2-ийн туршлага, үр дүн дээр үндэслэн илүү өргөн газар нутгийг хамруулах зорилготой.

Ye шат 2, Ye шат 3-д хамрагдах боломжит аймгуудын жагсаалт:

Хөтөлбөрт нийт 17 аймаг хамрагдах боломжтой гэж үзсэн. Үүнд:

- Ховд, Увс, Баян-Өлгий: Ye шат 1-д хамрагдаж байгаа.
- Архангай, Дорнод, Төв, Хэнтий, Булган, Сэлэнгэ, Дундговь, Дархан-Уул, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Дорноговь, Говь-Алтай: Ye шат 2 болон Ye шат 3-д хамрагдах боломжтой гэж тодорхойлсон.

4. ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД

“АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ИЙН ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

_____оны___сарын___ Дугаар:.... Улаанбаатар хот

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайлангийн тухай

Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.10.8.3, , 7.10.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗӨВЛӨМЖ БОЛГОХ нь:

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Аймаг сумын бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2024 оны жилийн үйл ажиллагааны тайлан, худалдан авах ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан болон хяналт, шинжилгээ үнэлгээний тайлантай танилцсаны үндсэн дээр төслийн ажлыг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, төсөл, арга хэмжээ тус бүрийг батлагдсан төлөвлөгөөний дагуу шуурхай зохион байгуулахыг Төслийн захирал /Ж.Өнөржаргал/, Төслийн зохицуулагч /Н.Тэгшбаяр/ нарт тус тус зөвлөсүгэй.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ДАРГА И.БАТХҮҮ

“АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ИЙН ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ТОГТООЛ

_____оны___сарын___ Дугаар:.... Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.10.8.2, 7.10.16 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, санхүүгийн төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төслийн хэрэгжилтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу үр дүнтэй хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах, төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төслийн захирал /Ж.Өнөржаргал /-д, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төслийн зохицуулагч /Н.Тэгшбаяр/-т тус тус үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ДАРГА И.БАТХҮҮ

“АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ИЙН ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

_____оны___сарын___ Дугаар:.... Улаанбаатар хот

Хөлсөөр ажиллах гэрээг сунгах тухай

Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.10.8.3, 7.10.8.4, 8.11, 8.12 болон 8.17 дахь заалтууд, Төслийн удирдах хорооны 2024 оны …. сарын …. өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗӨВЛӨМЖ БОЛГОХ нь**:**

1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын хөлсөөр ажиллах гэрээний биелэлтээр “хангалттай болон бүрэн хангалттай” гэж үнэлэгдсэн ажилтнуудын Хөлсөөр ажиллах гэрээг сунгах саналыг төсөл хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх, гэрээний хугацаа дуусгавар болж байгаа ажилтнуудын сул орон тоог нөхөх ажлыг шуурхай зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэх нэгжийн тогтвортой үйл ажиллагааг хангахыг Төслийн захирал /Ж.Өнөржаргал/ болон Төслийн зохицуулагч /Н.Тэгшбаяр/ нарт зөвлөмж болгов.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ДАРГА И.БАТХҮҮ

“АЙМАГ СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР”-ИЙН ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ЗӨВЛӨМЖ

_____оны___сарын___ Дугаар:.... Улаанбаатар хот

Хөтөлбөрийн 2 болон 3 дугаар үе шатны төслийн бэлтгэл ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай

Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.10.1, 7.10.8.6 заалтуудыг тус тус үндэслэн ЗӨВЛӨМЖ БОЛГОХ нь**:**

1. **“**Аймаг сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн 2 болон 3 дугаар үе шатны төслийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Засгийн газрын холбогдох бодлогын баримт бичиг, Төслийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр болон бусад холбогдох баримт бичигтэй уялдуулан төсөл хэрэгжих аймгуудыг тогтоож, Төслийн удирдах хороонд 2025 оны 1 дүгээр улиралд багтаан танилцуулж, шийдвэрлүүлэхийг Төсөл хэрэгжүүлэх нэгж /Н.Тэгшбаяр/-д даалгасугай.

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА БӨГӨӨД
ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ДАРГА И.БАТХҮҮ